Australian Aid

AMEP
Australia Mongolia Extractives Program

# ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, ОРОН НУТАГТАЙ ХАМТРАХ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

## Эцсийн тайлан

2023/03/15



## Тайланг хүлээлгэн өгсөн байдал:

| | |
|---|---|
| Илгээсэн огноо | 15/03/2023 |
| Хэнд | Адам Смит Интернэйшнл |
| Гарын үсэг | |
| Хэнээс | Лхагвагийн Цэлмэгсайхан<br>(“IRIM судалгааны хүрээлэн”-гийн Гүйцэтгэх захирал) |

## Эцсийн тайланг хүлээн авалцсан баримт:

| | |
|---|---|
| Эцсийн тайланг хүлээлгэн өгсөн | |
| Илгээсэн огноо | |
| Илгээгч | |
| Хүлээн авагч | |
| Гарын үсэг | |
| Батлав | |
| Гарын үсэг | |
| Огноо | |

**Мэдэгдэл**

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Түүнчлэн энэхүү тайлангийн агуулгыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа хэрэг биш бөгөөд мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг ч батлахгүй. Тайланд багтсан тоо баримт, мэдээ материал алдаа дутагдалтай байхыг үгүйсгэхгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэ тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

**Хөтөлбөр хэрэгжүүлэгч**

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2)-ийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэйшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.

**Талархал**

Энэхүү тайланг боловсруулахад хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. АМЕП 2 хөтөлбөрийн багаас “Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутагтай хамтрах хүрээнд хийгдсэн ажлуудын үнэлгээ” тайланд санал өгч, идэвхтэй хамтран ажилласанд талархал илэрхийлье. Мөн үнэлгээний бүхий л үе шатанд үнэ цэнэтэй зөвлөмж, удирдамж өгч ажилласан Рена Гүэндүэз, П. Оюунбилэг, зохион байгуулалтын асуудал дээр хамтран ажиллаж, тухай бүрт дэмжлэг үзүүлж байсан У. Бүжинлхам нарт талархал илэрхийлж байна.

Уг тайлан Та бүхэнд үнэ цэнэтэй, чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгнө гэдэгт найдаж байна. Монголын олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоо, нөлөөллийн үйл ажиллагаа, тэдгээрийн ололт амжилт дээр бидний хамтын ажиллагаа цаашид ч амжилттай үргэлжилнэ гэдэгт итгэж байна.

.

# Зохиогчид

**Пүрэвжавын Болормаа, Багийн ахлагч**

П. Болормаа нь Гриффит их сургуулийн Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй. Тэрбээр орон нутагт олон талт зөвлөл байгуулах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг сумын түвшинд боловсруулах, төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хүний эрхэд суурилсан хандлага, жендерийн эрх тэгш байдлыг хангах, бичил уурхайгаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийх аргачлал боловсруулах чиглэлээр олон улсын хөгжлийн мэргэжилтнээр 15 жил ажилласан туршлагатай. НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Монгол Улсын Засгийн газрын төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж байсан. Одоогоор Бритиш Колумбийн их сургуулийн Төрийн бодлого, гадаад хэргийн сургуулийн Азийн судалгааны институтийн гишүүн, Уул уурхайн инженерчлэлийн тэнхимд докторын зэрэг горилж байна. Судалгааны чиглэл: усны менежмент, уул уурхайн бүс нутаг дахь усны нэгдсэн менежмент, усны засаглал, талуудын оролцоо, хамтын ажиллагаа, тогтвортой хөгжил. Англи, Монгол, Орос, Чех хэлтэй. Канад, Монгол, Киргизстан, Этиоп, Чех улсуудад ажиллаж байсан туршлагатай.

**Цэгмидийн Чимэддондог, Мэдээлэл харилцааны зөвлөх**

Ц. Чимэддондог МУИС, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг тус тус дүүргэсэн, сэтгүүл зүйн магистр. Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийг үүсгэн байгуулагч, редактор юм. МҮОНРТ-д сэтгүүлчээр ажлын гараагаа эхэлж, Монголын Хэвлэлийн хүрээлэнд сэтгүүл зүйн сургагч багшаар ажиллахдаа олон арван сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, олон зуун сэтгүүлчдэд мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлсэн туршлагатай. 2015-2017 онд ХБНГУ-ын DW Академийн хөтөлбөрөөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургагч багшаар бэлтгэгдсэн. Тэрбээр сэтгүүлчийн ёс зүйн асуудлаар судалгаа, сургалт явуулдаг бөгөөд Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийг үүсгэн байгуулагчдын нэг юм. Өдгөө Ёс зүйн хорооны орлогч даргаар ажиллаж байна. Монгол улс болон Дани улсын Орхусын их сургуулийн хамтарсан орчин цагийн сэтгүүл зүйн хөтөлбөр болон Австрали, Швед, Америк, бусад орны мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийн судалгаа, Орчин цагийн сэтгүүл зүйн үндэс, Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн судалгаа, аргачлал, Сэтгүүлчийн ёс зүй зэрэг сэдвээр сургалт зохион байгуулдаг. Үүнээс гадна олон нийтийн мэдээлэл харилцааны салбарт, тэр дундаа Хямралын харилцааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ, сургалтыг 2022 оноос ХБНГУ-ын DW Академийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна. Тэрбээр эдийн засаг, уул уурхайн салбар дахь эрэн сурвалжлах сэтгүүл зүй, мэдээлэл харилцааны чиглэлээр олон удаагийн хөтөлбөрт хамтран ажиллаж байсан туршлагатай,Бодлогод залуусын хяналт ТББ-ын сургагч багш, Эмнести Интернэшнл төвийн Хүний эрхийг хамгаалагчдын хорооны гишүүн юм.

**Даваашаравын Мөнхчимэг, Мэдээлэл харилцааны ахлах судлаач**

Д. Мөнхчимэг Хэвлэл мэдээллийн хараат бус зөвлөх, сэтгүүлч мэргэжилтэй. Монголын хэвлэл мэдээллийн салбарт жендерийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран сэтгүүлчид, редакцуудыг чадавхжуулах чиглэлээр ажилладаг. Мөнхчимэг "Жендерийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүйн удирдамж" болон "Улс төрийн мэдээллийн агуулгад жендерийн тэгш байдлыг хангах нь" сэдэвт редакцуудад зориулсан гарын авлагыг сүүлд хэвлүүлжээ. Тэрбээр 2008 онд өдөр тутмын “Өнөөдөр” сонинд эдийн засаг, уул уурхайн сэтгүүлчээр ажлын гараагаа эхэлсэн бөгөөд түүнээс хойш Монголын олон нэр хүндтэй хэвлэл болон олон улсын Reuters, NYT, The Guardian зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүтээлээ нийтлүүлж байв. Мөнхчимэг ОХУ-ын Ивановогийн улсын их сургуулийг сэтгүүлч мэргэжлээр, Латви улсын Рига хотын Стокхольмын Эдийн засгийн сургуулийг хэвлэл мэдээллийн менежментийн чиглэлээр төгссөн.

**Лхагвагийн Цэлмэгсайхан, Гүйцэтгэх захирал**

Л.Цэлмэгсайхан нь Монгол Улсын их сургуулийг социологич мэргэжлээр төгссөн, магистрын зэрэгтэй, Австрали улсын Мельбурнын Их сургуульд Хөгжил судлалын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр IRIM Судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирлын алба хашдаг ба Монгол, Төв, Зүүн өмнөд Азийн орнуудад хөгжлийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцогч талуудад хэрэгцээт хөгжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэн удирдаж ирсэн. Л. Цэлмэгсайхан нь байгалийн нөөцийн менежмент дэх талуудын оролцоо, олборлох салбарын нийгэм, жендерийн асуудал, хот, хөдөөгийн өөрчлөлт зэрэг сэдвээр судалгааны ажлуудад түлхүү оролцож ирсэн. Хараат бус судалгаа, нотолгоо, үр дүнтэй талуудын оролцоог хөгжүүлэх замаар бодлого, хөтөлбөрийн боловсруулалтад хувь нэмэр оруулахыг эрмэлзэн ажилладаг. Монгол, Англи хэлтэй. Монгол, Австрали, Зүүн Тимор улсуудад ажиллаж байсан туршлагатай.

**Энхтүвшингийн Оюундэлгэр, Төслийн зохицуулагч**

2017 онд Байгаль орчны бодлогын чиглэлээр Австралийн Үндэсний их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Байгаль орчин, ногоон хөгжил, уул уурхай дахь иргэдийн оролцооны чиглэлийн судалгаа, нөлөөллийн төслүүдэд ажиллаж байсан. Тэр дундаа, НҮБ-ын Хүнс хөдөө ахуйн байгууллагын “Хамтын оролцооны ойн менежмент”-ийн төсөлд ажиллаж, орон нутгийн иргэдэд суурилсан байгаль орчны менежментийн чиглэлээр туршлагажсан.

**Батдоржийн Халиунбат, Судлаач**

Монгол Улсын Их Сургууль, Бакалаврын зэрэгтэй, 2012. Судалгааны чиглэл: Байгаль орчин, эрдэс баялгийн салбарын судалгаа, талбарын мэдээлэл цуглуулалт, чанарын болон тоон судалгааны аргууд.

**Найдансүрэнгийн Нандинцэцэг, Судлаач**

Монгол Улсын Их Сургууль, Бакалаврын зэрэгтэй, 2020
Судалгааны чиглэл: Байгаль орчин, нийгмийн судалгаа, талбарын мэдээлэл цуглуулалт, чанарын болон тоон судалгааны аргууд.

# Агуулга

Зохиогчид .... 4
Агуулга .... 6
Товчилсон үгсийн жагсаалт .... 8
Хүснэгт, зургийн жагсаалт .... 9
Хураангуй .... 10
Нэр томьёоны тайлбар .... 12
1 Оршил .... 14
2 Судалгааны арга зүй .... 16
3 Судалгааны явц .... 18
3.1 Хоёрдогч мэдээлэл цуглуулах, танилцах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх явц .... 18
3.1.1 Судлагдсан байдлыг системтэй үнэлэх явц .... 18
3.1.2 Уул уурхайн компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээ .... 19
3.1.3 Уул уурхайн сэдвээр хэвлэгддэг сонинуудын контент дүн шинжилгээний явц .... 20
3.1.4 Ойлголт, санаа бодлын судалгааг шинжлэх явц .... 21
3.1.5 Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагыг шинжлэх явц 22
3.1.6 Уул уурхайн онцлох үйл явдлын мэдээнүүдийг тоймлох явц .... 23
3.1.7 Анхдагч мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх явц .... 23
4 Судалгааны үр дүн .... 25
4.1 Судалгааны үр дүнгийн хураангуй .... 25
4.2 Судлагдсан байдлын тойм .... 30
4.3 Компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээний үр дүн .... 36
4.4 Уул уурхайн сонины контент дүн шинжилгээний үр дүн .... 41
4.5 Олон нийтийн санаа бодол, ойлголтын судалгаануудад хийсэн дүн шинжилгээ .... 44
4.6 Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагад хийсэн дүн шинжилгээ .... 45
4.7 Уул уурхайн онцлох үйл явдлын талаарх мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ .... 47
4.8 Анхдагч мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ .... 48
1.8.1 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх ажлуудын үр дүн .... 49
4.8.2 Олон нийтийн ойлголт хандлага, холбогдох эрсдэлүүд .... 49
4.8.3 Олон нийтийн оролцоо, мэдээлэл харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлс .... 50
4.8.4 Сумын түвшинд хамгийн түгээмэл хэрэглэгддэг мэдээлэл харилцааны хэлбэрүүд 53
4.8.5 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх сайн туршлага .... 53
4.8.6 Судалгаанд хамрагдсан орон нутгийн нөхцөл байдал .... 54
5 Зөрүүний шинжилгээ .... 57
3.1 Олон нийтийн оролцоог хангах, хамтран ажиллах .... 57
3.2 Уул уурхайн компаниудын орон нутгийн удирдлага болон иргэдтэй хамтран ажиллах арга зам .... 58
6 Дүгнэлт .... 60

7 Санал зөвлөмж ... 61
7.1 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх стратегийн ерөнхий санал зөвлөмжүүд 61
7.2 Оролцогч талуудад чиглэсэн зөвлөмжүүд ... 62
Хавсралтууд ... 65
Хавсралт 1 Чанарын судалгаанд оролцогч талууд ... 65
Хавсралт 2 Судлагдсан байдлын тойм: PICOC дүн шинжилгээ. Монголын туршлага ... 68
Хавсралт 3 Судлагдсан байдлын тойм: PICOC дүн шинжилгээ. Олон улсын туршлага ... 77
Хавсралт 4 Ярилцлагуудад хийгдсэн шинжилгээний хүснэгт ... 84
Хавсралт 4.1 Салбарын мэргэжилтнүүд ... 84
Хавсралт 4.2 Орон нутгийн удирдлага ... 91
Хавсралт 4.3 Орон нутгийн иргэд ... 93
Хавсралт 4.4 Засгийн газар ... 95
Хавсралт 4.5 Уул уурхайн компанийн төлөөлөл ... 97
Хавсралт 5 Компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээ ... 99
Хавсралт 6 Судалгааны дүн шинжилгээний загвар ... 124
Ашигласан материалуудын жагсаалт ... 125

# Товчилсон үгсийн жагсаалт

| | |
|---|---|
| АМГТГ | Ашигт малтмал, газрын тосны газар |
| АМЕП | Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БОНБҮ | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ |
| БОННҮ | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ |
| ГХО | Гадаадын хөрөнгө оруулалт |
| ГЯ | Ганцаарчилсан ярилцлага |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| КНХ | Компанийн нийгмийн хариуцлага |
| ОНХАГ | Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ |
| ОУСК | Олон улсын санхүүгийн корпораци |
| ОҮИТБС | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга |
| СҮА | Судалгааны үндсэн асуулт |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УУХҮЯ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| ФБЯ | Фокус бүлгийн ярилцлага |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

# Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны аргуудын тодорхойлолтууд ........ 16
Хүснэгт 2. Дүн шинжилгээ хийсэн хоёрдогч мэдээлэл ........ 18
Хүснэгт 3. Цахим хуудасны контент дүн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд ........ 20
Хүснэгт 4. Сонины түүвэр ........ 21
Хүснэгт 5. Судалгааны ярилцлагууд........ 24
Хүснэгт 6 Судалгааны үр дүнгийн хураангуй, мэдээллийн эх сурвалж тус бүрээр ........ 25
Хүснэгт 7. Тогтвортой байдлыг хангах хүчин зүйлс, талуудын үүрэг оролцоо. ........ 31
Хүснэгт 8. Ажиллаж буй цахим хуудастай компаниуд. ........ 36
Хүснэгт 9. Цахим хуудасны бүрэлдэхүүн хэсгүүд. ........ 36
Хүснэгт 10. Аймгуудын өрсөлдөх чадварын индекс. ........ 44

Зураг 1 Судалгааны загвар ........ 16
Зураг 2 Судлагдсан байдлыг системтэйгээр үнэлэх явц ........ 19

Шигтгээ 1 “Оюу Толгой” компанийн олон нийтийн оролцоог хангах ажлууд ........ 39
Шигтгээ 2 “Баян Айраг Эксплорэйшн” компанийн орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээсэн байдал ........ 39
Шигтгээ 3 ОҮИТБС-ын санаачилгаар орон нутгийн засаг захиргаа мэдээллээ ил тод болгосон нь ........ 41
Шигтгээ 4 Хулд сумын онцлог ........ 55
Шигтгээ 5 Бүрэгхангай сумын онцлог ........ 55

# Хураангуй

Австрали-Монголын Эрдэс баялгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2) нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор хэрэгжиж байна. Энэ хүрээнд оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах, тэр дундаа иргэд, олон нийтийн оролцоог дэмжих замаар эрдэс баялгийн салбарын бодлого, бүтцийн орчныг сайжруулахаар зорьж байна.

Иргэдийн итгэлцэл, хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд эрдэс баялгийн салбарт харилцаа, хамтын ажиллагааны бодлого, дүрэм журмыг шинэчлэх, шинэлэг арга замуудыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага үүсээд байгаа. Тиймээс олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутагтай хамтран ажиллах чиглэлээр Монголын олборлох үйлдвэрлэлийн салбарт өмнө нь хийсэн болон одоо хэрэгжүүлж буй ажлуудын үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлж, сайжруулах арга замуудыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг IRIM судалгааны хүрээлэн (IRIM) хийж гүйцэтгэв.

Судалгааны баг а) 221 эрдэм шинжилгээний өгүүлэл, (үүнээс 16 өгүүлэлд дүн шинжилгээ хийсэн), б) Монголд үйл ажиллагаа явуулж буй 63 уул уурхайн компаниудын цахим хуудсууд (үүнээс 29 цахим хуудсанд дүн шинжилгээ хийсэн), в) уул уурхайн салбарын мэдээ, мэдээллээр дагнасан 2 сонины 10 дугаар, г) Монголын уул уурхай, байгаль орчин, хөгжлийн ойлголт, санаа бодлын судалгааны 4 тайлан, д) уул уурхайн салбарын ил тод байдал, өрсөлдөх чадвар, байгаль орчны 8 илтгэл тайлан, е) төсөл хөтөлбөрүүдээс гаргасан орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах 9 гарын авлага зэрэг эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд судалгааны баг гол оролцогч талуудтай 17 удаа ганцаарчилсан, орон нутгийн иргэдтэй 2 удаа фокус бүлгийн ярилцлагууд зохион байгууллаа.

Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутаг дахь хамтын ажиллагааны чиглэлээр өмнө нь хийсэн болон одоо хэрэгжиж буй ажлуудын үр дүн, тогтвортой байдал хангалттай бус хэдий ч олон нийтийн оролцоог хангах нь иргэдийн ойлголт, идэвхтэй оролцоо, тодорхой хүчин чармайлт, хугацаа шаарддаг гэдгийг оролцогч талууд илүү ойлгосон байгааг судалгааны үр дүн харууллаа.

Энэ нь ганц удаагийн эсвэл бие даасан хэд хэдэн салангид үйл ажиллагаа бус харин орон нутгийн иргэд бодитоор оролцсоноор үр шим хүртэх үйл явц бөгөөд нээлттэй, ил тод байдал, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, улмаар итгэлцлийг бий болгох, оролцогч талууд мэдээлэл солилцох, харилцаа холбоог хөгжүүлэх үйл явц юм.

Судалгаанаас харахад компанийн танилцуулгаас эхлээд хайгуул, газар зохион байгуулалт, олборлолт, ашиглалт, нөхөн сэргээлтийн тухай гэх мэт орон нутгийн иргэдэд зориулсан хэвлэмэл мэдээлэл бэлтгэж түгээх нь туйлын хангалтгүй байна.

Дийлэнх уул уурхайн компани[1] менежментийн бодлогодоо орон нутгийн иргэдийн хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагын хөтөлбөр, зохицуулалтыг тусгаагүй байна. Цөөн хэд нь л орон нутгийн иргэдтэй харилцаа, хамтын ажиллагааны сайн туршлага, урт хугацааны түншлэлийг тогтоосон, иргэдийн оролцоо, нийгмийн хариуцлагын бодлого боловсруулсан байна.

Судалгаагаар өнөөгийн хамтын ажиллагаа, мэдээлэл түгээх арга барил, туршлага төдийлөн үр

[1] Монголд уул уурхайн том, дунд, жижиг хэмжээний компаниуд үйл ажиллагаагаа явуулдаг. Өмчлөл, засаглалын хувьд төрийн өмчит, хувьцаат, хувийн, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гэх мэт.

дүнтэй, тогтвортой биш байгаа шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлүүдийг нарийвчлан шинжилж, үр дүнг тус тайланд тусгалаа.

Судалгааны үр дүнг товч дүгнэвэл уул уурхайн салбарын талаарх иргэдийн ойлголт, хандлага ерөнхийдөө сөрөг байна.[2] Энэхүү сөрөг ойлголт, хандлага нь уул уурхайн компаниудад итгэх олон нийтийн итгэл сулрахад нөлөөлжээ. Уул уурхайн компаниудын байгаль орчны дүрэм журмыг хэрхэн даган мөрдөж байгаа эсвэл мөрдөхгүй байгаагаас хамааран тухайн орон нутгийн иргэдийн итгэлцлийн түвшин харилцан адилгүй байна.

Харин уул уурхайн компаниуд орон нутагт (эс) хүлээн зөвшөөрөгдөх, компанийн нэр хүндийн асуудал хөндөгдөх, улс төрийн нөлөөлөл зэрэг бизнесийн олон сорилттой нүүр тулж байгааг судалгааны үр дүн харууллаа.

Орон нутгийн түвшинд үр дүнтэй хэрэгжиж буй сайн туршлага, тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судалгаагаар тодорхойлоход: хамтын ажиллагаа, түншлэл, итгэлцлийг бий болгох, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, орон нутагт тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, харилцаа холбоо тогтоох зэрэг туршлагууд багтсан болно.

Мэдээлэл харилцаа, биечилсэн уулзалтууд, иргэдэд нэн хэрэгцээтэй мэдээллүүд[3] нээлттэй бус, хүртээмжгүй байгаа нь  олон нийтийн оролцоо, орон нутгийн хамтын ажиллагааг бий болгоход хамгийн ихээр үгүйлэгдэж байна. Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо сул, тухайлбал хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгох болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд орон нутгийн иргэдийн оролцоо хязгаарлагдмал зэрэг нь энэ салбарт оршиж буй хангагдаагүй хэрэгцээ гэж үзэж байна. Үүнээс улбаалан, компани болон орон нутгийн удирдлага хооронд байгуулдаг хамтын ажиллагааны гэрээнд иргэдийн оролцоо дутмаг, гэрээний хэрэгжилт ил тод биш байдал нь иргэдийн хэрэгцээ бүрэн хангагдаагүй гэж үзэх үндэслэл юм. Уул уурхайн нөлөөллийн талаарх иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч тусгах нь ч хангалтгүй байна. Энэ нь тэдний хувьд бас нэг төрлийн хангагдаагүй хэрэгцээ бөгөөд уул уурхайн компаниудад үл итгэх байдлыг бий болгосоор байгаа юм.

Тиймээс байгууллага, хувь хүмүүс хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах, мэдээлэл түгээх сувгуудыг нэмэгдүүлэх, үнэн, зөв, шинэчилсэн, найдвартай мэдээллийг иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн хүргэхэд анхаарах хэрэгтэй байна.

Судалгааны үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж болон судалгааны зохион байгуулалтын зэрэг нарийвчилсан бусад мэдээлэлтэй тайлангийн холбогдох хэсгээс танилцана уу.

---

[2] Нутгийн  иргэд, малчид өөрийн амьдарч буй газар нутаг, бэлчээр доройтож байгааг харах нь уул уул уурхайн бүтээн байгуулалтад болгоомжтой хандахад хүргэж байна.
[3] Мэдээллийн хэрэгцээ нь нөхцөл байдлаас хамаарч ялгаатай байх боловч малчид, нутгийн иргэдэд усны нөөц, хүртээмжтэй холбоотой тодорхой мэдээлэл, ажлын байр, уул уурхайн компаниудын хандив, санхүүжилтийн зарцуулалт болон орон нутгийн хамтын ажиллагааны гэрээтэй холбоотой мэдээллүүдийг ил тод болгох хэрэгцээ, шаардлага өндөр байна.

# Нэр томьёоны тайлбар

| № | Нэр томьёо | Тайлбар, үндсэн ойлголтууд |
|---|---|---|
| 1 | Албан гомдол мэдүүлэлт | Хувь хүн эсвэл олон нийтийн бүлэг тулгамдсан асуудал, саад бэрхшээл, санаа зовсон асуудлын талаар компани, гэрээ байгуулагчдад санал хүсэлт, шаардлага хүргүүлэн, шийдвэр хүсэх үйл явц. |
| 2 | Анхдагч мэдээлэл | Судалгаанд ашиглах зорилгоор анх удаа цуглуулж, олж авсан мэдээллийг хэлэх бөгөөд энэ төрлийн мэдээллийг судалгааны асуудлын талаар гүнзгий ойлгож мэдэх, хариулт шийдэл олох зорилгоор судлаач өөрийн биеэр асуумж, ярилцлага, туршлага судлах зэрэг тодорхой аргачлалаар цуглуулдаг. |
| 3 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ) | Аливаа төслийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлох үйл явц. |
| 4 | Дэд зөвлөл | Орон нутгийн Засаг захиргаа, компани, нутгийн иргэдийн оролцоотойгоор уул уурхайн ил тод байдлыг ард иргэдэд мэдээлэх, хариуцлагатай уурхайг бий болгох зорилго бүхий орон нутаг дахь хамтын үйл ажиллагааны бүтэц. |
| 5 | Ил тод байдал | Аливаа мэдээлэлд цаг алдалгүй, найдвартай, саадгүй нэвтрэх боломж. |
| 6 | Иргэний нийгмийн байгууллага /ИНБ/ | Хүний эрх, байгаль орчин, хөдөлмөрийн стандарт, авлигын эсрэг нийтлэг үнэт зүйлсийг бий болгохын төлөө төр, хувийн хэвшил хоорондын сул орон зайг нөхөж ажилладаг институт. Эдийн засгийн үйл ажиллагааг нийгэм, байгаль орчны тэргүүлэх чиглэлтэй уялдуулахад тэдний үүрэг онцгой ач холбогдолтой болсон. Хуулийн нэр томьёо нь төрийн бус байгууллага (ТББ). |
| 7 | Иргэдийн оролцоог хангах | Газарзүй, ашиг сонирхол болон нийгмийн нөхцөл байдлын хувьд нийтлэг бүлэг хүмүүстэй тэдний сайн сайхан байдалд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллах үйл явц. |
| 8 | Компанийн нийгмийн хариуцлага | Аж ахуйн нэгжүүд бизнесийн үйл ажиллагаандаа хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээ, олон улсын стандартыг мөрдөж ажиллахыг хэлнэ. Энэ нь корпорацын бүтэц, үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг бөгөөд нийгэм, байгаль орчны сорилтод шинэлэг, идэвхтэй шийдлүүдийг бий болгох, нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг сайжруулахын тулд дотоод болон гадаад оролцогч талуудтай хамтран ажиллах зэрэг нь нийгмийн хариуцлагад хамаарна. |
| 9 | Олборлох үйлдвэрлэл | Газрын тос, байгалийн хий, ил ба далд  уурхайн салбарууд хамаардаг. |
| 10 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) | Газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөцийн нээлттэй, хариуцлагатай ашиглалтыг бий болгоход чиглэсэн дэлхий нийтийн стандарт. |
| 11 | ОҮИТБС-ын Тайлан | ОҮИТБС-ын стандартыг хэрэгжүүлэгч улс орнууд тухайн орныхоо байгалийн баялгаас олсон орлого болон олборлолтын талаарх мэдээлэл бүхий ОҮИТБС-ын тайлан гаргах ёстой/үүрэг хүлээсэн байдаг. |
| 12 | Орон нутгийн иргэд | Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа газар нутагт болон зэргэлдээх орон нутагт байнга оршин сууж буй иргэд. |
| 13 | Оролцогч тал | Аливаа төсөл, санаачилга, бодлого,байгууллагын нөлөөлөлд эерэг эсвэл сөрөг байдлаар өртсөн, өртөж болох талууд (иргэд, бүлэг г.м.) |
| 14 | Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ | Гэрээний талуудын хувьд гэрээнд тусгасан заавал биелүүлэх үүрэг хүлээж, хэрэгжилтийг хангах зорилготой уул уурхайн компани ба орон нутгийн удирдлага хооронд байгуулсан гэрээ. |
| 15 | Санаа бодол | Мэдээлэл, туршлага, мэдлэг, мэдрэхүйд тулгуурлан аливаа зүйлийн талаар ойлгох, дүгнэлт хийх чадвар. |
| 16 | Судлагдсан байдал | Тухайн сэдвийн хүрээнд цугларсан мэдлэг, туршлагыг системтэй ойлгож авч, судалгаа шинжилгээнд ашиглахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тухайн сэдвийн хүрээнд цугларсан сүүлийн үеийн мэдлэг, туршлагыг хайн цуглуулж, тодорхой шалгуурын дагуу судалгааны асуултад хариулт өгөхөд хамгийн тохиромжтой мэдээллийг сонгож авч, дүн шинжилгээ хийн нэгтгэх явц. |

| | | |
|---|---|---|
| 17 | Төрийн өмчит компани | Төрийн өмнөөс арилжааны үйл ажиллагаанд оролцох зорилгоор засгийн газраас байгуулсан хуулийн этгээд. |
| 18 | Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл | Компанийн үйл ажиллагааг нийгэм болон орон нутгийн иргэд өргөнөөр хүлээн зөвшөөрөх. Энэ нь төрөөс эсвэл хуулиар олгогдсон бизнес эрхлэх зөвшөөрлөөс тусдаа ойлголт юм. Энэ зөвшөөрөлгүй бол бизнест нь ноцтой саатал, зардал гарах өндөр эрсдэлтэй. |
| 19 | Холбоо | Нийтлэг ашиг сонирхол бүхий байгууллагуудын гишүүнчлэл бүхий нэгдэл. Энэхүү судалгаанд олборлох үйлдвэрлэлийн салбарт хариуцлагатай уул уурхайг дэмжих зэрэг тодорхой зорилгын дагуу нэгдэн үйл ажиллагаа явуулдаг холбоодыг авч үзсэн. Тухайлбал, Уул уурхайн үндэсний ассоциаци. |
| 20 | Хоёрдогч мэдээлэл | Хоёрдогч мэдээлэл нь өөр байгууллага, этгээдийн өөрсдийн тодорхой зорилгын хүрээнд боловсруулж гаргасан бэлэн мэдээллийг хэлнэ. Энэ төрлийн мэдээллийг төрийн байгууллагын тайлан эмхэтгэл, тооллого, байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлт, ном, сэтгүүл, цахим хуудас, төрөл бүрийн тайлан зэрэг олон төрлийн эх сурвалжаас олж авах боломжтой. |

# 1 Оршил

## 1.1. Үндэслэл

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж буй, хөгжлийн тулгуур салбаруудын нэг юм. Тухайлбал, 2010-2021 оны хооронд уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 23 %-ийг эзэлж байв.[4] Энэ салбар дангаараа нийт ажиллах хүчний ~3.6 орчим хувь, улсын төсвийн >20 гаруй хувь, экспортын ~90 гаруй хувийг бүрдүүлж байна (Баатарзориг, Галиндэв, Мэйсоннэйв, 2018).

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) олон нийтийн оролцоонд суурилсан үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, талуудын үүрэг оролцоог илүү тодорхой болгох, иргэд санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатайг онцолж байна. Сүүлийн жилүүдэд хуучин тогтолцоонд тулгуурласан мэдээлэл харилцаа, олон нийттэй харилцах арга зам нь иргэдийн оролцоог хангаж, тэдний санал бодлыг тусгахад хангалттай үр дүнтэй бус болох нь харагдсан бөгөөд үүний улмаас олон нийтийн итгэл суларч, салбарын нэр хүндэд нөлөөлөхөд хүрч байна.[5]

АМЕП 2 хөтөлбөрөөс санаачилсан “Эрдэс баялгийн салбарын үнэ цэнийг нэмэгдүүлэх нь” төсөл нь орон нутгийн иргэд, малчид, төрийн бус байгууллагууд, залуу үеийнхэнд мэдлэг туршлагаа шинэлэг арга замаар, мэдээлэл харилцааны хэрэгслээр хуваалцах боломж олгоход чиглэнэ. Энэхүү санаачилга нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй ба эхний хэсэг болох судалгааны ажлыг IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэв.

Судалгааг (1) Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоог хангах ажлууд, бодлогын орчныг үнэлэх (2) орон нутгийн нөхцөл байдалд тохирсон шинэлэг мэдээлэл харилцааны стратеги боловсруулах чиглэлээр явуулав.

## 1.2. Судалгааны зорилго

Уг судалгаа нь Монгол дахь олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутгийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр сүүлийн 5 жилийн хугацаанд хийсэн ажлуудын үр нөлөө, тогтвортой байдлыг үнэлж, сайжруулах арга замуудыг тодорхойлох зорилготой. Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Олон нийтийн оролцоог хангах чиглэлээр хийсэн болон хийж буй ажлууд, мэдээлэл түгээх зорилгоор гаргасан материалууд, мэдээлэл солилцох арга замууд хэр үр дүнтэй байсныг үнэлэх;
2. Олборлох үйлдвэрлэлийн салбарын тухай олон нийтийн ойлголт хандлагыг судлах;
3. Хангагдаагүй хэрэгцээг тодорхойлох (зөрүүний шинжилгээ хийх замаар);
4. Олон нийтийн оролцоог хангах, орон нутагтай хамтран ажиллахад хамгийн үр дүнтэй бөгөөд шинэлэг мэдээлэл харилцааны арга замууд бүхий зөвлөмж боловсруулах.

## 1.3. Төслийн удирдлага, зохион байгуулалт

Дээрх судалгааг АМЕП 2 хөтөлбөрийн хүсэлтээр IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэсэн болно. IRIM судалгааны хүрээлэн нь уг судалгааны ажлыг гүйцэтгэх зорилгоор зөвлөхүүд болон

[4] Эдийн засгийн төрөлжилтийг хэмжих нь, ҮСХ, ЭЗХЯ, НҮБХХ, 2022
[5] AMEP2, RfP, 2022

судлаачдаас бүрдсэн үндсэн багийг бүрдүүлж удирдлагын болон талбарын судалгааны багууд үндсэн багт дэмжлэг үзүүлэн ажилласан болно. Судалгааны баг АМЕП 2 багийнхантай зөвлөлдөх уулзалтуудыг хийж санал хүсэлтийг тусгаснаас гадна судалгааны үндсэн баг долоо хоног бүр зөвлөлдөх уулзалт хийж, ИРИМ судалгааны хүрээлэнгийн удирдлагатай цахим уулзалт болон и-мэйлээр харилцаж удирдлага, арга зүйн чиглэл өгч ажилласан. Судалгаанд аль болох олон талын үзэл бодлыг оруулах үүднээс үндэсний болон орон нутгийн түвшинд төрөл бүрийн оролцогч талуудын төлөөллийг хамруулсан ярилцлага, мэдээлэл цуглуулалтын ажил зохион байгууллаа. Судалгааны ажлыг 2022 оны 12-р сарын 07-ноос 2023 оны 3-р сарын 10-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

# 2 Судалгааны арга зүй

Судалгааны ерөнхий арга зүй нь Монгол дахь олборлох үйлдвэрлэлийн салбарт сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн болон одоо хийгдэж буй олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлуудыг баримт нотолгоонд үндэслэн, нарийвчлан үнэлэхэд чиглэсэн.

Сонгогдсон судалгааны аргууд дээр үндэслэн Судалгааны үндсэн асуулт (СҮА)-уудыг тодорхойлон гаргасан. Үүнд:

> ***СҮА1****. Монголын олборлох үйлдвэрлэлийн салбарт өмнө нь хийгдсэн болон одоо хийгдэж буй олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, мэдээлэл түгээх ажлууд хэр үр дүнтэй бөгөөд тогтвортой байв?*
>
> ***СҮА2.*** *Олборлох салбарын тухай иргэдийн ойлголт ямар байна вэ? Хэрхэн хувьсан өөрчлөгдөж ирсэн бэ? Өнгөрсөн хугацаанд иргэдийн энэхүү ойлголт, хандлага нь олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлж ирсэн бэ? Олон нийтийн оролцоо, орон нутгийн харилцаа, хамтын ажиллагаа өөрчлөгдөж буйгаас шалтгаалсан ямар эрсдэлүүдтэй (нэр хүнд, улс төр, нийгэм, эдийн засгийн) компаниуд тулгарч байна вэ?*
>
> ***СҮА3****. Дээрх асуудлуудын хүрээнд орхигдуулсан хэрэгцээ юу байв? Мэдээлэл оролцоог хангах, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд юу дутагдаж байв?*

Энэхүү үнэлгээ нь олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг бий болгох чиглэлд оролцогч талуудын ойлголтыг илүү сайн ойлгох үүднээс харилцан зөвлөлдөх хандлагыг баримталсан.

Судалгааны анхдагч ба хоёрдогч мэдээлэлд тулгуурлан олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоо, олон нийтэд хэрхэн хүрч, хамтран ажилласан ажлын үр нөлөөг үнэлэхийн тулд судлагдсан байдлыг системтэй үнэлэх, чанарын ярилцлагууд, зөрүүний шинжилгээг хийх аргуудыг ашигласан.

*Зураг 1 Судалгааны дизайн*




Судалгааны арга тус бүрийг Хүснэгт 1-т харуулав.

*Хүснэгт 1. Судалгааны аргуудын тодорхойлолтууд*

| Судалгааны аргууд | Тодорхойлолт |
|---|---|
| Судлагдсан байдлыг системтэй үнэлэх арга<br><br>(СҮА1, СҮА2) | Судлагдсан байдлыг системтэй үнэлэх энэ аргыг 2018-2022 онд уул уурхай, геологийн салбарт олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй ажлуудыг хайж, тохиромжтойг нь сонгоход ашигласан. Энэ нь “геологи, уул уурхайн тухай ойлголт, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа”-ны талаар өргөн хүрээнд, гүнзгий ойлголт авахад чиглэсэн. Судалгааны ажлуудыг сонгох, уншиж танилцах, дүн шинжилгээ хийж, нэгтгэх замаар дүгнэлт, санал зөвлөмж боловсруулсан ба тусгаж авах асуудлуудыг анхдагч мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх явцад ашигласан. |

| | |
|---|---|
| Чанарын ярилцлагууд<br><br>(СҮА1, СҮА2, СҮА3) | Чанарын судалгааны ярилцлагууд нь сүүлийн 5 жилд хийгдсэн олон нийтэд чиглэсэн ажлуудын мэдээллийн тухай оролцогч талуудын туршлага, үзэл бодол, байр суур, шинэлэг санааг ойлгож мэдэхэд чиглэнэ. Үүний хүрээнд ганцаарчилсан ярилцлага болон фокус бүлгийн ярилцлагуудыг зохион байгуулсан. Судалгааны үе шатанд нөхцөл байдлыг тодорхойлохоор хийгдсэн чанарын ярилцлагууд нь олон нийтийн оролцооны төлөвлөлтийн цаашдын ажлуудад чухал ач холбогдолтой юм. |
| Зөрүүний шинжилгээ<br><br>(СҮА1, СҮА2, СҮА3) | Судлагдсан байдлын тойм болон ганцаарчилсан ярилцлагуудын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн **зорилтот түвшин болон бодит байдлыг харьцуулан зөрүүний шинжилгээг** гаргасан. Үүгээр судалгааны үр дүнгээс хангалттай гарч ирээгүй олон нийтийн оролцоог хангах үр дүнтэй бөгөөд тогтвортой арга замуудыг тодорхойлохыг зорьсон. |

**Анхдагч мэдээлэл**[6] нь ганцаарчилсан ярилцлага, Фокус бүлгийн ярилцлага, талбарын ажиглалтаас бүрдэнэ. Чанарын судалгааны контент дүн шинжилгээнд үндэслэн анхдагч мэдээллийг боловсруулсан.

**Хоёрдогч мэдээлэл**[7] нь эх сурвалжийн хувьд холбогдох эрдэм шинжилгээний өгүүллүүд, сэтгүүл, уул уурхайн компаниудын цахим хуудас, байгууллагуудын судалгааны ажлууд, сонин, голлох үйл явдлын мэдээ, олон нийтийн санаа бодлын судалгаануудад тулгуурласан.

Дээрх хоёрдогч мэдээлэл болон мэдээлэл сурталчилгааны материалуудад судлагдсан байдлын тойм, контент дүн шинжилгээ хийхдээ сүүлийн 5 жилийн хугацаанд хамаарах монгол болон англи хэл дээрх эх сурвалжуудыг хамруулан хайлт хийж, тохирох материалуудыг сонгон дүн шинжилгээ хийсэн. Судалгааны гол сэдэв, үндсэн асуултууд, тэдгээртэй уялдах дүн шинжилгээний асуудлууд, тус бүрийн хариултыг мэдээллийн ямар эх сурвалжаас хайсан дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6 Судалгааны дүн шинжилгээний загвар-0Хавсралт 6 Судалгааны дүн шинжилгээний загвараас харна уу.

[6] Судалгаанд ашиглах зорилгоор анх удаа цуглуулж, олж авсан мэдээллийг хэлэх бөгөөд энэхүү төрлийн мэдээллийг судалгааны асуудлын талаар гүнзгий ойлгож мэдэх, хариулт шийдэл олох зорилгоор судлаач өөрийн биеэр асуумж, ярилцлага, туршлага судлах зэрэг тодорхой аргачлалаар цуглуулдаг.
[7] Хоёрдогч мэдээлэл нь өөр байгууллага, этгээдийн өөрсдийн гэсэн тодорхой зорилгын хүрээнд боловсруулж гаргасан бэлэн мэдээллийг хэлнэ. Энэ төрлийн мэдээллийг төрийн байгууллагын тайлан эмхэтгэл, тооллого, байгууллагын албан бичиг хэрэг хөтлөлт, ном, сэтгүүл, цахим хуудас, төрөл бүрийн тайлан зэрэг олон эх төрлийн эх үүсвэрээс олж авах боломжтой.

# 3 Судалгааны явц

Энэхүү судалгааны ажлын хүрээнд эхний ээлжинд хоёрдогч мэдээллийг (1-р хэсэг) цуглуулж, дараа нь анхдагч мэдээлэл цуглуулах (2-р хэсэг), тэдгээрт дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэлээ.

## 3.1 Хоёрдогч мэдээлэл цуглуулах, танилцах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх явц

Хоёрдогч мэдээллийг 2022 оны 12 дугаар сарын 19-нөөс 2023 оны 2 дугаар сарын 5-ны хооронд цуглуулсан. Энэ хүрээнд СҮА1 болон СҮА2-той холбогдох эрдэм шинжилгээний өгүүлэл, тайлан, цахим хуудас, сонин зэрэг хоёрдогч мэдээллийг олох, тодорхой шалгуурын дагуу шүүж хамгийн их хамаарал холбоотойг нь сонгох, уншиж танилцах, дүн шинжилгээ хийж, нэгтгэх ажлууд хийсэн. Нийт 73 мэдээлэлтэй танилцаж, дүн шинжилгээ хийснийг Хүснэгт 2-т харууллаа.

*Хүснэгт 2. Дүн шинжилгээ хийсэн хоёрдогч мэдээлэл*

| # | Мэдээллийн төрөл | Тоо |
|---|---|---|
| 1 | “Web of Science” болон “Scopus” мэдээллийн баазаас сонгож, судлагдсан байдлыг системтэйгээр үнэлэхэд ашигласан эрдэм шинжилгээний өгүүллүүд | 16 |
| 2 | Уул уурхайн компаниудын цахим хуудас, тэдгээрийн агуулгад тоон болон чанарын аргаар хийсэн дүн шинжилгээ | 29 |
| 3 | Уул уурхайн чиглэлээр хэвлэгддэг сонинууд (“Ил тод орон нутаг”, “Эрдэс баялгийн тойм”) | 10 |
| 4 | Холбогдох олон нийтийн санаа бодлын судалгаанууд | 4 |
| 5 | Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагууд | 8 |
| 6 | Эрдэс баялгийн салбарын голлох үйл явдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, мэдээлэл | 6 |
| **Нийт** | | **73** |

### 3.1.1 Судлагдсан байдлыг системтэй үнэлэх явц

Олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоо, оролцогч талуудын хамтын ажиллагаа, компанийн нийгмийн хариуцлага, уул уурхайн үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл зэрэг сэдвийн хүрээнд судлагдсан байдлыг системтэйгээр үнэлж, шинжлэх ухааны баримт нотолгоо цуглуулах ажил гүйцэтгэлээ. Дурдсан сэдвийн хүрээнд 2022 оны 12 дугаар сараас 2023 оны 1 дүгээр сарын хооронд “Web of Science” болон “Scopus” мэдээллийн сангаас эрдэм шинжилгээний өгүүллүүд хайсан. Эдгээр мэдээллийн сан нь шинжлэх ухааны голлох салбарууд, тэр дундаа салбар дундын судалгаануудыг багтаасан давуу талтай.

Хайлтад дараах түлхүүр үгүүдийг ашигласан: Үүнд: 1) “олон нийтийн оролцоо” (community engagement) ба “уул уурхай”, 2) “талуудын хамтын ажиллагаа” (stakeholders’ engagement) ба “уул уурхай”, 3) “компанийн нийгмийн хариуцлага” (corporate social responsibility) ба “уул уурхай”, 4) “(уул уурхайн) үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл” (social license to operate)” ба “уул уурхай” зэрэг болно.

Web of Science мэдээллийн баазаас нийт 296 өгүүлэл, Scopus мэдээллийн баазаас нийт 321 эрдэм шинжилгээний өгүүлэл олдсон. Хасах болон авч үлдэх тодорхой шалгууруудын дагуу шүүлт хийж, гол агуулгыг гаргаж авсны дараа 16 өгүүлэл шигшигдэн үлдэж, тэдгээрт дүн шинжилгээ хийлээ. Эдгээр 16 өгүүлэл судалгааны зорилго, үндсэн асуултуудтай шууд нийцсэн болно. Зураг 2-т судлагдсан байдлыг системтэй үнэлэх явцыг харууллаа.

*Зураг 2. Судлагдсан байдлыг системтэй үнэлэх явц*




Сонгогдсон 16 өгүүллэгт PICOC (Population-Хүн ам, Intervention-Арга хэмжээ, Comparison-Харьцуулалт, Outcome-Үр дүн, Context-Нөхцөл байдал) аргачлалын дагуу дүн шинжилгээ хийн үр дүнг дараах хавсралтуудад оруулсан. Үүнд:

- 0Хавсралт 2 Судлагдсан байдлын тойм: PICOC дүн шинжилгээ. Монголын туршлага.
- Хавсралт 3 Судлагдсан байдлын тойм: PICOC дүн шинжилгээ. Олон улсын туршлага.

### 3.1.2 Уул уурхайн компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээ

Энэхүү судалгааны явцад тодорхой тооны уул уурхайн компаниудыг сонгож, тэдгээрийн цахим хуудсанд орон нутгийн иргэдийн оролцоог хангах, тогтвортой/хариуцлагатай уул уурхайн сэдвээр гарсан мэдээлэл болон олон нийтэд мэдээлэл түгээхэд чиглэсэн монгол хэл дээрх материалын агуулгад тоон болон чанарын дүн шинжилгээ хийв. Судалгааны түүвэрт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын 2021 оны буюу 16-дугаар тайланд (Монголын ОҮИТБС, 2022) багтсан 63 компанийг хамруулан компаниудыг гурван ангилалд хувааж үзэв. Эдгээр нь:

1. Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ) -11
2. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалт

(ГХО)-тай хувийн компаниуд –21

3. Үндэсний хувийн компаниуд –31 зэрэг уурхайн амьдралын мөчлөгийн янз бүрийн үе шатанд үйл ажиллагаа явуулж буй том, дунд, жижиг хэмжээний компаниуд юм.

Компаниуд олон нийтийн оролцоог хангах тал дээр идэвхтэй, эсвэл бага идэвхтэй байх бөгөөд олон нийтийн санаа зовоосон асуудалд хариу үйлдэл үзүүлэх түвшин өөр өөр байна. Судалгааны хүрээнд хийсэн алхмуудын хураангуйг дор харуулав.

Уул уурхайн компаниудын цахим хуудсанд хайлт хийхдээ "нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжил, орон нутгийн хөгжил, олон нийтийн оролцоо, олон нийтийн арга хэмжээ, зөвлөгөөн" гэх мэт түлхүүр үгсийг монгол хэлээр ашиглалаа.

Контент дүн шинжилгээний судалгааг чиглүүлэхийн тулд

- Уул уурхайн компаниуд цахим хуудас идэвхтэй хөтөлж (шинэчилж) байна уу?
- ТӨҮГ, гадаадын болон ГХО-тай, үндэсний хувийн компаниуд цахим хуудсаараа мэдээлэл түгээх тал дээр ялгаатай байна уу?
- Эдгээр компани олон нийтийн оролцоо, орон нутгийн хөгжил, тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагыг чухалчилдаг уу?
- Уул уурхайн компаниудын цахим хуудасны хэрэглэгчдэд мэдээлэл өгөх/танилцуулахад зонхилох, эсхүл ховор хэрэглэгддэг харилцааны хэрэгсэл юу вэ?
- Компаниуд олон нийтийн оролцоо, орон нутгийн хөгжил, нийгмийн хариуцлагын талаар ямар мессеж хүргэж байна вэ? зэрэг багц асуултыг боловсруулсан.

Уул уурхайн компаниудын цахим хуудсыг санамсаргүй түүврийн аргаар сонгож танилцсаны дараа хэрэглэгчдэд мэдээлэл түгээх гол болон ховор харилцааны хэрэгслүүд, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжил, олон нийтийн оролцооны чиглэлээр хэрэглэгчдэд хүргэсэн гол мессежүүдийг тодорхойлохын тулд контент дүн шинжилгээний явцад ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдийн жагсаалт гарган Хүснэгт 3-т харуулав.

*Хүснэгт 3. Цахим хуудасны контент дүн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд*

| Цахим хуудасны судалгааны арга | Тоон үзүүлэлт | Чанарын үзүүлэлт |
|---|---|---|
| Түлхүүр үгс компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсэд байгаа | Тийм/Үгүй | Хэрэв "Тийм" бол мэдээллийг чанарын судалгаа хийхэд зориулж авна |
| Түлхүүр үгс цахим хуудасны нүүр хуудасны цэсэнд байгаа | Тийм/Үгүй | Хэрэв "Тийм" бол мэдээллийг чанарын судалгаа хийхэд зориулж авна |
| Компанийн жилийн тайлан/Компанийн нийгмийн хариуцлагын тайланг татаж авах боломжтой | Тийм/Үгүй | Хэрэв "Тийм" бол мэдээллийг чанарын судалгаа хийхэд зориулж авна |
| Мэдээлэл түгээх материалууд (мэдээ, видео, постер г.м.) байгаа | Тийм/Үгүй | Хэрэв "Тийм" бол мэдээллийг чанарын судалгаа хийхэд зориулж авна |
| Олон нийтийн нөлөөллийн кампанит ажил зарласан | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Орон нутгийн иргэдэд зориулсан үйл ажиллагаанууд зарласан | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Хэрэглэгчид сэтгэгдэл бичих боломжтой | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Түгээмэл асуулт хариултууд байгаа | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Санал хүсэлт, гомдол гаргах боломжтой | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Холбоо барих мэдээлэл байгаа | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |
| Цахим хуудсанд компанийн олон нийтийн сүлжээний хуудсыг холбосон | Тийм/Үгүй | Чанарын дүн шинжилгээнд ашиглахгүй |

### 3.1.3 Уул уурхайн сэдвээр хэвлэгддэг сонинуудын контент дүн шинжилгээний явц

"Ил тод орон нутаг," болон "Эрдэс баялгийн тойм" сониныг судалгааны хүрээнд ярилцлагад хамрагдсан хэвлэл мэдээлэл болон ОУИТБС-ын төлөөллүүд орон нутгийн иргэдэд

чиглэсэн уул уурхайн мэдээллийн эх сурвалж хэмээн зөвлөж, 2021-2023 онд гарсан дугааруудыг судалгааны багт өгсөн. Тэдгээртэй танилцаж, “Ил тод орон нутаг” сонины хоёр дугаар, “Эрдэс баялгийн тойм” сонины 2021 оны нэгдүгээр сараас 2022 оны арванхоёрдугаар сард гарсан найман дугаарыг түүвэрлэн авч дүн шинжилгээнд хамруулав (Хүснэгт 4).

*Хүснэгт 4. Сонины түүвэр*

| # | Сонин | Он | Хүлээн авсан нийт дугаар | Дүн шинжилгээ хийсэн дугаарын тоо | Судалгааны түүвэрт багтсан сарууд |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Ил тод орон нутаг” | 2022 | 2 | 2 | |
| 2 | “Эрдэс баялгийн тойм” | 2021 | 12 | 4 | 1, 4, 7, 10 дугаар сарууд |
| | | 2022 | 12 | 4 | 3, 6, 9, 12 дугаар сарууд |
| **Нийт** | | | **26** | **10** | |

Уул уурхайн нөлөөлөлд байгаа орон нутгийн иргэдийн үнэн бодит мэдээлэл авах санаачилгыг дэмжих, тэднийг тоо баримтад тулгуурласан, найдвартай мэдээллээр хангах зорилгоор ОҮИТБС-ын Ажлын албанаас 2022 онд "Ил тод орон нутаг" сонины хоёр дугаар гаргасан байна. Тус сонины анхны дугаарт Дорноговь аймгийн Даланжаргалан сумыг онцолж, "Хил хязгааргүй алхам" ТББ-аар дамжуулан 300 ширхгийг орон нутгийн иргэдэд түгээжээ. Хоёр дахь дугаар нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд гарсан бөгөөд тус сумын нутгийн зөвлөлийн санаачилгаар 1000 ширхгийг тараасан байна.

"Эрдэс баялгийн тойм" нь "Тогтвортой уул уурхай хөгжлийн гарц" уриан дор уул уурхайн салбарын мэдээ мэдээллийг"Түгээмэл шуудан", "Монгол шуудан"-гаар дамжуулан сар бүр 2000-5000 ширхэгийг олон нийтэд хүргэдэг, дижитал хувилбарыг цахим шуудан ба хуудсаараа дамжуулан 40 мянга гаруй хүний хүртээл болгодог сар тутмын сонин юм.

Гол оролцогч талууд болон судалгааны зорилтот сэдвүүдийг тодорхойлохын тулд сонины нийтлэлд контент дүн шинжилгээ хийн дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тоон болон чанарын мэдээллийг бүрдүүллээ. Үүнд:

1. Сонины нийтлэлийн булангууд, гол төрөл, жанрууд, тэдгээрийн агуулга
2. Мэдээллийн хамрах хүрээ (үндэсний хэмжээний эсвэл орон нутгийн мэдээлэл)
3. Нийтлэл мэдээллийн гол оролцогч эх сурвалжууд
4. Олон нийтийн оролцоо, орон нутгийн хөгжил, Компанийн нийгмийн хариуцлага (КНХ-ын талаарх булан, сэдэвчилсэн нийтлэл)
5. Олон нийтийн оролцооны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн нийтлэл мэдээлэл байвал жишээгээр оруулах.

### 3.1.4 Ойлголт, санаа бодлын судалгааг шинжлэх явц

Судалгааны эх сурвалжийг баяжуулахын тулд дараах уул уурхай, байгаль орчны холбогдолтой олон нийтийн ойлголт, санаа бодлын судалгаануудыг шүүсэн.

- Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, 2022
- Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлан, 2022
- Уул уурхай, усны менежментийн олон нийтийн санаа бодлын эцсийн шатны судалгаа, Олон улсын санхүүгийн корпораци (IFC), 2021
- Олон нийтийн санаа бодлын судалгаа: Монгол улсад оршин суугчид, Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн (IRI) болон IRIM судалгааны хүрээлэн, 2022

### 3.1.5 Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагыг шинжлэх явц[8]

Судалгааны дэвшүүлсэн асуудал, ерөнхий зорилттой холбоотой мэдээллээр хангах үүднээс нийт найман эх сурвалжийг хянаж судалгаандаа багтаасан. Эдгээр нь байгаль орчин, мэдээ мэдээллийн хүрэлцээ, хүртээмж, ил тод байдал, нийгмийн бүлэг, уул уурхайн эдийн засаг болон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөг харуулсан. Судалгааны үр дүнгийн чанарын хэсгийг нөхөх зорилгоор холбогдох мэдээллийг хамтад нь гаргаж авсан.

1. Монгол Улсын уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээний тайлан 2017/ Intergovernmental Forum (IGF): Mongolia Mining Policy Framework Assessment Report 2017
2. ЗГХФ уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээний тайлан (мон), 2017
3. Монгол Улсын 2018 оны тогтвортой байдлын төлөв/ Sustainability outlook of Mongolia, 2018)
4. Хариуцлагатай уул уурхайн индексийн тайлан, 2020 /Responsible Mining Index report, 2020)
5. IGF тохиолдлын судалгаа: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд зөвлөлдөх, оролцохын ач холбогдол, 2023 он /IGF Case study: The importance of Consultation and Engagement in Environmental and Social Impact Assessments, 2023)
6. Монгол Улсын Хэнтий, Дорнод аймгуудад хүний эрхийг хамгаалагч, байгаль орчинд үзүүлж буй уул уурхайн нөлөөллийн талаарх баримт, бодит байдлыг илрүүлэх ажлын тайлан, 2019 он. /Fact Finding Mission Report on the impacts of mining on defenders and environment in Khentii and Dornod provinces of Mongolia, 2019)
7. Коронавирусын халдварын (COVID-19) Монголын уул уурхайн салбарт үзүүлэх нөлөө, судалгааны үр дүнг танилцуулах нь, 2022 он /Impact of Coronavirus disease (COVID-19) on Mongolian Mining Sector, presentation of survey findings, 2022)
8. Уул уурхайн салбарын шийдвэр гаргалтад талуудын оролцооны мэдлэг, хандлага, дадлын үнэлгээний тайлан, 2017 он /Stakeholders’ participation assessment report on knowledge, attitudes and practices in mining decision-making, 2017)
9. Бие даасан тайлангийн механизм (IRM): Монгол Улсын шилжилтийн үр дүн (2019-2021) /Independent Reporting Mechanism (IRM): Mongolia Transitional Results (2019-2021)

Судалгааны баг олон улсын донор байгууллагын санхүүгийн тусламжтайгаар боловсруулсан гарын авлага, зөвлөмжүүдтэй танилцсан. Тус гарын авлага, зөвлөмжүүд нь талуудын оролцоо, газрын нөхөн сэргээлт, хүний эрх болон бизнесийн талаар тодорхой зааварчилгаа, үндсэн ойлголт, зарчмуудыг тоймлон харуулсан нь уул уурхайн компаниуд, бусад оролцогч талуудад үр дүнтэй оролцоог хангахад мэдлэг мэдээлэл, арга зүй, замуудыг танилцуулсан хэрэгтэй материалууд болохыг онцлон дурдаж байна. Үүнд:

- “Хариуцлагатай уул уурхай” сургалтын гарын авлага./Training Manual on Responsible Mining, United Nations Development Programme (UNDP) in Mongolia, 2019, Монгол дахь НҮБХХ.
- Уул уурхайн салбарын шийдвэр гаргалтад талуудын оролцооны мэдлэг, хандлага, дадлын үнэлгээний тайлан, 2016 он, Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилттэй Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF). /Assessment report on the of knowledge, attitudes and practices of stakeholders involved in mining decision-making, 2016, World Wild Fund (WWF) funded by European Union (EU).
- Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн гарын авлага, НҮБХХ-ийн санхүүжилттэй "Хил хязгааргүй алхам" (SWB), 2021 он. /Participatory Environmental Monitoring guide, Steps without borders” (SWB), funded by UNDP, 2021.

---

[8] Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлага гэдэг нь "Засгийн газар, эрдэмтэн судлаачид, бизнес, аж үйлдвэрийн бүх түвшинд арилжааны хэвлэлээр хянагддаггүй, хэвлэн гаргах нь тухайн байгууллага, хувь хүний үндсэн үйл ажиллагаа бус, цахим болон хэвлэмэл хэлбэрээр түгээгдсэн мэдээ мэдээллийг хэлнэ.

- Олон нийтийн оролцооны сайн туршлага 2016, Канадын ашигт малтмал, металлын салбар /Good community engagement practices 2016 Canada’s Minerals and Metals Sector
- Хүний эрхийн магадлан шинжилгээ сургалтын гарын авлага /Human Rights Due Diligence Training Facilitation guide (mon), 2021,
- Бичил уурхайн нөхөн сэргээлтийн гарын авлага, 2016. Азийн сан, Уул уурхайн яам (ММ), Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА) /Frugal Rehabilitation Methodology, Field Handbook, 2016. Asia Foundation, Ministry of Mining (MM), Swiss Agency for Development and Cooperation (SDC)
- Монголд хэрэгжүүлсэн бичил уурхайн нөхөн сэргээлтийн жишиг төслүүд, 2016. Азийн сан, ММ, ШХА /Frugal rehabilitation demonstration in Mongolia, 2016. Asia Foundation, MM, SDC
- Талуудын оролцоо, 2016. Азийн сан, ММ, ШХА /Stakeholders Engagement, 2016. Asia Foundation, MM, SDC
- Орон нутгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг бэлтгэх, хэлэлцээ хийх, хэрэгжилтийг хангах тухай дижитал гарын авлага, 2020 он, Нээлттэй нийгэм форум

/Digital manual on Preparing, Negotiating and Ensuring the Implementation of Local Cooperation Agreement, 2020, Open Society Forum

- Уул уурхайн амьдралын мөчлөг, 2016-2017, СЕСМИМ хөтөлбөр /Mine Life Cycle, 2016-2017, SESMIM Program
- Канад улсын Гадаад хэргийн яамнаас санхүүжүүлж буй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төслийн мэдлэгийн портал /MERIT Project knowledge portal http://portal.merit.mn/en/

### 3.1.6 Уул уурхайн онцлох үйл явдлын мэдээнүүдийг тоймлох явц

COVID-19-ийн хязгаарлалттай холбоотойгоор судалгааны хамрах хүрээний хугацаанд олон нийтийн арга хэмжээ тун ховор зохион байгуулагдсан. 2022 оны 9 дүгээр сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Оюу Толгой” компани хамтран Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулан "Уул уурхайн долоо хоног" арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү чуулганыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр уул уурхайн салбарын 100 жилийн түүхэн дэх хамгийн том үйл явдал гэж тодорхойлсон учир нь Монголд анх удаа эрдэс баялгийн салбарынхан долоо хоног чууллаа. Төр, иргэний нийгмийн байгууллагууд, гадаад, дотоодын компаниуд, хөрөнгө оруулагчид, орон нутгийн удирдлагууд, нутгийн иргэд, малчдын төлөөлөл өргөнөөр оролцсон.
Чуулган дээр уул уурхайн талаарх иргэдийн ойлголт, орон нутаг дахь хамтын ажиллагааг тусгайлан салбар хуралдаанаар сэдэв болгон хэлэлцсэн. Тийм учраас судалгааны хүрээнд чуулганы үеэр хэлэлцсэн агуулгыг Mongolian mining journal, Зууны мэдээ, Өнөөдөр сонингууд, www.gogo.mn, www.ikon.mn, www.time.mn болон бусад эх сурвалжаас тоймлон авч үзлээ.

### 3.1.7 Анхдагч мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх явц

Анхдагч мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх ажлыг үндэсний болон орон нутгийн түвшинд 2023 оны 01-р сарын 16-наас 02-р сарын 09-ний хооронд гүйцэтгэж, судалгааны үндсэн асуултуудын талаарх оролцогч талуудын санал бодлыг цуглуулсан.

Үндэсний түвшинд 2023.01.16-02.09-ний хооронд нийт 17 ганцаарчилсан ярилцлагад олон улсын байгууллага, ТББ-ууд, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллага, уул уурхайн компаниудын төлөөллийг хамруулсан.

Орон нутгийн түвшинд чанарын ярилцлага нь тухайн орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг компаниуд (бичил, жижиг уурхай), орон нутгийн ТББ-ууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын төлөөллөөс ганцаарчилсан ярилцлагууд, орон нутгийн иргэдтэй ФБЯ зохион байгуулсан.

*Хүснэгт 55 . Судалгааны ярилцлагууд.*

| Үйл ажиллагаа | Оролцогч талууд | Үйл ажиллагааны тоо | Оролцогчдын тоо | Байршил |
|---|---|---|---|---|
| ГЯ | Уул уурхай, геологийн салбарын төрийн байгууллага | 2 | 2 | Улаанбаатар |
| | Орон нутгийн удирдлага | 2 | 2 | Сум |
| | Олон төрлийн оролцогч талуудтай байгууллага | 1 | 1 | Улаанбаатар |
| | Хэвлэл мэдээлэл | 2 | 2 | Улаанбаатар |
| | Уул уурхайн компаниуд | 2 | 3 | Улаанбаатар |
| | ТББ-ууд | 1 | 1 | Улаанбаатар |
| | Донор байгууллага | 2 | 2 | Улаанбаатар |
| | Холбоо | 1 | 2 | Улаанбаатар |
| | Орон нутгийн ТББ/Идэвхтэй иргэн | 2 | 2 | Сум |
| ФБЯ | Орон нутгийн иргэд (сумын төвийн оршин суугч, малчид) | 1 | 8 | Сум (Бүрэгхангай) |
| | | 1 | 7 | Сум (Хулд) |
| | **Нийт** | **17** | **32** | - |

Анхдагч мэдээлэл цуглуулалтын хүрээнд хийгдсэн талбарын ажиглалтыг сонгогдсон сумдын 4 байршилд хийсэн. Энэ нь орон нутгийн иргэдийн зан төлөв, хандлага, дадал зуршил, хэрэгцээ, нийгмийн харилцаа, орон нутгийн нөхцөл байдлыг ойлгоход дөхөм болдог. Үүнд талбарын судлаачийн тэмдэглэл, ярилцлагын дуу бичлэг, фото зураг, мөн тухайн орон нутгаас цуглуулсан хэвлэгдсэн материалууд багтана.

ГЯ болон ФБЯ-аар цуглуулсан мэдээллийг боловсруулахдаа ярилцлагын дуу бичлэгүүдийг шивэх, шивэлтийг эргээд дуу бичлэгтэй тулгаж хянах процессууд хийгдсэн. Цуглуулсан мэдээлэлд доороос дээш чиглэсэн буюу индуктив аргаар дүн шинжилгээ хийсэн. Энэхүү процесс нь:

1. Судалгааны асуулт, ярилцлагуудын хариултуудыг шүүж, нэгтгэх байдлаар ангилал хийх,
2. Агуулгад дүн шинжилгээ хийх байдлаар бүтэцчилэх,
3. Оролцогч талуудыг бүлгээр нь харьцуулсан шинжилгээ хийж, орхигдсон зүйлсийг илрүүлэх,
4. , харьцуулалтуудаа ашиглан таамаглал дэвшүүлэх,
5. Ерөнхий дүгнэлт гаргах үе шаттай.

# 4 Судалгааны үр дүн

## 4.1 Судалгааны үр дүнгийн хураангуй

Сүүлийн жилүүдэд олборлох үйлдвэрлэлийн салбар дахь олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүчин чармайлтууд хангалттай үр дүнд хүрээгүйг анхдагч болон хоёрдогч мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнээс харж болно. Чухам яагаад үр дүн багатай байсныг дүн шинжилгээний агуулга тус бүрээр Хүснэгт 6-д хураангуйлан орууллаа.

Хураангуй үр дүнгийн дэлгэрэнгүй тайлбарыг нь судалгааны үр дүнгийн дараах дэд хэсгүүдэд мэдээллийн эх сурвалж тус бүрээр ба Хавсралт 4 Ярилцлагуудад хийгдсэн шинжилгээний хүснэгт-т илүү дэлгэрэнгүй харууллаа.

*Хүснэгт 6 Судалгааны үр дүнгийн хураангуй, мэдээллийн эх сурвалж тус бүрээр*

| Мэдээллийн эх сурвалжийн төрөл | Мэдээллийн эх сурвалж | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн | Олон нийтийн оролцооны тухай ойлголт | Олон нийтийн ойлголт, хандлага | Эрсдэл ба боломж | Иргэдийн оролцоог хангах, олон нийттэй харилцах үр дүнтэй аргууд | Хангагдаагүй хэрэгцээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хоёрдогч мэдээллийн эх сурвалж | Судлагдсан байдлын тойм | Уул уурхайн дөрвөн компани орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж, үйл ажиллагаандаа хамруулах, хамтран ажилладаг гэсэн баримт байна.<br><br>Бусад компаниудын хувьд ерөнхий дүр зургаас харахад өмнөх болон одоогийн орон нутгийн харилцаа тийм ч үр дүнтэй биш байсан.<br>Олон нийт, иргэдийн оролцоо бага.<br>Орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх нь тун ховор.<br>Нийтийг хамарсан нээлттэй өдөрлөг жилд 2-3 удаа болдог. | Цөөн хэдэн компанийг эс тооцвол Монголын компаниудад олон нийтийн оролцоог хангах талаарх ойлголт маш дутмаг.<br>Ихэнх уул уурхайн компаниудад нийгмийн хариуцлагын соёл үгүйлэгдэж байна.<br><br>Олон улс дахь сайн практик туршлага, сургамж судлагдсан байдал их. | Уул уурхайд итгэх иргэдийн итгэлийг тодорхойлогч хүчин зүйлсийн талаарх ойлголтыг өгөх. | Эрсдэл: Олон нийтийн эсэргүүцэл.<br><br>Байгаль орчны эрсдэл, нийгмийн эрсдэл<br><br>Боломж: ажлын байр бий болох, дэд бүтцийг сайжруулах | Орон нутгийн иргэд зөвлөлдөх, шийдвэр гаргахад оролцохыг хүсдэг. Орон нутгийн иргэдтэй зөвшилцөх, харилцаа холбоотой байх арга барилыг тодорхойлох.<br>Уул уурхайн компаниуд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр компанийн байгаль орчны гүйцэтгэл, орон нутгийн хөгжилд үзүүлсэн хандив, дэмжлэгийг мэдээлэх. | Компаниуд орон нутгийн иргэдтэй харилцаа бий болгодоггүй. Тэд ихэвчлэн орон нутгийн засаг захиргаатай харилцдаг.<br>Хөрсний доройтол, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой иргэдийн санаа зовоосон асуудал шийдэгдээгүй байна.<br>Мэдээллийн зөрүүтэй байдал<br><br>Харилцааны зөрүүтэй байдал<br>Орон нутгийн хөгжилд үзүүлж буй уул уурхайн хувь нэмэр болоод иргэдийн хүлээлт хоорондын зөрүү |

| Мэдээллийн эх сурвалжийн төрөл | Мэдээллийн эх сурвалж | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн | Олон нийтийн оролцооны тухай ойлголт | Олон нийтийн ойлголт, хандлага | Эрсдэл ба боломж | Иргэдийн оролцоог хангах, олон нийттэй харилцах үр дүнтэй аргууд | Хангагдаагүй хэрэгцээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагууд | Ил тод байдал дутмаг байгаа нь иргэдийг оролцоход саад болдог. Төрийн байгууллагууд нь хүний эрхийг хамгаалагчдын хөдөлмөрийг үнэлж, хүндэтгэж, дэмжих талаар зохих ойлголт, зөв хандлагагүй байна. Монголд олборлох салбарын мэдлэг хязгаарлагдмал, хүний эрхийг дээдлэх хүсэл эрмэлзэл дутмаг. Энэ судалгаагаар нутгийн удирдлагууд хүний эрхийн зөрчлөөс, тэр дундаа газрын эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ төлөө тэмцэж буй иргэд, тэдэнд заналхийлсэн үйлдлээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх тал дээр үр дүнгүй ажиллаж байгааг тогтоосон. Тухайн суманд олборлолт явуулж буй уул уурхайн үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийн түвшин нь орон нутгийн удирдлагуудын мэдлэг, мэдээлэлтэй харьцуулахад харьцангуй доогуур байна. | Орон нутгийн хэрэгцээ, нэн тэргүүний шаардлагыг ойлгох. Уул уурхайн компаниудтай хэрхэн гэрээ боловсруулж, зохицуулах талаар орон нутгийн засаг захиргааны ойлголт дутмаг, уурхайн өгөөжөөс уурхайн нөлөөнд өртсөн тухайн нутгийн иргэдэд хүргэх тал дээр муу, хэрхэн оновчтой хүргэх талаар мэдлэг дутмаг, түүнчлэн уул уурхайн мөчлөгийн үе шат бүрд оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлага дутагдалтай байхаас гадна уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгэм, эдийн засаг дахь | Нутгийн иргэд уул уурхайн сөрөг үнэлэмж, сэтгэгдэлтэй, жижиг болон дунд уул уурхайн компаниуд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зөв тооцдоггүй, байгаль орчны үр дагаврыг үл тоомсорлодог, сүүлийн шатанд орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг нь хамтын ажиллагааг үр дүнгүй болгодог. Иргэд хайгуул, ашиглалт гэж ялгадаггүй учраас эсэргүүцэх нь элбэг. | Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэл, байгаль орчны доройтол. Уул уурхайн компаниуд Засгийн газрын тогтоолыг дагаж мөрдөхөд хүндрэлтэй байдаг. Олон компани үйлдвэрлэл, борлуулалт, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалтын асуудалтай тулгарснаар тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрдэг. Орон нутгийн, төрийн уул уурхайн нэгдсэн бодлого байхгүй. Улс төрийн тогтворгүй байдал нь уул уурхайн салбарт нөлөөлдөг. | Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь төслийн төлөвлөгөөнд нөлөөлж, үр нөлөө бүхий үр дагавар авчрах шийдвэрийг олон нийтийн оролцоонд үндэслэж гаргах чухал үйл явц юм. | Цөөхөн компани тогтвортой байдлын тайлан гаргадаг, байгаль орчны нөлөөллийн гүйцэтгэл нь холилдсон. Засгийн газар нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн салбарын болзошгүй нөлөөллийн зардлыг системтэй үнэлж, шийдвэрлэх тал дээр бага зүйл хийсэн. Иргэний нийгмийн оролцогч талууд засгийн газар болон иргэний нийгмийн хооронд ямар ч оролцоо байхгүй, иргэний нийгэм шийдвэр гаргахад нөлөөлөх, үүргийн биелэлтийн явцын тухай мэдээлэл авах боломж байхгүй гэж мэдээлсэн. Компаниуд болон орон нутгийн засаг захиргаа уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчин, нийгмийн соёлд үзүүлэх нөлөөг бууруулахад хүчин чармайлт бага гаргадаг. Орон нутгийн иргэд байгаль орчинд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийн талаарх мэдээлэлгүй. БОНБҮ тайлангийн хэлэлцүүлэгт иргэд оролцдоггүй. |

| Мэдээллийн эх сурвалжийн төрөл | Мэдээллийн эх сурвалж | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн | Олон нийтийн оролцооны тухай ойлголт | Олон нийтийн ойлголт, хандлага | Эрсдэл ба боломж | Иргэдийн оролцоог хангах, олон нийттэй харилцах үр дүнтэй аргууд | Хангагдаагүй хэрэгцээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нөлөөллийн талаарх тогтмол хийх баримтжуулалт байхгүй.<br>Уул уурхайн компаниуд ч, орон нутгийн засаг захиргаа ч нутгийн иргэдийн санал, гомдлыг барагдуулдаггүй. | | | | |
| | Уул уурхайн сонин | Орон нутгийн удирдлага мэдээллээ харьцангуй ил тод болгож байна;<br>Оролцооны нэг хэлбэр нь сумын олон талт дэд зөвлөл;<br>Шийдвэр гаргалт, хэрэгжилтийг хянах үйл явцад талуудын оролцоо тэнцвэртэй бус;<br>Биечилсэн уулзалт хийдэггүй тул үр дүн бага. | Орон нутгийн удирдлага илүү өндөр ойлголттой байдаг. | Тусгай зөвшөөрөл ихтэй сумдад олон нийтийн хандлага илүү сөрөг;<br>Компаниуд хандив тусламж амласан ч ерөнхий хандлага сөрөг хэвээр; | Эрсдэл:<br>Малчдын эзэмшлийн газар нутаг тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан тохиолдолд газрын доройтол үүсэх, иргэдийн амьжиргаа дордох эрсдэлтэй;<br>Ил тод бус байдлаас болж үл ойлголцол үүсэх;<br>Боломж: Дэд зөвлөлийг талуудын тэгш оролцоотойгоор байгуулж, сайтар боловсруулсан журам, дүрмийн дагуу ажиллуулах. | Бүх талуудыг тэнцвэртэй оролцуулах | Шийдвэр гаргалтад иргэний нийгэм, иргэдийн оролцоо хангагдаагүй;<br>Компани, орон нутгийн удирдлага мэдээллээ ил тод болгоогүйгээс үл ойлголцол үүсч байна;<br>Тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсанаас болж нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр хэрэгждэггүй, улмаар зөрчил маргаан, сөрөг хандлагыг нэмэгдүүлж байна;<br>Иргэд компаниудаас илүү өндөр хүлээлттэй байна |

| Мэдээллийн эх сурвалжийн төрөл | Мэдээллийн эх сурвалж | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн | Олон нийтийн оролцооны тухай ойлголт | Олон нийтийн ойлголт, хандлага | Эрсдэл ба боломж | Иргэдийн оролцоог хангах, олон нийттэй харилцах үр дүнтэй аргууд | Хангагдаагүй хэрэгцээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Анхдагч мэдээлэл | Ганцаарчилсан ярилцлага | Олон нийтийн хандлага сөрөг хэвээр, орон нутагт зөрчилдөөн байсаар байгаа тул өмнөх хүчин чармайлтууд хүссэн үр дүндээ хүрээгүй.<br>Цөөхөн хэдэн тусгай зөвшөөрөлтэй газруудыг эс тооцвол ихэнх уул уурхайн бүсэд орон нутгийн иргэдийн оролцоо хангагдаагүй.<br>Орон нутгийн иргэдийн оролцоог хангах байдал тун хязгаарлагдмал. Тухайлбал, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-ын гишүүд л мэдээлэл авч, БОНБҮ, тусгай зөвшөөрөл зэрэг уул уурхайтай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлдэг. | Сүүлийн жилүүдэд олон нийтийн оролцоо, түүний ач холбогдлын талаарх ойлголт нэмэгдэж байна. | Олон нийтийн ойлголт хандлага ерөнхийдөө сөрөг. Энэ нь нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, олон нийтийн дунд тархсан гол мессежээс хамаарч хувьсаж ирсэн бөгөөд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компанийн нийгмийн хариуцлагын биелэлтээс ихээхэн хамааралтай. | Эрсдэл: Компани байгаль орчны стандартыг мөрдөөгүй, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг биелүүлээгүй зэрэг нь иргэдийн дундах сөрөг хандлагыг нэмэгдүүлдэг.<br>Боломж: Суманд байгуулагдсан болон иргэдтэй ойр байдаг компаниудын талаарх иргэд, орон нутгийн удирдлагын хандлага илүү эерэг байна. | Алхам алхмаар давтамжтай мэдээлэл өгөх.<br>Нүүр тулсан харилцааг чухалчлах.<br>Гол болон хөндлөнгийн оролцогч талууд (жишээ нь боловсролын байгууллага)-ыг хамруулсан олон талт оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.<br>Эрт мэдээлэх.<br>Мэдээлэл түгээхдээ нийгмийн үйлчилгээг хамтатгах (жишээ нь, эрүүл мэнд, иргэний бүртгэлийн үйлчилгээ бүхий нээлттэй хаалганы өдөрлөг). Ингэснээр ялангуяа малчдын оролцоо нэмэгддэг.<br>Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг.<br>Орон нутгийн иргэдийн түүхийг өөрсдөөр нь яриулах нь тэдний оролцоог нэмэгдүүлэх үр дүнтэй арга. | Дамжуулсан мэдээлэл нь агуулга, хүртээмжийн хувьд орон нутгийн иргэд, оролцогч талуудын хэрэгцээ, хүлээлтэд нийцэхгүй байна.<br>Сөрөг мэдээлэл илүү хурдан тархдаг ба энэ нь нийт уул уурхайн салбарын талаарх ойлголт хандлагад нөлөөлж байна.<br>Компанийн олон нийттэй харилцах нэгжүүд хүний нөөцийн дутагдалтай.<br>Компанийн төлөөлөгчийн өгсөн мэдээлэл иргэдэд зөвөөр хүрэхгүй байх тохиолдол их. |

| Мэдээллийн эх сурвалжийн төрөл | Мэдээллийн эх сурвалж | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн | Олон нийтийн оролцооны тухай ойлголт | Олон нийтийн ойлголт, хандлага | Эрсдэл ба боломж | Иргэдийн оролцоог хангах, олон нийттэй харилцах үр дүнтэй аргууд | Хангагдаагүй хэрэгцээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Фокус бүлгийн ярилцлага | Сумын хэмжээнд багийн иргэдийн нийтийн хурлаас өөрөөр иргэдийн оролцоог хангах, санал бодлыг нь сонсох механизм байдаггүй.<br>Нутгийн иргэд уул уурхайтай холбоотой санал хүсэлтээ баг, сумын засаг дарга нарт уламжилдаг. | Уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх, БОНБҮ тайланг багийн иргэдийн хурлаар сонсох зэргээр оролцоог хангах. | Уул уурхайн идэвхтэй бүс нутгийн иргэдийн хандлага сөрөг. | Орон нутгийн иргэдтэй уул уурхайн компаниуд ойр дотно харилцаатай байх тусмаа тэдэнд хандах хандлага эерэг байна. | Иргэдтэй ганцаарчилсан болон бүлгийн хурлаар уулзах.<br>Иргэдийн саналыг авах боломжит аргуудыг тодорхойлж, дагаж мөрдөх. | Иргэдэд тогтмол мэдээлэл өгдөггүй.<br>Мэдээллийг мэдээллийн эх сурвалжтай ойр хүмүүсээс ам дамжуулан олж авдаг. |

<u>Олборлолт явуулж буй уул уурхайн компаниудад тулгарч буй бэрхшээл:</u>

1. Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн орон нутгийн иргэд уул уурхайн талаар сөрөг ойлголттой болж, компани орон нутгийн иргэдийн хооронд зөрчил, маргаан бий болж байна.
2. Орон нутагт ойр байдаг компанийн ажилтнууд шийдвэр гаргах эрхгүй байдаг учир иргэд, орон нутгийн удирдлагуудын зүгээс гарсан аливаа санал, санаачилга шийдэгдэлгүй орхигддог.
3. КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс үүдэлтэй хөл хорионы үед уул уурхайн компаниудын үйл ажиллагаа ялангуяа олборлолт, борлуулалт, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалтад бэрхшээл тулгарсан байна. *Тухайн цаг үед ЗГ-ийн гаргасан тогтоол, шийдвэр нийт уул уурхайн компаниудын 64 % -д бэрхшээл болж байгааг Эдийн засгийн судалгааны хүрээлэн (ЭЗСХ) 2022 оны судалгаанд дурджээ.*

<u>Орон нутгийн удирдлагуудад тулгарч буй бэрхшээл:</u>

1. Нөхөн сэргээлт хийлгүй үлдсэн газар нутаг.
2. Орон нутгийн иргэд, уул уурхайн компани хоёрын дунд ямар нэг маргаан үүсэхэд орон нутгийн удирдлага тухайн компанийн үйл ажиллагааг зогсоох эрх мэдэл байдаггүй, холбогдох төрийн байгууллагын /АМГТГ/ оролцоо байдаггүй.
3. Бичил уурхайчдын туршлага: Байгаль орчин, нийгэмд узүүлэх сөрөг үр үйл ажиллагаа нь илүү.

<u>Орон нутгийн иргэдийн оролцоонд тулгардаг бэрхшээл:</u>

1. Уул уурхайн асуудлаар орон нутгийн иргэдээс гарсан санал, гомдол шийдвэрлэгддэггүй.
2. Уул уурхайн үйл ажиллагаа, тоосжилтоос үүдэлтэй мал өвчилдөг.
3. Хамтын ажиллагааны гэрээний зүйл заалт, хөрөнгө оруулалт зэрэг мэдээлэл иргэдэд хүрдэггүй.

## 4.2 Судлагдсан байдлын тойм

Эрдэм шинжилгээний өгүүллүүдэд дурдсанаар уул уурхайн компаниуд Компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ын төслүүд хэрэгжүүлэх, эсвэл уул уурхайн үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл (Social license to operate) олж авах замаар үйл ажиллагаагаа хариуцлагатайгаар эрхэлж олон нийтийн зүгээс ирж буй дарамт шаардлагуудад хариу өгч байна. КНХ-ын санаачилгууд болон нийгмийн зөвшөөрөл нь уул уурхайн бизнесийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой хэмээн тооцогдож байна.

Судлагдсан байдлыг системтэйгээр үнэлэх явцад эрдэм шинжилгээний өгүүллүүдээс гарч ирсэн үр дүнг дараах хэсгүүдэд авч үзлээ.

**Олон улсын туршлага**

КНХ-ыг хэрэгжүүлж тогтвортой үр дүн авчрах гол үндэс нь орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг оролцогч талуудын эхний уулзалтаар авч хэлэлцэх явдал юм (Серфонтейн-Жордаан & Длунгвэйн, 2022).

Богино хугацааны КНХ-ын төслүүд ихэвчлэн хандив тусламжийн хэлбэртэй байдаг[9]. Гэвч эдгээр хандив тусламж нь түр зуурын дэмжлэг болдог ба тухайн орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулахаас илүүтэй зөвхөн хэсэг бүлэг иргэдэд л хүрдэг. Асуудлын суурь шалтгааныг арилгахад чиглээгүй, ирээдүй хойч үеийн сайн сайхныг тооцоогүй учир эдгээр КНХ-ын төслүүд тогтвортой үр дүн авчирч чаддаггүй. Энэ дутагдлыг арилгаж, КНХ-ын үр дүнг тогтвортой байлгахын тулд зарим компани богино хугацааны төслүүдийн оронд урт хугацааны бодлого хэрэгжүүлэх болсон байна. Урт хугацааны КНХ-ын төслүүд нь дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, чадавхи бэхжүүлэх чиглэлээр хэрэгждэг ба ирээдүй хойч үед хүртээмжтэй, орон нутгийн иргэдэд эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг нөлөө авчирдгаараа онцлог.

Компаниуд төрөл бүрийн оролцогч талуудын хүлээлтийг тэнцвэртэй хангах шаардлагатай болдог. Тухайлбал, зам (хуучирсан зам засварлах), ус, ариун цэвэр, цахилгаан эрчим хүч, орон сууц, амралт сувиллын газар, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх явдал түгээмэл.

Үүнээс гадна уурхайн амьдралын мөчлөгийн бүхий л үе шатан дахь компанийн асуудлуудаар оролцогч талуудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ гардаг.

Уул уурхайн нөлөөллийн тухай оролцогч талуудын ойлголт, хандлагыг харгалзан үзэх нь КНХ-ыг төлөвлөхөд чухал үүрэгтэй. Энэ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тусгаж, хэрэгжүүлэхэд дэмжлэг болдог. Жишээ нь, Өмнөд Африкийн уул уурхайн бүс нутгуудад уул уурхайн эдийн засгийн нөлөөллийн олон нийтийн ойлголт, хандлага харьцангуй эерэг бол байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хувьд илүү сөрөг байна. КНХ-ын төслүүд нь ихэвчлэн дэд бүтцийн хөгжилд чиглэсэн ч орон нутгийн иргэд нь ажил эрхлэлтийг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх тал дээр илүү хүлээлттэй байжээ. Ийнхүү орон нутгийн иргэдийн хэрэгцээг тусгаж чадаагүй, сөрөг хандлага давамгай байдгаас улбаалан компаниудад үл итгэх байдал үүсэж, цаашилбал үйл ажиллагааг нь эсэргүүцэх үндсэн шалтгаан болдог аж (Сэлоа & Нголе-Жим, 2022).

---

[9] Судалгааны мэдээллээс харахад ихэнх компани орон нутгийн удирдлагатай хамтран ажилллаж, хандив тумламж үзүүлдэг байна.

Орон нутгийн удирдлага болон компани хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг болох зохицуулалтын механизм[10] чухал (Ван дер Уатт & Марайс, 2021).

Эдийн засаг, нийгмийн, байгаль орчны тогтвортой үр дүнд хүрэхийн тулд төслийн төлөвлөлт, шийдвэр гаргах явцад иргэдийг оролцуулах нь чухал (Матикайнен, 2022). Оролцогч талуудыг үйл ажиллагаандаа өнгөцхөн хамруулах нь тогтвортой байдлыг хангах хангалттай хөшүүрэг болж чадахгүй. Талуудын оролцоог хангахдаа харилцан санал солилцох, хамтран ажиллах зэрэг үр дүнтэй арга ашиглах нь харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, тогтвортой байдлын төлөө хүчин чармайлтаа нэгтгэхэд чухал нөлөөтэй (Матикайнен, 2022). Тухайлбал:

1. Ажил эрхлэлтийг дэмжих, ур чадвар олгох сургалт зохион байгуулах зэргээр орон нутгийн бизнесийг дэмжих;
2. Оролцогч талуудын үнэт зүйлсийг ойлгож мэдэх, хамтын үнэ цэнийг бий болгох;
3. Байгаль орчныг хамгаалах төслүүд хэрэгжүүлэх;
4. Олж авсан сургамжуудыг олон нийтийн оролцоог хангах цаашдын төслүүддээ тусгах.

*Хүснэгт 7. Тогтвортой байдлыг хангах хүчин зүйлс, талуудын үүрэг оролцоо.*

| Тогтвортой байдлын тулгуур | Тогтвортой байдлыг хангах хүчин зүйлс | Талуудын үүрэг оролцоо |
|---|---|---|
| Эдийн засаг | Шинээр ажлын байр бий болгох<br>Орон нутгийн иргэдэд орлогын эх үүсвэр бий болгох<br>Барилга, дэд бүтцийн хөгжил<br>Тэтгэврийн сан үүсгэх | Шийдвэр гаргалтын тогтолцоонд иргэдийг оролцуулах<br>Шийдвэрт нөлөөлөх үүднээс талуудын хамтын ажиллагааг дэмжих<br>Ажлын байр бий болгох хамтын ажиллагаа/оролцоо<br>Ажлын байраар дамжуулж орон нутгийн бизнесийг дэмжих |
| Нийгэм | Ур чадвар олгох сургалт<br>Нийтийн эрүүл мэндийг асуудлаас сэргийлэх<br>Иргэдийн уул уурхайгаас хамааралтай байдлаас сэргийлэх<br>Орон нутгийн иргэдийн нийгмийн хэрэгцээг хангах | Талуудын үнэ цэнийг ойлгохын тулд оролцуулах/хамтрах<br>Талуудын үнэ цэнийг дэмжих байдлаар хамтын үнэ цэнийг бий болгох<br>Шийдвэр гаргалтын тогтолцоонд иргэдийг оролцуулах |
| Байгаль орчин | Байгаль орчныг хамгаалах<br>Цэцэрлэгжүүлэлтийг байнга хийснээр байгалийн унаган төрхийг сэргээх<br>Цэвэр эрчим хүч ашиглах | Сургамжуудаа цаашдын ажилдаа тусгах<br>Байгаль орчны асуудлыг шийдвэрлэх олон талт форумд оролцох |

*Эх сурвалж: Матикайнен, 2020*

Төлөвлөлтийн шатанд олон нийтийн оролцоог хангах өөр нэг хэлбэр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-нд иргэдийг оролцуулах явдал юм. Канадын хойд нутгаар уул уурхайн БОНБҮ-ний явцад иргэдийн оролцоог хангах үйл явц хамтарсан менежментийг хэрэгжүүлэх замаар уг төслийг дэмжигчдийн манлайлснаар үр дүнтэй явагджээ. Энэ явцад уугуул иргэдийн соёлын онцлог, уламжлалт мэдлэгийг тусгасан ажээ (Прно г.м., 2021). Хэдэн жил үргэлжилсэн БОНБҮ-ний явцад орон нутгийн иргэдийн оролцоог хангах талаар

[10] Энэхүү механизм болох Нийгэм, хөдөлмөрийн төлөвлөгөөг Өмнөд Африкийн уул уурхайн үйлдвэрлэлд ашигладаг ба уул уурхайгаас хүртэх үр өгөөжийг бүх талд тэгш хуваарилахад чиглэсэн. 2022 оны Ашигт малтмал, газрын тосны нөөц ашиглах тухай хуулинд зааснаар энэхүү төлөвлөгөөг Ашигт малтмал, эрчим хүчний газар баталсан нөхцөлд компанид ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог (Ван дер Уатт & Марайс 2021). Уул уурхайн компани Нийгэм хөдөлмөрийн төлөвлөгөөгөө тухайн орон нутгийн Хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөнд нийцүүлсэн байх нь зөвшөөрөл авах урьдчилсан нөхцөл болдог ба үүний үр дүнд компани, орон нутгийн засаг захиргаа хооронд албан ёсны хамтын ажиллагаа үүсдэг (Ван дер Уатт & Марайс 2021). Хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө нь орон нутгийн удирдлагын ажлыг орон нутгийн иргэдтэй бизнес үйлдвэрлэлийн салбаруудаар дамжуулан холбох замаар орон нутгийн амьжиргааг дэмжих цогц хөтөлбөр.

- Үйл явцын эхнээс нь оролцуулах, нөхцөл байдалд тохирсон арга замыг хэрэгжүүлэх,
- Мэдээллийг цогц байдлаар бүртгэж, тайлагнах
- Орон нутгийн иргэдийн санал бодлыг чухалчилж авч үзэх
- Урт хугацааны харилцаа, хамтын ажиллагаа, өгөөжийг бий болгох зэрэг арга замуудыг хэрэгжүүлжээ.

Олон удаагийн давтамжтай энэхүү үйл явцын үр дүнд иргэдийн нийгмийн асуудлуудыг тусгаж, улмаар олон нийтийн дэмжлэгийг авснаар төсөл батлагдсан байна.

Иргэдийн ихэнх нь компаниудыг орон нутагт ажлын байр бий болгох, ханган нийлүүлэлтийн боломж бүрдүүлэх, санхүүгийн мэдээллээ ил тод болгох, орон нутгийн иргэдийн нийгмийн болон байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэдэг байхыг хүсдэг байна (Кот-Ниевиадомска, г.м., 2022).

Уул уурхайн төслийг хүлээн зөвшөөрөхийн тулд иргэд тухайн төслийн боломжит үр өгөөжийг эрсдлээс дээгүүр гэж авч үзэх нь зүйтэй. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, иргэдийн хүлээлтэд нийцүүлэн ажиллах асуудал нь 2021 онд уул уурхайн салбарын эрсдэлүүдээс эхний 4-т бичигдсэн байна (Клинвелд Пийт Марвик Гоэрделер, 2021).

Уул уурхайн үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл олж авах нэг арга зам нь тухайн орон нутгийн иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх явдал юм (Кот-Ниевиадомска, г.м., 2022). Тайлан дахь Меконг мөрний ойролцоо оршдог нэгэн уул уурхайн бүсэд компанийн зүгээс мэдээлэл дутмаг байсны улмаас орон нутгийн иргэд ус, хөрсөнд хүнд металын бохирдол үүссэн гэж сэжиглэн компани, иргэдийн хооронд зөрчил үүсжээ (Килажиана & Чареонсуджай, 2021). Олон нийт санаа зовж эхэлсний улмаас тухайн газар нутаг орчмын ус, хөрсний сорьцыг авч шинжилгээнд харуулахад хүнцэлээс бусад хүнд металлын агуулгаж тухайн улсын зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур гарсан ба төсөл эхлэхээс өмнө хийсэн төлөв байдлын судалгааны суурь үзүүлэлтээс онц өөрчлөгдөөгүй байжээ (Килажиана & Чареонсуджай, 2021). Энэ жишээгээр олон нийтэд хангалттай мэдээлэл хүргэх, харилцаа холбооны оновчтой аргуудыг ашиглах, иргэдийн амьдралд шууд нөлөөтэй төслүүдийн шийдвэр гаргалтад орон нутгийн иргэдийг хамруулахын ач холбогдлыг харж болно.

Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл нь хамтын шийдвэр гаргалт бүхий нийгмийн хариуцлагыг чухалчилдаг. Үүний нэг жишээ нь, орон нутгийн засаглалыг сайжруулахад чиглэсэн талуудын харилцан санал солилцох явдал юм. Санал солилцох хоёр төрлийн арга байж болно.

1. Харилцан санал солилцох стратеги загвар (тодорхой зорилго, үр дүнд чиглэсэн илүү бүтэцлэгдсэн уулзалт яриа) нь талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхэд чиглэгдэнэ.
2. Харилцан суралцахад чиглэсэн уулзалт яриа (талууд төрөл бүрийн асуудлаар илүү чөлөөтэй ярилцаж, харилцан нэгнээсээ суралцах) нь зөвшилцөлд хүрэх тодорхой зорилготой байж болно.

Хоёр талын урсгал бүхий шууд харилцаа үүсгэдэг тул аль аль арга нь үр дүнтэй бөгөөд бусдынхаа нөлөөгөөр оролцогч талуудын үзэл бодол өөрчлөгдөх магадлалтай гэдэг утгаараа хувь хүний болон нийгмийн түвшинд өөрчлөлт авчрах боломжтой (гэвч амьдрал дээр ховор) юм. Харилцан санал солилцох нэг үр дүнтэй арга нь иргэд болон компанийн төлөөлөл нүүр тулан ярилцах явдал юм. Энэ нь үзэл бодол, санаа зорилго, үнэт зүйлс болон байгаа мэдээллээ солилцож хөгжүүлэх замаар харилцан ойлголцлыг бий болгох ач холбогдолтой. Энэ нь “хэлэлцүүлэг”-ээс ялгаатай юм. Учир нь хэлэлцүүлэг бол нэг тал нь чиглүүлдэг бол харилцан санал солилцох нь өөр өөр талууд нэг ширээний ард ижил тэгш эрх, оролцоотойгоор суух боломжийг бүрдүүлдэг (Мерсер-Мапстоун, г.м., 2018).

Компаниуд нөөцийн төлөөх өрсөлдөөнөөс, ялангуяа усны асуудлаас үүссэн зөрчил маргаанаас сэргийлэх үүднээс оролцогч талуудтай хамтардаг (жишээ нь, Латин Америкийн уул уурхайн төслүүдэд гаргасан гомдлын 58 % нь устай холбоотой). Олон нийтийн оролцоог хангах хүрээнд иргэдийн оролцоотой усны мониторингийн хөтөлбөр Латин Америкийн орнуудад түгээмэл

хэрэгждэг. Уг үйл явц иргэний шинжлэх ухаан (citizen science) хэмээх ойлголт дээр үндэслэсэн байдаг ба энэ нь олон нийт сорьц цуглуулж өгөх зэргээр шинжлэх ухааны судалгааны үйл явцад оролцохыг хэлнэ. Эдгээр хөтөлбөр нь иргэдийн оролцооны цар хүрээнээс хамааран дараах түгээмэл хэлбэрүүдтэй. Үүнд:

1. Гаднаас удирдсан, мэргэжлийн түвшинд зохион байгуулагдсан (хамгийн түгээмэл хэлбэр),
2. Гаднаас удирдсан, орон нутгийн иргэд мэдээлэл цуглуулсан,
3. Хөндлөнгийн тал мэдээллийг хөрвүүлсэн, хамтарсан мониторинг,
4. Орон нутгийн оролцогчид мэдээллийг хөрвүүлсэн хамтарсан мониторинг,
5. Орон нутгийн талууд бие даан мониторинг хийх (2 дахь түгээмэл хэлбэр).

Ерөнхийдөө иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг нь шийдвэр гаргалтад нөлөөлөхөөс илүүтэй мэдээлэл өгөх ач холбогдолтой. Харин тогтмол зохион байгуулснаар иргэдийн шийдвэр гаргалтад оролцох идэвхи санаачилгыг нэмэгдүүлж болох юм. Уг жишээнээс авах гол санаа нь уул уурхайн төслийн хүрээнд хийгдэж буй иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн үе шат бүрт иргэдийн оролцоог үнэлэх

1. Төлөвлөлт: гадны удирдлагатай, хамтарсан, орон нутгийн удирдлагатай;
2. Мэдээлэл цуглуулалт: орон нутгийн, мэргэжлийн;
3. Орон нутгийн, гадны мэдээллийг хөрвүүлэх (Пажера, г.м., 2018) загварууд юм.

Зарим бүсэд бичил уурхай нь орон нутгийн иргэдийн амьжиргааны нэг эх үүсвэр болж, ихэнх өрх ямар нэгэн байдлаар энэ үйл явцтай холбогдсон байдаг тул харьцангуй хүлээн зөвшөөрөгдөх хандлагатай болжээ. Жишээ нь, Перугийн нэгэн тосгонд бичил уурхай амьжиргааны бусад эх үүсвэрүүдтэй зэрэгцэн оршдог ба усны бохирдол, усан дахь хавчны нөөц багасах, газар ашиглалтын маргаан, нийгмийн хагарал хуваагдал зэрэг зөрчил маргаантай асуудлуудыг тэсвэрлэн оршсоор байдаг. Орон нутгийн иргэдэд ирэх эдийн засгийн үр өгөөжөөс гадна нийгмийн харилцаан дахь эрх мэдэл ашиг сонирхлын нөлөөлөл, ялангуяа бичил уурхайн бүлгийн ахлагч нар орон нутгийн удирдлагатай ойр байдгаас эсэргүүцдэг иргэдийн дуу хоолой дарагдаж, бичил уурхайг илүү хариуцлагатай ажиллуулах тэмцлийн хүч суларчээ (Малоне, г.м., 2021).

**Монголын туршлагаас**

Африк, Латин Америк, Төв Азийн орнууд болон Монголд ч мөн адил мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй иргэд, жижиг бизнес эрхлэгчид тухайн газар эсвэл бэлчээрийн газрын эзэмшил байдаггүй. Хөгжиж буй орнуудад лиценз, зөвшөөрөлтэй холбоотой авлигын асуудал байнга яригддаг, орон нутгийн иргэдийн шийдвэр гаргалтад оролцох боломж хязгаарлагдмал бөгөөд энэ байдал нь үргэлжилсээр байна (Стэрнберг, 2022).

Компанийн ажилтнуудтай харилцах харилцаа, үйл ажиллагааны шударга байдал, нийгмийн дэд бүтцэд үзүүлэх нөлөөлөл нь компанид итгэх итгэлийг нэмэгдүүлэх эсвэл бууруулах замаар олон нийтийн зөвшилцөлд нөлөөлдөг. Процедурын шударга байдал[11] нь хамгийн хүчтэй таамаглагч байсан бол нийгмийн дэд бүтцэд үзүүлэх нөлөөлөл нь хоёрдугаарт, харин холбоо харилцааны тоон үзүүлэлт нь хамгийн сул таамаглагч байсан (Т.Батдэлгэр, 2022).

1. Төрийн өмчит уул уурхайн компаниуд хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниудтай харьцуулахад олон нийтийн эсэргүүцэлтэй[12] харьцангуй бага

[11] Процедурын шударга ёсны үзэл баримтлалд шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн хэргийг шүүн тунгаахгүй байх эсвэл үр дүнд нь санаархахгүй байх, шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гаргахын өмнө хэргийн хоёр талын саналыг сонсох гэсэн нийтлэг хуулийн хоёр зарчмаас үүссэн. Процедурын шударга байдал нь шийдвэрийн үр дүн шударга байсан эсэхэд хамаарахгүй, харин үйл явц шударга болсон эсэхэд чухал ач холбогдолтой. Хэрэв үйл явц шударга бус байсан бол захиргааны шийдвэрийг шүүхээр хянуулахын тулд шүүхэд хандах боломжтой.
[12] Түүхээс харахад 1990 оноос өмнө уул уурхайн компаниуд төрийн өмчид байсан. Тиймээс ард иргэдийн оролцоо гэсэн ойлголт байгаагүй. Монгол Улс нэг (коммунист) намаар удирдуулсан социалист орон байсан. Төрийн өмчит компаниуд мэдээлэл солилцдоггүй байсан бөгөөд тэдний нийгмийн хариуцлага нь улс төрийн шинж чанартай байдаг.

тулгардаг. Үүний эсрэгээр, үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөлтэй холбоотой асуудал хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай уурхайнуудад хамгийн их тохиолддог.

2. Уул уурхайн үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл авсан компаниудын жишээнээс дурьдвал “Оюутолгой” ХХК, “Энержи Ресурс” ХХК юм. Харин нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй холбоотойгоор уул уурхайн бүтээн байгуулалт хойшилсон, тасалдсан, бүр зогссон тохиолдол цөөнгүй удаа гарч байсан.

3. Монголд уул уурхайн олон компани үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл авдаг нь маш цөөхөн. Жижиг, дунд уул уурхайн компаниуд олон нийтэд мэдээлэл өгдөггүй, ил тод бус байдаг[13]. Монголын уул уурхайн компаниуд тус зөвшөөрлийн талаар сайн ойлголтгүй байдаг. Монголд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдлын судалгаа огт хийж байгаагүй. Өмнө нь социалист дэглэмтэй байсан тул Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулах нийгмийн зөвшөөрөл авах нь шинэ үзэгдэл болсон (Т.Батдэлгэр, 2022). Уул уурхайн компаниуд зөвхөн хууль ёсны шаардлагыг дагаж мөрддөг, олон нийтийн санаа зовоосон асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй.

4. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг зөвхөн нэг удаа олгоод л тодорхойгүй хугацаанд хүчинтэй хэвээр байна гэсэн үг биш, харин тус зөвшөөрлийг хадгалах арга зам нь уул уурхайн төсөл болон бусад нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх иргэдийн хандлагыг тасралтгүй үнэлэх явдал юм.

КНХ-ын олон нийт, корпорацуудын цогц ойлголт дутмаг байгаа нь эргээд энэхүү нийгмийн хариуцлагын тогтвортой практикийг төлөвшүүлэх гол сул тал мөн гэж тодорхойлсон. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааны талаарх ойлголтыг буяны үйлс, хандив өгөх, ивээн тэтгэх гэсэн хэдхэн үйл ажиллагаа гэж үздэг (Алтанчимэг Занабазар, 2019).

1. Монголд нийгмийн хариуцлагын тайлан дутмагаас гадна нийгмийн хариуцлагын хөтөлбөрөө тайлагнадаг компани маш цөөхөн.
2. Түүгээр ч зогсохгүй ихэнх аж ахуйн нэгжүүд ил тод бус байдгаас ашиг орлого, удирдлагын үйл ажиллагаагаа ил тод болгодоггүй, мэдээлэхийг хүсдэггүй, албан ёсны лавлагаанд хариу өгдөггүй, бүр албан газраа хаадаг, татварын албанд бүртгэлтэй дансгүй байх тохиолдол гардаг байна.
3. Орон нутгийн түвшинд компанийн нийгмийн хариуцлага нь байгаль орчны нөхөн сэргээлт, татвар төлөлт, ажлын байр, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлж байгаа зэрэг компанийн гүйцэтгэсэн ажилд чиглэгддэг.
4. Компаниуд төвийн болон орон нутгийн төрийн байгууллагуудтай харилцаж, зөвхөн Засгийн газарт тогтмол тайлан, мэдээлэл ирүүлэх замаар хариуцлагаа харуулдаг.

Ашигт малтмалын талаар шийдвэр гаргахад орон нутгийн засаг захиргаа, малчдын гүйцэтгэх үүрэг ач холбогдлын хувьд хоёрдогч хэвээр байна (Д.Бямбажав, 2022).

- Олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж буй гэрээнүүд нөхцөл байдалтайгаа сайн уялдаагүй байх нь нэлээд тохиолдоно. Тухайлбал, (а), уул уурхайн компани, орон нутагтай гэрээ байгуулдаг бол хайгуулын компаниуд гэрээ байгуулдаггүй, (б) аймаг

[13] Мэдээлэл нийтлэхэд хууль эрх зүйн шаардлага байхгүй (NRGI, 2021). Бусад шалтгаан нь: (1) олон нийтийн оролцоонд сонирхолгүй байх, олон нийтийн оролцоог дарамт гэж үзэх, зөвхөн хуульд заасан зүйлийг биелүүлэх, (2)татвараа засгийн газарт төлдөгөөс үүдэн олон нийт төв засгийн газраас татвараа сумандаа хуваарилахыг шаардах ёстой болдог.

гэхээсээ илүү сумдад илүү хийсэн байна; (в) гэрээг харьцангуй богино хугацаагаар, ихэвчлэн нэг жил ба түүнээс ч бага хугацаатай байгуулдаг.

- Компаниуд ОНХАГ-г засгийн газраас гаргасан шахалт дарамт, нэмэлт зардал гэж хардаг.
- ОНХАГ байгуулахад Засгийн газрын дэмжлэг, санаачилга дутмаг.
- Гэрээ байгуулах үйл явц нь ил тод бус.
- ОНХАГ-нд юу тусгах тал дээр илүүтэй анхаарч харин харилцаа холбоо хэрхэн тогтоох, уг гэрээг хэрэгжүүлэх арга замын заавар, зааварчилгааг тусгадаггүй байна.

Компанийн үр дүнтэй харилцаа холбоо нь малчдын дунд эерэг ойлголт, итгэлцлийг бий болгоход нөлөөлсөн болохыг судалгаа харуулж байна (Л.Дагвадорж, 2018).

Уул уурхай нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг хэдий ч орон нутгийн аж амьдрал, иргэдийн тогтвортой амьжиргаа, хүмүүсийн сэтгэл зүйн эрүүл мэнд, хандлага, нийгмийн ёс зүйд сөргөөр нөлөөлдөг (Штернберг, Токтомушев, Ичинхорлоо, 2022).

Уул уурхайгаас үүдэлтэй иргэдэд учирч буй хохирлыг барагдуулахын тулд зохих нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө шаардлагатай ч нүүлгэн шилжүүлэлтийн багц стандарт байдаггүй нь нутгийн иргэдийн дунд ялгаварлан гадуурхалт, төөрөгдөл үүсгэж, зөрчилдөөнийг улам хурцатгаж байна.

## 4.3 Компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээний үр дүн

Контент дүн шинжилгээний үр дүнгээс харахад уул уурхайн компаниуд өөр өөр арга, мессежээр дамжуулан хэрэглэгчидтэй харилцахын тулд цахим хуудсаа ихээхэн ялгаатай байдлаар ашиглаж байна. Компанийн үндсэн мэдээлэлд төвлөрсөн энгийн сайтуудаас эхлээд виртуал аялал, арга хэмжээ, мэдээллийн сан, мэдээллийн товхимол, хэрэглэгчид болон орон нутгийн иргэдэд зориулсан сэтгүүл зэрэг цогц элементүүдийг агуулсан илүү хөгжингүй сайтууд ч байна. Түүгээр ч зогсохгүй ТӨҮГ-ууд, ГХО-тай болон үндэсний хувийн хэвшлийн компаниудын дунд олон нийтэд мэдээлэл түгээх, олон нийтийн оролцооны үйл ажиллагааны хувьд ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Энэ хэсэгт гол дүгнэлтүүдийн хураангуйг хүргэж байгаа бол нарийвчилсан дүн шинжилгээг Хавсралт 5 Компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээ-д оруулсан болно.

Судалгааны үр дүн нь уул уурхайн компаниуд цахим хуудсаа идэвхтэй ашиглаж, хөтөлж байгаа эсэхийг харуулж, дараа нь хэрэглэгчдэд мэдээлэл түгээх/оролцуулахын тулд ямар хэрэгслийг голчлон, эсхүл ховор ашиглаж байгааг харуулахын тулд бүрэлдэхүүн хэсгүүдийн ангилалд хамаарах тоон шинжилгээг үзүүлэв. Эцэст нь, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцооны талаар цахим хуудсаараа дамжуулан түгээдэг гол мессежүүдийн талаар хүргэнэ.

### Цахим хуудас ашиглах байдал

Судалгаанд хамруулсан 63 компаниас 26 нь судалгаа явуулах үед цахим хуудасгүй, найман компанийн мэдээлэл толгой компанийнхаа цахим хуудсанд гарсан, эсхүл цахим хуудсанд нь нэвтрэх боломжгүй байсан тул эдгээр компанийг цаашдын дүн шинжилгээнээс хасав (Хүснэгт 8).

*Хүснэгт 8. Ажиллаж буй цахим хуудастай ком*

| Ангилал | Компанийн тоо | Цахим хуудастай | Хассан | Цахим хуудасгүй | Цахим хуудасгүй компаниудын хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| ТӨҮГ-ууд | 11 | 10 | 0 | 1 | 9 |
| Гадаадын/ГХО-тай компаниуд | 21 | 10 | 1 | 10 | 48 |
| Үндэсний хувийн компаниуд | 31 | 9 | 7 | 15 | 48 |
| **Нийт** | **63** | **29** | **8** | **26** | **41** |

Үр дүнгээс харахад ТӨҮГ-ууд цахим хуудсыг хамгийн идэвхтэй ашиглаж байна. Дүн шинжилгээнд хамрагдсан 11 ТӨҮГ-ын зөвхөн 1 нь (9 %) нь энэ судалгааг хийх үед цахим хуудасгүй байв. Нөгөө талаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын/ГХО-тай хувийн компаниуд болон Монголын хувийн компаниудын 48 % нь цахим хуудасгүй байлаа.

### Мэдээлэл харилцааны гол болон ховор бүрэлдэхүүн хэсгүүд

Судалгааны баг 29 компанийн (ТӨҮГ-10, Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын/ГХО-тай компани-10, үндэсний хувийн компани-9) цахим хуудсанд мэдээлэл харилцааны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлохын тулд тоон судалгааны арга ашигласан (Хүснэгт 9).

*Хүснэгт 9. Цахим хуудасны бүрэлдэхүүн хэсгүүд.*

| Ангилал | ТӨҮГ-ууд (10) | | | Гадаадын/ГХО-тай компаниуд (10) | | | Үндэсний хувийн компаниуд (9) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Цахим хуудасны бүрэлдэхүүн** | **Тийм** | **Үгүй** | **Тийм (%)** | **Тийм** | **Үгүй** | **Тийм (%)** | **Тийм** | **Үгүй** | **Тийм (%)** |
| Түлхүүр үгс компанийн эрхэм | 8 | 2 | 80 | 9 | 1 | 90 | 5 | 4 | 56 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зорилго, алсын хараа, үнэт зүйлсэд байгаа | | | | | | | | | |
| Түлхүүр үгс цахим хуудасны нүүр хуудасны цэсэнд байгаа | 10 | 0 | 100 | 8 | 2 | 80 | 8 | 1 | 89 |
| Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайланг татаж авах боломжтой | 4 | 6 | 40 | 5 | 5 | 50 | 2 | 7 | 22 |
| Мэдээлэл түгээх материалууд (мэдээ, видео, постер г.м.) байгаа | 10 | 0 | 100 | 9 | 1 | 90 | 6 | 3 | 67 |
| Олон нийтийн нөлөөллийн кампанит ажил зарласан | 3 | 7 | 30 | 1 | 9 | 10 | 0 | 9 | 0 |
| Орон нутгийн иргэдэд зориулсан үйл ажиллагаанууд зарласан | 2 | 8 | 20 | 1 | 9 | 10 | 1 | 8 | 11 |
| Хэрэглэгчид сэтгэгдэл бичих боломжтой | 2 | 8 | 20 | 1 | 9 | 10 | 2 | 7 | 22 |
| Түгээмэл асуулт хариултууд байгаа | 0 | 10 | 0 | 2 | 8 | 20 | 0 | 9 | 0 |
| Санал хүсэлт, гомдол гаргах боломжтой | 7 | 3 | 70 | 7 | 3 | 70 | 4 | 5 | 44 |
| Холбоо барих мэдээлэл байгаа | 10 | 0 | 100 | 9 | 1 | 80 | 9 | 0 | 100 |
| Цахим хуудсанд компанийн олон нийтийн сүлжээний хуудсыг холбосон | 7 | 3 | 70 | 6 | 4 | 60 | 5 | 4 | 56 |

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын/ГХО-тай хувийн компаниудын 90 %, ТӨҮГ-уудын 80 %, үндэсний хувийн компаниудын 56 % нь өөрсдийн эрхэм зорилго, алсын хараа болон үнэт зүйлсийн мэдэгдэлд түлхүүр үгсийг[14] ашигласан байна. Нийт уул уурхайн компаниудын 80-100 % нь энэ судалгаанд сонгосон түлхүүр үгсийн талаар цахим хуудсандаа тусгайлсан цэс/дэд цэстэй байгаагаас үзэхэд тэд хариуцлагатай уул уурхай хэрэгжүүлэгч хэмээн өөрсдийгөө танилцуулахыг эрмэлзэж байна. Гэвч гадаадын/ГХО-тай хувийн компаниудын тал хувь нь, ТӨҮГ-уудын 40 %, үндэсний хувийн компаниудын 22 % нь л жилийн/КНХ-ын тайлангаа цахим хуудсандаа нийтэлжээ.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 90 гаруй хувь, гадаадын/ГХО-тай компаниуд, үндэсний хувийн компаниудын 67 хувь нь мэдээ, видео, зурагт хуудас зэрэг олон нийтэд мэдээлэл түгээх материал нийтэлсэн бол нийт уул уурхайн компаниудын 10-20 хувь нь л цахим хуудсан дахь материалдаа сэтгэгдэл үлдээх боломжийг хэрэглэгчдэдээ олгодог байна.

Ихэнх компани хэрэглэгчдийг татан оролцуулах бүрэлдэхүүн хэсгүүдийг ашигладаггүй нь судалгааны дүнд ажиглагдав. Тухайлбал, ТӨҮГ-ын ердөө 30 %, гадаадын/ГХО-тай компаниудын 10 % нь л олон нийтийн нөлөөллийн кампанит ажил цахим хуудсаараа дамжуулан мэдээлсэн бол үндэсний нэг ч хувийн компани энэ арга хэрэгслийг ашиглаагүй байна. Орон нутгийн иргэдэд зориулсан үйл ажиллагаа зарлах тухайд ТӨҮГ-ын 20 %, үндэсний хувийн компаниудын 11 %, гадаадын/ГХО-тай компаниудын 10 % нь цахим хуудсаа ашиглажээ.

Ихэнх компани холбоо барих мэдээллээ цахим хуудсандаа байрлуулсан хэдий ч зарим нь үүгээр

[14] Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжил, орон нутгийн хөгжил, олон нийтийн оролцоо, олон нийтийн арга хэмжээ, зөвлөгөөн

дамжуулан нийгмийн сүлжээгээ сурталчлах боломжийг бүрэн ашиглаж чадаагүй байна. ТӨҮГ-ууд болон гадаадын/ГХО-тай компаниудын 70 %, үндэсний хувийн компаниудын 44 % нь цахим хуудсаараа дамжуулан санал хүсэлт, гомдол илгээх боломж бүрдүүлсэн системтэй байсан нь анхаарал татахуйц үр дүн юм. Түгээмэл асуулт хариултууд хамгийн бага ашиглагдсан бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гадаадын/ГХО-тай компаниудын 20 % үүнийг ашигласан бол ТӨҮГ болон үндэсний хувийн компаниудын аль нь ч түгээмэл асуулт нийтлээгүй байна.

**Цахим хуудасны дүн шинжилгээнд суурилсан гол мессежүүд[15]**

**Төрийн өмчит үйлдвэрийн газрууд**

Ихэнх ТӨҮГ-ууд өөрсдийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн мэдэгдэлдээ тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагыг онцолжээ. Тэдгээрийн цахим хуудас нүүр хуудсандаа тусгай цэстэй бөгөөд нийгмийн хариуцлага, байгаль орчны нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлт, худалдан авалт, аюулгүй байдал зэргийг тэргүүн эгнээнд онцолж мэдээлэл өгчээ. ТӨҮГ-уудын 40 % нь жилийн болон КНХ-ын тайлангаа нийтэлж ихэнх нь "Мэдээ" гэсэн цэсээр дамжуулан үйл ажиллагааныхаа мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Компаниуд мэдээллийг гол төлөв текст болон зураг хэлбэрээр өгдөг бол “Бадрах Энержи”, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ видео, инфографик, мэдээллийн хуудас, кейс зэргийг нийтэлсэн хэдий ч ихэнх мэдээлэл нь хуучирсан, шинэчлэх шаардлагатай харагдав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд ТӨҮГ-ууд эрүүл мэнд, боловсролын салбарт болон малчид, ахмадуудад өгсөн хандив тусламж, оюутны тэтгэлгийн талаар мэдээллийг түлхүү багтаажээ. Түүнчлэн “Эрдэнэт үйлдвэр”, “Эрдэнэс Тавантолгой” зэрэг төрийн өмчит компани ажилчдаа нийгэм, эдийн засгийн боломжоор хангаж байгаагаа онцолсон байв. Орон нутгийн иргэдэд зориулсан уулзалт, уурхайтай танилцах аялал, сургалт, зөвлөгөөний талаар цөөн мэдээ нийтэлсэн ч тэдгээр арга хэмжээний хэлэлцүүлгийн явц, үр дүнг голдуу орхигдуулсныг тэмдэглэе. “Эрдэнэс Силвер Ресурс” компанийн цахим хуудас сүүлийн саруудад байнга шинэчлэгдэж МЕРИТ төсөлтэй хамтарсан уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлын мэдээллүүдийг гаргасан нь мэдэгдэхүйц ялгарч харагдана. Учир нь, эдгээр мэдээлэл олон нийтийн оролцоонд анхаарлаа хандуулж, нутгийн иргэдийн санал бодлыг олон нийттэй хуваалцсан байлаа.

**Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын/ГХО-тай компаниуд**

Монгол дахь гадаадын/ГХО-тай уул уурхайн компаниудын ихэнх нь нийгмийн хариуцлагыг эрхэмлэн, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжил, олон нийтийн оролцоо зэргийг чухалчилсан мэдээллийг цахим хуудсаараа хүргэжээ. 10 компанийн 8 нь тогтвортой хөгжил/нийгмийн хариуцлагын бодлогоо нарийвчлан тайлбарласан тусгай цэсээр харуулжээ. Орон нутгийн иргэдийг ажлын байраар, орон нутгийн бизнес эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэх боломжоор хангах, хандив, тэтгэлэг зэрэг олон нийтийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь компаниудын өгсөн хамгийн нийтлэг мессеж байв.

Компаниудын тал нь жилийн/КНХ-ын тайлангаа нийтэлжээ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлсэн талаар мэдээлэл өгөх нь мөн түгээмэл байв. Зарим компани орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэхэд олон нийтийг татан оролцуулах механизм ашигладаг ажээ. Тухайлбал, “Саусгоби Ресорсиз” Иргэдийн хороо байгуулж, “Баян Айраг Эксплорэйшн” орон нутгийн “Баян Дөрвөлжингийн Өгөөж” ТББ-тай хамтран ажиллаж, “Оюу Толгой” компани “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан”-г санхүүжүүлдэг аж.

---

[15] Компаниудын вэб сайтын контент анализын судалгааны үр дүнд тодорхойлсон гол мессежүүдийн талаар илүү нарийвчилсан мэдээлэл авахын тулд Хавсралт 5-ыг харна уу.

*Шигтгээ 1. “Оюу Толгой” компанийн олон нийтийн оролцоог хангах ажлууд.*

2021 оны жилийн тайлан нь "Түншлэгч талуудын хамтын ажиллагаа" бүлгээрээ дамжуулан орон нутгийн иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаагаа хүргэжээ. Тус компани Өмнөговь аймгийн төрийн албан хаагчид, малчид болон нийгмийн бусад гишүүд зэрэг 1172 оролцогч талтай 800 гаруй уулзалт, зөвлөгөөн хийснээ онцолж “Оюу Толгой” компани жил бүр Ханбогд, Даланзадгад, Манлай, Баян-Овоо сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдгаа нийтэлжээ.

Тус компани орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2021 онд “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан”-д 5.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

“Оюу Толгой” компани хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжиж, "Малчин" гар утасны аппликейшн нэвтрүүлж, бизнесийг чадавхжуулах 5 удаагийн сургалт 29 оролцогчдод, 99 зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, малчин өрхүүд ингэний сүүгээр дотоодын брэнд бий болгон зах зээлд нийлүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлсэн зэргээс гадна бусад хандив, тусламжийн мэдээллийг хүргэжээ.

2021 оны 12 дугаар сарын байдлаар “Оюу Толгой” компанийн үндэсний худалдан авалтын 25 хувийг орон нутгийн ханган нийлүүлэлт эзэлж, нийт ажиллах хүчний 24.7 хувийг орон нутгийн иргэд бүрдүүлж байна. Зөвхөн 2021 онд дотоодын 94 ханган нийлүүлэгч 216 сая ам.долларын бараа, үйлчилгээг “Оюу Толгой” компанид нийлүүлжээ.

Цагдаагийн ерөнхий газартай урт хугацааны түншлэл эхлүүлэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр улсын хэмжээнд аян өрнүүлж, Сайншанд-Замын-Үүд чиглэлийн замд хурд хянах камер суурилуулсан.

Тус тайланд COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан хандив тусламж, өсвөр насныхны сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд чиглэсэн боловсролын төсөл, хөтөлбөрүүдийг орхигдуулалгүй дурджээ.

Гадаадын/ГХО-тай компаниудын олонх нь мэдээллийн булангаа монгол хэлээр цаг тухайд нь шинэчлэхгүй байна. Үүнд үл хамаарах нь “Монцемент Билдинг Материалс”, “Оюу Толгой” ХХК байв. “Монцемент Билдинг Материалс” компани "Медиа" булангаа компанийн үйл ажиллагаа, кампанит ажил, ажилтнуудын тухай мэдээ мэдээлэл, видео, фото мэдээллээр байнга шинэчлэн олон нийтийн хүртээл болгожээ. Оюу Толгой ХХК-ийн цахим хуудас "Хэвлэл мэдээлэл" булангаа тогтмол шинэчлэхийн сацуу компанийн үйл ажиллагаа, орон нутгийн бүтээн байгуулалтын мэдээлэл бүхий "Уурхайчин" сэтгүүлийг улирал тутам гаргадаг аж.

*Шигтгээ 2. “Баян Айраг Эксплорэйшн” компанийн орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээсэн байдал*

“Баян Айраг Эксплорэйшн” компанийн “Тогтвортой хөгжил” тайлан нь 35 гаруй хүнтэй хийсэн ярилцлагад үндэслэн хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хөгжил, аюулгүй байдал, байгаль орчны менежмент, хүний нөөц, бизнесийн манлайллын мэдээллийг 64 нүүр сэтгүүл хэлбэрээр гаргасан нь орон нутгийн иргэдэд шууд чиглэжээ. Тус тайланд “Баян Айраг Эксплорэйшн” компани ажилд орсон нутгийн иргэдийг тухайлан онцолсон байна. Тайлангаас үзэхэд цианид алдагдсан тухай ташаа мэдээлэл байнга тархдаг, бага оврын жижиг осол гарсныг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шийдвэрлэснийг компанид ажилладаг нутгийн иргэд онцолж байна. Цианид алдагдсан талаарх ташаа мэдээллийг залруулах үүднээс технологи, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг хэрхэн мөрдөж аюулгүй үйлдвэрлэл явуулдаг тухай дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгажээ.

Орон нутгийн шийдвэр гаргагчид, компанийн олон нийттэй харилцах албаны дарга нар Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, түүний хэрэгжилт, нийтийг хамарсан үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг өгчээ. Тус компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар орон нутгийн эрүүл мэндийн төв, сургууль, нутгийн иргэд, малчдын төлөөлөл байр сууриа илэрхийлж орон нутгийн бизнес эрхлэгчид тус компанид бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэх туршлагаа сэтгүүлийн уншигчидтай хуваалцсан байна. Эцэст нь, тус компанийн санхүүжилтээр, иргэдийн саналын дагуу орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийдэг “Баян Дөрвөлжингийн Өгөөж” орон нутгийн төрийн бус байгууллагын төлөөлөл хэрэгжүүлсэн ажил/төсөл, орон нутагт үлдэх үр өгөөжийн талаар дэлгэрэнгүй мэдээлжээ.

**Үндэсний хувийн компаниуд**

ТӨҮГ-ууд болон гадаадын/ГХО-тай компаниудтай харьцуулахад үндэсний 9 хувийн компаниас 5 нь л компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн мэдэгдэлдээ нийгмийн хариуцлагыг онцолсон ч ихэнх нь нийгмийн хариуцлагын талаар тусгайлсан цэстэй байна. Мэдээллийн гол мессежүүд нь байгаль орчны нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй, нийгэм-эдийн засгийн үр нөлөө, хандив тусламж, орон нутгийн дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг багтаажээ.

9 компаниас ердөө 2 нь жилийн/КНХ-ын тайлангаа нийтэлсэн, 4 нь "Мэдээ" булангаа шинэчилдэггүй. Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, олон нийтэд зориулсан хандив/хөрөнгө оруулалтынхаа талаар цөөн тооны мэдээ нийтэлжээ.  Зөвхөн “Энержи Ресурс” ХХК цахим хуудасны мэдээ мэдээллээ тогтмол шинэчилдэг бөгөөд 2022 оны 10-р сард Цогт-Овоо, Хан-Хонгор, Цогтцэций сумдад "Хариуцлагатай уул уурхайд иргэдийн оролцоо" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн 700 гаруй иргэнийг хамруулан, байгаль орчны менежмент, орон нутагт нийгмийн хөрөнгө оруулалт хийх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, иргэдээс асуулга судалгаа авч, нээлттэй ажлын байранд сонгон шалгаруулалт хийж, санал гомдлыг нь сонсон бичгээр авсан байна. Үүнээс гадна өдөрлөгт оролцогчдын байр суурийг мэдээндээ тусгажээ.

**Цахим хуудасны контент дүн шинжилгээний үр дүнгийн хураангуй**

Компаниуд нийгмийн хариуцлагыг эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн мэдэгдэлдээ онцлон тэмдэглэж, судалгаанд ашигласан түлхүүр үгс бүхий цэс/дэд цэстэй байна. Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын амлалтаа бүрэн хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах нь чухал. Гэвч цахим хуудасны агуулгыг судалж үзэхэд ихэнх уул уурхайн компани нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт ажлын байр, ханган нийлүүлэлтийн боломж бий болгох, боловсрол, эрүүл мэнд, соёл зэрэг тухайлсан салбарт санхүүгийн дэмжлэг (тэтгэлэг, хандив, тусламж хэлбэрээр) үзүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг нь онцгой анзаарагдана. Сургууль, цэцэрлэг шинээр барих, орон нутгийн дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх нь цахим хуудасны нийгэмд хандсан гол мессежүүдийн нэг байсан.

Цөөн компани албан ёсны цахим хуудсандаа энэ бүхнийг хэрэгжүүлэхдээ олон нийтийн оролцоог хангадаг гэсэн нотолгоо гаргаж өгчээ. Тухайлбал, “Оюу Толгой”, “Энержи Ресурс”, “Саусгоби Ресурс”, “Баян Айраг Эксплорэйшн” компани орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэхэд олон нийтийг татан оролцуулах бие даасан механизмтай. Ихэнх компани олон нийтэд зориулсан мэдээллийг цахим хуудсандаа нийтэлдэг бөгөөд орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээлэл түгээх материалын цөөн жишээг л судалгааны хүрээнд илрүүлэв.

## 4.4 Уул уурхайн сонины контент дүн шинжилгээний үр дүн

“Ил тод орон нутаг” сонин Монгол Улсад хамгийн олон тусгай зөвшөөрөл олгогдсон Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт явагдаж буй уул уурхайн олборлолт, ашиглалтын талаар тусгай дугаар (2022 оны I улирал) гаргасан байна. Харьцангуй уул уурхайн хайгуул, ашиглалтын баялаг түүхтэй тус сумын нутгийн иргэд, засаг захиргааны удирдлагын ойлголт, хандлагыг контент анализын судалгаагаар шинжлэхэд дараах үр дүн харагдана.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын дарга нь сумандаа олборлолт хийж буй компаниудтайгаа үл ойлголцсон хэвээр байгааг илэрхийлжээ. ИТХ-ын Н. Болдбаатарын “Бодит мэдээлэлгүй бол компани, иргэн, төр гурвын үл ойлголцол хэзээ ч арилахгүй” гэсэн ишлэл нь үл ойлголцол, хамтын ажиллагаа амжилтгүй байгаагийн үндсэн шалтгааныг тодорхойлж байна. Компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа ажлууд сумын бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд үр өгөөжөө өгдөггүй нь компаниудын хандив аймагт л очдогоос биш суманд наалддаггүй хамтын ажиллагааны үр дүнг нь үнэлжээ (“Ил тод орон нутаг” сонин, 2022 оны I улирлын дугаар).

Сумын засаг дарга уурхайн эдэлбэрт бэлчээрийн газраа алдаж, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь зөрчигдсөн, бэлчээрийн газар хайж буй олон малчдад хаалттай байгаа уул уурхайн бизнес эрхлэгчдийн тухай мэдээллийг ил тод болгохоор захирамж гаргаж, олон нийтэд шаардлагатай мэдээллийг хүргэж, ил тод байдлыг хангах үүрэгтэй Дэд зөвлөл байгуулсан аж.

*Шигтгээ 36 ОҮИТБС-ын санаачилгаар орон нутгийн засаг захиргаа мэдээллээ ил тод болгосон нь*

| |
|---|
| 2021 оны 10 дугаар сард Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын Ажлын албанаас санаачлан говийн бүсийн төр захиргааны байгууллага, компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлчдэд мэдээллийн ил тод байдлын ач холбогдол, хэрэгцээ, ашиглалтын талаар цахим сургалт зохион байгуулах үеэр Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгууд эдийн засгийн мэдээллүүдээ ил тод болгож байжээ. Эдгээр мэдээллүүд нь уул уурхайгаас орж ирж буй эдийн засгийн өгөөж, байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн өөрчлөлт, ажлын байрны асуудлыг хөндсөнийг чухалчлан аймаг, сумын удирдлагуудын цахим хуудсанд нийтлэхээр шийджээ. Орон нутаг, сумын түвшний эдгээр мэдээллийг ил болгосноор Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын Цогтцэций, Ханбогд, Өлзийт, Даланжаргалан, Гурвантэс сумдын Дэд зөвлөлүүд хамтран ажиллаж эхэлсэн тухай “Ил тод орон нутаг” сонин 2022 оны 1-р улирлын дугаартаа онцлон тэмдэглэжээ. |

Дэд зөвлөлд компани, иргэд болон иргэний нийгэм, төрийн байгууллага гэсэн гурван талын төлөөллийг тэнцвэртэй оролцуулах нь зөв хандлага. Даланжаргалан сумын Дэд зөвлөлийг байгуулсан ч компанийн төлөөлөлгүй, төрийн байгууллага нь давамгайлжээ. Энэ нөхцөл байдал бусад сумдад ч ижил байгаа нь сонины дараагийн дугаарын ерөнхий агуулгаас ажиглагдсан. Тухайлбал, Сүхбаатар аймгийн ИТХ-ын дарга Д. Хосбаяр дэд зөвлөлд талуудын оролцоо ижил биш байгаа нь иргэд болон компанийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гол саад болж буй хүчин зүйл гэж хүлээн зөвшөөрчээ. (“Ил тод орон нутаг” сонин, 2022 оны II улирлын дугаар.) Талуудын оролцоо жигд бус байгааг илэрхийлсэн түүний тайлбараас ажиглахад сумдын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд идэвхтэй Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийг оролцуулдаггүй байжээ. Нэгэнт иргэдийн төлөөллийг оролцуулдаггүй учраас орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулахад тухайн сум орон нутаг, иргэдийн санал тусдаггүй, гэрээний явц, хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэхэд иргэдийн хамтын оролцоо дутагдаж байсан. Иймд дэд зөвлөлд иргэдийн төлөөллийг жигд хамруулснаар уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилт орон нутагт хангагдах, ил тод хариуцлагатай уул уурхай зөв гольдролоор хөгжин орон нутагт үзүүлэх үр өгөөж дээшлэн, ажлын байр нэмэгдэж, дэд бүтэц хөгжинө гэж Д. Хосбаяр онцлон хэлжээ.

Монголд уул уурхай тойрсон асуудалд тухайн сумын нутгийн зөвлөл идэвхтэй оролцож байр сууриа илэрхийлдэг онцлогтой. Тухайлбал, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутгийн

зөвлөлийн дарга Д. Болортуяа уул уурхай эрхлэгчид ил тод байдлаа сайжруулах нь яагаад чухал болохыг компаниуд нутгийн иргэдтэй ойлголцож илүү сайн харилцаатай болсны дараа үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын ач холбогдлыг сурталчлан таниулах нь аль аль талд хэрэгтэй. Нөгөө талдаа сумын засаг захиргаа нийгэм болоод эдийн засгийн хөгжлийн дунд, урт хугацааны зорилтуудаа амжилттай шийдвэрлэхэд компаниуд нээлттэй хамтран ажиллах замаар итгэлцлээ бэхжүүлэх нь чухал гэж үзжээ. ("Ил тод орон нутаг" сонин, 2022-II улирлын дугаар.)

Харин Увс аймгийн Хар тарвагатайн уурхайн компанийн төлөөлөл нутгийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд компаниас гүйцэтгэж байгаа ажил, хөрөнгө оруулалт хангалттай байгаа гэж үзэж байна. Тус компанийн уурхайн нүүрс нь Монголдоо эхний гуравт орох чанарын үзүүлэлттэй юм. Компанийн зүгээс ахмадуудад мөнгөн хишиг хүртээх, цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих, цагаан идээ боловсруулах сургалтад малчин эмэгтэйчүүдийг хамруулах, иргэдэд нүүрс үнэгүй өгөх, спортоор хичээллэж байгаа спортын баг, тамирчдад шаардлагатай хэрэгсэл, өмсгөлөөр туслалцаа үзүүлэх зэргээ онцолжээ. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт ийм түвшинд байхад орон нутгийн иргэдтэй үл ойлголцол үүсдэг шалтгааныг "Хар тарвагатай" ХК-ийн ТУЗ-ийн дарга С. Баяржаргал сумын төсөвт уул уурхайн салбараас төвлөрүүлсэн АМНАТ, тусгай зөвшөөрлийн төлбөрөөс Сангийн яам орон нутгийн төсөвт маш бага хэмжээтэйг хуваарилж байгаатай холбон тайлбарлаж байна. "...Хэрэв төсөв, мөнгө нь сум, аймагтаа хуулийн заалтын хуваарилагддаг бол уул уурхайн компаниас заавал нэмэлт зардал нэхэн шаардахгүйгээр сум, орон нутгаа хөгжүүлээд явах бүрэн боломжтой" гэж тэрбээр тайлбарлажээ ("Эрдэс баялгийн тойм" сонин, 2020-XII сарын дугаар).

Малчдын баг, нөхөрлөлийн саналд үндэслэн компанийн зүгээс хамтран ажилласан түүх нь сайн туршлага болж байгааг сонинд онцолжээ. Тухайлбал, Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин Ч. Намнансүрэн нарын малчдын санаачилгаар үүсэн байгуулагдсан дэд зөвлөл нь компани-малчид-орон нутгийн удирдлага гэсэн гурван талын харилцан ойлголцолд тулгуурлан асуудлаа ярилцан шийдвэр гаргаад ажиллаж байгаа аж. Малчдын зүгээс гаргасан аливаа нэгэн гомдол, санал, хүсэлтийг тухайн асуудал бүр дээр гурван тал хэлэлцэж шийдэлд заавал хүрдэг нь сайн тал юм. Энэ амжилтын нууцыг малчдын төлөөллийг багийн иргэдийн нийтийн хурлаас сонгон дэд зөвлөлийн дотоод дүрэм, журмыг маш сайн хэлэлцэн боловсруулсантай холбон тайлбарлаж байна. ("Эрдэс баялгийн тойм" сонины 2021 оны VII сарын дугаар).

Уул уурхайн мэргэшсэн сэтгүүлч Г. Идэрхангай уул уурхайн компаниуд олон нийттэй харилцан ойлголцолд хүрч амжилттай хамтран ажиллах цаашдын хандлагыг: "Иргэд, малчдыг юм мэддэггүй гэж буруутгахаас илүүтэй тухайн компани тэдэнтэй нүүр тулсан, амьд уулзалт хийдэггүй, хатуухан хэлэхэд бултан зугтдаг, зайлсхийдэг нь байдлыг улам даамжруулдаг" онцолжээ. "Нөгөө талдаа орон нутгийн захиргаа иргэдэд тухайн компанийн тухай мэдээлэл өгөхдөө хойрго, аж ахуйн нэгжээс ирсэн албан бичиг, танилцуулга зэргийг нь албан өрөөний шүүгээндээ хав дардаг гэм бас бий. Талуудын мэдээллийн солилцоо ийм муу байдалтай, сэтгэлгүй хүмүүсийн балгаар иргэд уул уурхайн салбарыг муухайгаар харж сурчихсан, энэ нь үргэлжилсээр байвал уул уурхайн салбар тийм ч гоёор харагдахгүй" гэж нийтлэлдээ өгүүлжээ ("Эрдэс баялгийн тойм" сонины 2022-XI сарын дугаар).

Хүний эрхийн конвенцийн[16] дагуу тухайн тусгай зөвшөөрөлтэй талбай нь малчин өрхийн ашигладаг газарт давхцаж байвал нөхөн төлбөр олгох тухай заалт бий. Энэ өнөөдрийг хүртэл Монгол Улсад яагаад хэрэгждэггүй юм бэ? Даланжаргалан суманд уурхайн нөлөөллийн бүсэд байдаг, амьдрах аргагүй болсон олон малчдад 20 гаруй жилийн хугацаанд нөхөн төлбөр өгч,

---

[16] Хохирогчид нөхөн төлбөр авах эрхтэй. Энэ нь хохирогч эсхүл тэдний гэр бүл, түүнчлэн нөлөөлөлд өртсөн ард иргэдэд материаллаг болон бэлгэдлийн чанартай олон төрлийн ашиг тусыг хүртээх замаар хүний эрхийн зөрчлийг арилгах арга хэмжээг хэлнэ. Нөхөн төлбөр нь хангалттай, үр дүнтэй, шуурхай байх ёстой бөгөөд зөрчлийн хүнд байдал, учирсан хохиролтой дүйцэхүйц байх ёстой. Үүнд нөхөн төлбөр, нөхөн олговор олгох, нөхөн сэргээх, сэтгэл ханамж авах зэрэг орно.

нүүлгэн шилжүүлэлт хийсэн нэг ч тохиолдол байдаггүйг мөн сонинд дурджээ.

Сонинуудын агуулгаас нэгтгэн дүгнэвэл уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл нутгийн иргэдэд дутмаг байгаа нь компани болон нутгийн иргэдийн үл ойлголцлын гол шалтгаан мөн. Энэ зөрчлийг арилгахын тулд сумдад нутгийн иргэд, нутгийн удирдлага, компанийн төлөөллөөс бүрдсэн салбар зөвлөл байгуулах нь зүйтэй. Зөвлөлийн гол зорилго нь сумын удирдлага, иргэдийн саналыг компанийн нийгмийн хариуцлагын гэрээнд тусгуулах, талуудад мэдээлэл хүргэх, үл ойлголцлыг арилгахад оршино. Харамсалтай нь талуудын тэгш оролцоог хангаагүйгээс нэгэнт байгуулагдсан салбар зөвлөлүүд хүссэн үр дүндээ хүрч ажиллаж чадахгүй тохиолдол элбэг, салбар зөвлөлүүд Ханбогд сумын сайн жишээнээс суралцаж үйл ажиллагаандаа тусган сайжруулах боломж судалгааны энэ түвшинд тодорхой харагдаж байна.

## 4.5 Олон нийтийн санаа бодол, ойлголтын судалгаануудад хийсэн дүн шинжилгээ

Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, 2022: Монгол Улс дэлхийн 180 орноос 29.6 оноогоор 155 дугаар байранд жагссан нь байгаль орчны стандартыг дагаж мөрдөх үзүүлэлт маш доогуур түвшинд байгааг харуулна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх байдлаар дэлхийн 180 орноос 14.6 оноогоор 178-р байранд орсон. Монгол орны хувьд малчдын амьжиргаа нь бэлчээр, усны нөөцөөс шууд хамааралтай тул байгаль орчны доройтол нь ноцтой тулгамдаж буй асуудал мөн.

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлан, 2022: Тайлан аймгуудын өрсөлдөх чадварыг эдийн засгийн тогтвортой байдлаар нь үнэлж эрэмбэлдэг. Уг үзүүлэлтээр Орхон, Дархан, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар аймгууд эхний 5 байранд, Завхан, Булган, Дундговь, Архангай, Говь-алтай аймгууд сүүлийн 5 байранд эрэмбэлэгджээ. Хэнтийгээс бусад аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 10. Аймгуудын өрсөлдөх чадварын индекс.*

| Аймгуудын өрсөлдөх чадвар | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Дархан | 96 | 94.02 | 89.42 | 96.1 | 85.93 |
| Өмнөговь | 94 | 97.85 | 87.52 | 92.07 | 85.33 |
| Завхан | 54 | 54.63 | 38.14 | 36.8 | 45.14 |
| Баянхонгор | 55 | 48.24 | 62.26 | 53.54 | 49.03 |
| Ховд | 54 | 59.76 | 69.65 | 70.42 | 50.06 |
| Дорнод | 84 | 87.14 | 73.44 | 78.49 | 74.83 |
| Увч | 75 | 71.65 | 81.46 | 77.59 | 59.08 |
| Хэнтий | 71 | 70.53 | 69.29 | 78.19 | 76.02 |

Монгол дахь уул уурхай, олон нийт болон усны талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг судлах эцсийн шатны үнэлгээ, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), 2021: Тайланд тусгаснаар уул уурхайн компаниуд олон нийтэд нээлттэй, хамтын ажиллагаа явуулдаг. КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн улмаас олон нийтийг хамарсан ямар ч арга хэмжээ зохион байгуулагдаагүй нь орон нутгийн иргэд ба уул уурхайн компаниудын хоорондын харилцаанд нөлөөлж болзошгүй. Уул уурхайн үйл ажиллагаа явагддаг орон нутгийн удирдлагууд эерэг, харин уул уурхайгүй аймгийн удирдлага, мэргэжилтнүүд илүү сөрөг байр суурьтай байна.

Олон нийтийн санаа бодлын судалгаа: IRI болон IRIM, 2022: Монгол Улсад хамгийн их тулгамдсан асуудлыг судалгаанд хамрагдсан иргэдийн 60 орчим хувь (58 % нь амьжиргааны өртөг, 26 % нь ажилгүйдэл, 14 % нь бусад эдийн засгийн асуудал) нь макро эдийн засагтай холбосон санал өгчээ. “Авлигын талаарх мэдлэг, ойлголтын талаарх судалгаа”-гаар сүүлийн 10 жилийн 9-д нь газар зохион байгуулалттай холбоотой байгууллагууд авлигын асуудлаар тэргүүлж, уул уурхайн болон хууль сахиулах байгууллагууд удаалсан байдаг.[3] Монголд авлигын түвшин өндөр байгаа нь ардчиллыг сөргөөр үнэлэхэд хүргэсэн, уул уурхайн салбараас хэт хамааралтай улс төрийн нөлөөлөл үүссэн зэргийг судалж тодорхойлсон.

Олборлох үйлдвэрлэлийн салбарт орон нутгийн иргэдийн ойлголт, санаа бодол нь байгаль орчны гүйцэтгэлтэй нягт уялдаатай,байгаль орчны малчдын уул уурхайн компанид итгэх итгэлийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг болж байна. (Дагвадорж нар, 2018). Монгол Улс байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтээр маш доогуур буюу 180 орноос 29.6 оноогоор 155-р байранд жагссан (Байгаль орчны гүйцэтгэлийн индекс, 2022) нь ерөнхийдөө олон нийт уул уурхайгаас олсон ашгийн тэгш бус хуваарилалтад сэтгэл дундуур байдгаас үүдэлтэй (Мядар ба Жексон,

2019).

Бизнесийн эрсдэл: Олон нийт уул уурхайг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдолд уул уурхайн компаниуд томоохон хэмжээний эрсдэлтэй нүүр тулгарах нь элбэг. Сүүлийн хорин жилийн хугацаанд олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд орон нутгийн иргэдийн маргаан зөрчилдөөнтэй тулгарч үйл ажиллагаагаа зогсоон хойшлуулсны улмаас асар их алдагдал хүлээж компаниуд нэр хүнд, нийгэм, улс төрийн эрсдэлтэй тулгардгийг олон улсын хэмжээнд ч хүлээн зөвшөөрдөг (Давис & Франкс, 2011; Мютти нар., 2012; Тааруф-Эсбенсен, 2020). Дэлхий даяар хил дамнасан компаниуд олон нийтэд ил тод, оролцоог хангасан хариуцлагатай хандлагыг бизнесийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг болжээ.

## 4.6 Байгууллагуудын ажлын болон судалгааны тайлан, гарын авлагад хийсэн дүн шинжилгээ

Доор иш татсан тайлангуудад тусгаснаар цөөн компаниуд олон нийтийн хүлээлтийг хангасан байгаль орчныг хамгаалах олон улсын туршлагыг хэрэгжүүлдэг. Олон улсын байгууллагаас уул уурхайн төслийн зөвшөөрлийг зөвхөн олон нийтийн дэмжлэгтэй үед, өөрөөр хэлбэл компани үйл ажиллагаа явуулах нийгмийн тусгай зөвшөөрөлтэй үед л олгохыг зөвлөдөг.

Монгол Улсын тогтвортой байдлын төлөв (2018): Газар нутгийн бараг 77 хувьд ургамлын бүрхэвч өөрчлөгдсөн байна. Уул уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэх нь газрын доройтол, ургамлын зүйлийн регрессийн төлөвт бага ч гэсэн нөлөөлсөн. Монгол Улсын олборлох уул уурхайн салбарын байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэл харилцан адилгүй байдаг нь томоохон уул уурхайн компаниудын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах олон улсын стандарт туршлагыг нэвтрүүлэх эерэг хандлагатай байдгаас харагдана. Засгийн газар уул уурхайн салбарын хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй нөлөөллийн зардлыг системтэй үнэлж, шийдвэрлэх талын ажил бараг хийгээгүйг тайланд дурджээ. Сүүлийн үед цөөхөн компани л тогтвортой байдлын тайланг тогтмол гаргаж байгааг Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Бизнесийн зөвлөлөөс мэдээллээ.

Хариуцлагатай уул уурхайн индекс (2020): Хариуцлагатай уул уурхайн сан (RMF) нь хүний эрх, оролцогч талуудын оролцоо, орон нутгийн эдийн засгийн үр өгөөж, эрсдэлийн үнэлгээ зэрэг олон нийтийн сайн сайхан байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, компаниуд уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдардаг ард иргэд болон бусад бүлгүүдтэй хамтран ажиллах тал дээр ямар хэмжээний арга хэмжээ авч байгааг үнэлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Рио Тинтогийн Монгол дахь Оюу толгойн уурхай нь нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын бие даасан аудитын тайлангаа олон нийтэд ил тод мэдээлж, засч залруулах арга хэмжээг санал болгодог тул үнэлгээгээр хамгийн өндөр оноог (75 %) авсан.

Орон нутгийн худалдан авалт нь нөлөөлөлд өртсөн иргэдийн хувьд эдийн засгийн чухал ач холбогдолтой юм. Уурхайн 30 % (75) нь орон нутгаас гаралтай бараа, үйлчилгээнд зарцуулсан мөнгөний хэмжээг олон нийтэд ил тод мэдээлсэн боловч маш цөөхөн уурхай (14) нь орон нутгаас худалдан авч буй бараа, үйлчилгээний төрлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлсэн байна. Үнэлгээнд хамрагдсан 40 компанийн 37 нь байгаль орчин, нийгэм, захирганы ядаж нэг үзүүлэлтээр сайжирч, илүү сайн практик загваруудыг санал болгож байна. Үүнд хүний эрхийг хүндэтгэх, хээл хахууль, авлигаас урьдчилан сэргийлэх албан ёсны зохицуулалтыг бий болгох, байгаль орчин, нийгэм, захирганы гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулах, нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлд зохих шалгалт хийх, засгийн газарт төлөх төлбөр болон ажлын байрны аюулгүй байдлын зөрчлийг олон нийтэд мэдээлэх зэрэг орно.

IGF тайлан, 2023: IGF-ийн саяхан гаргасан “Тохиолдлын судалгаа: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННҮ) зөвлөлдөх, оролцохын ач холбогдол” тайланд БОННҮ-г төслийн төлөвлөгөөнд нөлөөлөх шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах чухал арга хэрэгсэл хэмээн онцолж IGF уул уурхайн төслийн зөвшөөрлийг зөвхөн олон нийтийн дэмжлэгтэй үед л олгохыг зөвлөжээ. Төсөл олон нийтийн дэмжлэггүйгээр батлагдвал засгийн газруудад үзүүлэх

дэмжлэг, итгэл алдагдана (IGF 2022). Хэрэв төслийн үр ашгийг нөлөөллийн бүсийн иргэд хүлээн зөвшөөрөхгүй бол уурхайн үйл ажиллагаа зөрчилдөөн, бусад хууль ёсны болон хууль бус үйлдлүүдтэй тулгарах магадлалтай.

Монгол Улсын уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээний тайлан 2017: IGF-ийн үнэлгээний тайланд Монголын уул уурхайн салбарын томоохон давуу ба сул талуудыг тодорхойлжээ (IGF, 2017). Сул талуудыг зассанаар Монголын уул уурхайн салбар улсдаа хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зам руу орох боломжтой юм. Эдгээр сул тал нь их хэмжээний, эрсдэлтэй уурхайн хог хаягдлуудын усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, түүний менежментийг сайжруулах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой. Уг тайланд уурхайн нөлөөллийн бүсийн ард иргэдэд үр өгөөж хүртээхийн тулд уул уурхайн компаниудад орон нутгийн засаг захиргаатай гэрээ хэлэлцээр хэрхэн боловсруулах, зохицуулах талын ойлголт бага, уул уурхайн мөчлөгийн үе шат бүрт нөлөөлөлд өртсөн оролцогч талуудтай зөвлөлдөх шаардлага дутмаг, уул уурхайн бүтээн байгуулалтын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг тогтмол баримтжуулах тогтолцоо бүрдээгүйг онцолжээ.

Засгийн газар бичил уурхайг албан ёсны болгоход хүчин чармайлт гаргаж байгаа ч жижиг, том уурхайчдын хоорондын зөрчилдөөнийг урьдчилан сэргийлж, таслан зогсоодоггүй. Хууль бусаар ашигт малтмал хулгайлан олборлогч нинжа нар малчдын хотхоноос мод, хоол хулгайлсан, ойролцоох гэрт амьдардаг эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн гэх мэт эрүүгийн хэргүүд бүртгэгдсэнээс гадна байгаль орчныг үлэмж ихээр сүйтгэж байна.

Хэнтий, Дорнод аймгуудын уул уурхайн хамгаалалт, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн баримт судалгааны ажлын тайлан, 2019: Уул уурхайн үйл ажиллагаа нь цар хүрээ, шинж чанараас үл хамааран байгаль орчин, бэлчээр хийгээд амьжиргаа нь бэлчээрийн мал аж ахуй. усны нөөцөөс хамааралтай ард иргэдэд сөргөөр нөлөөлж байна. Төрийн байгууллагуудад байгаль хамгаалагчдын хөдөлмөрийг үнэлж, дэмжих талаар хангалттай ойлголт, зөв хандлага байдаггүй. Монголын олборлох салбарын мэдлэг хязгаарлагдмал, хүний эрхийг дээдлэх хүсэл эрмэлзэл дутмаг. Нутгийн удирдлагууд хүний эрхийн зөрчлөөс, тэр дундаа газрын эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалж буй иргэдийн эсрэг заналхийлсэн үйлдлээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх тал дээр үр дүнгүй байдгийг тус төлөөлөгчийн газар илрүүлжээ (Форум-Ази, 2019).

Коронавирусийн халдвар (COVID-19)-ын Монголын уул уурхайн салбарт үзүүлсэн нөлөө, судалгааны үр дүнгийн танилцуулга, 2022: COVID-19 Монголын уул уурхайн салбарт сөргөөр нөлөөлж 2020 онд уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай бодит ДНБ 9.4 хувиар буурчээ. Тухайлбал, ашигт малтмалын экспорт (үнийн өсөлтөөс шалтгаалан зөвхөн алтны экспорт 3 дахин өссөн) 17.6 % багасч, нүүрсний экспортын хэмжээ огцом буурсан.

Уул уурхайн 2826 компаниас ердөө 252 нь уурхайн үйл ажиллагаанд КОВИД-19-ийн үзүүлсэн нөлөөллийн судалгаанд хариулт өгчээ. Судалгаагаар уул уурхайн компаниудын 64.7 %-д Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх хүндрэлтэй байсан нь тогтоогджээ. Олон компани үйлдвэрлэл, борлуулалт, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалтын асуудалтай тулгарч, тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрсэн. Уул уурхайн салбарын өсөлт нь КОВИД-19-ийн дараах эдийн засгийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ (Рагчаасүрэн, 2022).

Уул уурхайн шийдвэр гаргахад оролцогч талуудын оролцооны үнэлгээний тайлан, 2017 он: Нутгийн иргэдийн сумандаа үйл ажиллагаа явуулж буй уурхайн мэдлэг, мэдээлэл нь орон нутгийн удирдлагуудын мэдлэг, мэдээлэлтэй харьцуулахад харьцангуй доогуур иргэдийн 75.2 хувь, төрийн албан хаагчдын 15.5 хувь нь хангалтгүй мэдээлэлтэй. Орон нутгийн иргэдийн 2.6 % нь уурхайн үйл ажиллагааны талаар маш сайн мэдээлэлтэй, 22.2 % нь уурхайн үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээлэлтэй, 80 гаруй хувь нь шилжилт хөдөлгөөн, нөхөн төлбөрийн талаар мэдээлэл дутмаг байгаагаа илэрхийлжээ. Уул уурхайн туршлага муу, жижиг, дунд уул уурхайн компаниуд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зөв үнэлдэггүй, байгаль орчны үр дагаврыг үл тоомсорлодог, хамгийн сүүлийн шатанд орон нутгийн иргэдтэй зөвлөлддөг нь хамтын ажиллагааг

үр дүнгүй болгож байна.

Уул уурхайд итгэх итгэл буурахад нөлөөлж буй хүчин зүйлсэд:

- Компаниуд болон орон нутгийн засаг захиргаа уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, соёлын нөлөөллийг багасгахад тун сул хүчин чармайлт гаргадаг.
- Орон нутгийн иргэдэд байгаль орчинд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийн талаар мэдээлэл өгдөггүй.
- БОНБҮ тайлангийн хэлэлцүүлэгт иргэд өөрсдөө ирэхийг урьсан ч оролцдоггүй
- Уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргааны аль аль нь орон нутгийн иргэдийн санал, гомдлыг барагдуулдаггүй зэрэг орно.

Уул уурхайн компаниудад тулгарч буй бэрхшээлүүдэд:

1. Иргэд цуу ярианд итгэж, үндэслэлгүй, боломжгүй шаардлага тавьж, эсэргүүцдэг.
2. Иргэд хайгуул, ашиглалт гэж ялгадаггүй учраас эсэргүүцэх нь элбэг.
3. Орон нутаг, нийслэлийн хэмжээнд уул уурхайн хөгжлийн нэгдсэн бодлого байхгүй.
4. Улс төрийн тогтворгүй байдал уул уурхайн үйл ажиллагаанд нөлөөлдөг ба эдгээр сорилтуудыг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжүүдийг компани болон орон нутгийн засаг захиргаанд санал болгон тайланд тусгажээ.

Бие даасан тайлангийн механизм (IRM): Монгол Улсын шилжилтийн үр дүн (2019-2021): Монгол Улсын гурав дахь Нээлттэй засаглалын түншлэлийн (OGP) үйл ажиллагааны хөтөлбөр (2019–2021) нь 13 амлалтаас бүрдсэн. Монгол Улс мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа иргэдийг “мэдээлэх” доод босго заалтаа биелүүлээгүй. Иргэний нийгмийн оролцогч талууд засгийн газар ба иргэний нийгмийн хооронд ямар ч харилцаа байхгүй, иргэний нийгэмд шийдвэр гаргахад нөлөөлөх, заалтуудын хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл авах боломж байхгүйг мэдээлсэн (Равио Патра, 2021). Ерөнхийдөө олон салбарт төрийн худалдан авах ажиллагаанд иргэд, ИНБ-ын оролцоо хязгаарлагдмал, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны ил тод байдал, үүнтэй холбоотой иргэдийн оролцоо, хяналт хязгаарлагдмал, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, гэрээний тоо зэрэгт ил тод байдлыг хангах зохицуулалт тун хязгаарлагдмал байгааг илтгэлд дурджээ. Тухайлбал, мэдээллийн сан шинээр нэвтрүүлээгүй, хог хаягдлын менежмент, экологийн хариуцлага, хог хаягдлын эх үүсвэрийн талаар мэдээлэл өгөөгүй. Олборлох салбартай холбоотой ганцхан амлалт хэрэгжсэн нь олборлох салбарт ашиг хүртэх өмчлөлийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчны заалт бөгөөд ОҮИТБС-аас мэдээллийн сан шинээр үүсгэн хэрэгжүүлсэн.

## 4.7 Уул уурхайн онцлох үйл явдлын талаарх мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Нэн тэргүүнд онцлох зүйл бол Монгол Улсын Засгийн газар уул уурхайн салбарын хэвийн үйл ажиллагааг алдагдуулан ноцтой хохирол учруулж, эсэргүүцэл олон нийтийн зүгээс нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрсөн юм. Тэгвэл уул уурхайн талын иргэдийн ойлголт муу, мэдээлэл бүрэн бус байдгаас улбаалж уул уурхайн компаниуд эсэргүүцэлтэй тулгардаг хэмээн эрдэс баялгийн салбарын мэдээ мэдээллээр дагнасан Mongolian mining journal сэтгүүл чуулганы өдрүүдэд бичиж байв.

Малчдын төлөөлөл хэлэхдээ “Монголын уул уурхайн салбарын аль ч шатанд иргэдийнхээ оролцоог хангадаггүй, иргэдээ сонсдоггүй, бүрэн мэдээлэл өгдөггүй” гэв.

Уул уурхайн компаниудын гаргадаг нийтлэг алдаа нь иргэдтэй уулзалгүй сумын Засаг даргатай нь эхлээд уулзаж ярилцдаг байна. Ийнхүү “Танайд ганц цэцэрлэг барьж өгье” гэдэг байдлаар хэлэлцээ хийгээд газрыг нь ухаж, гол усных нь голдирлыг өөрчлөөд эхэлдэг тухай Экологийн цагдаагийн албаны төлөөлөл илтгэлдээ дурджээ.

Харин иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл уул уурхайн салбарт сонсох ажиллагааг огт явуулдаггүйг хэрэгжүүлдэг болох, хэрэгжилтэнд олон нийтийн оролцоог эрс сайжруулах

шаардлага чухал байгааг онцолсон. Засгийн газраас явуулж буй бодлого ард түмний санаа бодол хүсэл зорилгод тулгуурлаагүй учир орон нутгийн бид нар дэмжих боломжгүй гэсэн үгийг орон нутгийн удирдлагын төлөөлөл хэлэлцүүлгийн үеэр илэрхийлжээ.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн төслийг олон нийтэд нээлттэй болгохыг оролцогчдын зүгээс идэвхтэйгээр санал болгожээ. Учир нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р зүйлд аливаа хуулийн төслийн талаарх мэдээллийг хүссэн хүн бүхэнд ил тод мэдээлэх зохицуулалт тусгасан байдаг. Мөн Хууль, тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөлтэй танилцах, саналаа өгөх үйл явцыг зохицуулсан. Орон нутаг дахь иргэд, захиргаа, компанийн хамтын ажиллагааг бий болгох, үл ойлголцол, зөрчлийг шийдвэрлэх, байгаль орчны нөхөн сэргээлт хийх гэх мэт хамтын оролцоонд тулгуурласан харилцааг дээрх хуулийн төсөлд тусгах ёстой юм.

Олон нийтийн хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, иргэдийн ойлголтыг сайжруулах, ойлголцох чиглэлээр санаачилгыг ихэвчлэн төрийн байгууллага болон гадаадын мэргэжилтнүүд санал болгосон. Тухайлбал, АМГТГ-ын төлөөлөл орон нутагт уул уурхайн олборлолт эхлэхээсээ өмнө уурхайн хаалтын төлөвлөлтийн зураг төсөл, үүнд зарцуулах зардлыг байршуулсан байх зохицуулалтыг Ашигт малтмалын хуулийн төсөлд тусгахаар ажиллаж буйг дуулгасан.

Чуулганаар санал болгосон бусад улс орнуудын сайн туршлагаас манай улсад хэрэгжүүлж болох нэгэн чухал санааг олон улсын зөвлөхүүд хуваалцжээ. Компаниуд ажиллах гэж буй орон нутагтаа төлөөлөгчөө түрүүлж илгээн тухайн орон нутагт тулгарч буй асуудал, тогтвортой хөгжлийн асуудал зэргийг нь судлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл тэдний дуу хоолойг сонсож, хэрэгцээг нь мэдэх хэрэгтэй гэж зөвлөжээ.

Компаниудын төлөөлөл далд уурхайн үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчин, нутгийн иргэдийн соёл болон нийгмийн хандлагыг зайлшгүй харгалзаж үзэхээс өөр аргагүй гэдгийг онцолжээ.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс уул уурхайн салбарын эрх зүйн орчныг дэлхий нийтийн шинэ хандлага, ногоон хөгжил, хариуцлагатай, ил тод засаглалын шаардлагад нийцүүлж сайжруулах, орон нутгийн иргэд болон ирээдүй хойч үеийнхэн хүртэх хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш боломж, баялгийн шударга хуваарилалтыг бий болгоход анхаарах байр сууриа илэрхийлсэн.

Уул уурхайн  компани ямар бүтээн байгуулалт хаана хийх, байгаль орчны нөхөн сэргээлт хэрхэн хийх, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах, орон нутагт ямар үр өгөөжтэй байх гэх мэт мэдээллийг нээлттэй өгвөл мэдээлэлтэй иргэд уул уурхайн бүхий л түвшний ажиллагааг ойлгож, зөрчил маргаан үүсэхгүй байж болно гэсэн санааг Экологийн цагдаагийн алба шийдэл болгон дэвшүүлсэн.

Чуулганы үр дүнд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд уурхайн хаалт хүртэлх бүх шатанд мэдээллийг ил тод болгох нь иргэдтэй ойлголцолд хүрч, тэдний оролцоог хангах хамгийн зөв арга зам гэдэг дээр бүгд санал нийлсэн бөгөөд эдгээр асуудлыг Засгийн газар уг хуулийн шинэчлэлдээ тусгана хэмээн ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан хэлсэн.

## 4.8 Анхдагч мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Анхдагч мэдээлэл буюу ярилцлага хэлэлцүүлгийн үр дүнг үндсэн болон нэмэлт асуудлуудын хүрээнд шинжиллээ. Үүнд:

Үндсэн асуудал:

1. Олон нийтийн оролцоог хангах, орон нутагтай хамтран ажиллах, мэдээлэл хүргэх ажлуудын үр дүн
2. Олон нийтийн ойлголт хандлагатай холбоотой эрсдэлүүд

3. Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл хүргэх ажлууд үр дүн багатай байсан шалтгаан, тулгарч буй сорилтууд

Нэмэлт асуудал:

4. Сумын түвшинд хамгийн үр дүнтэй, түгээмэл хэрэглэгддэг мэдээлэл харилцааны арга замууд
5. Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл хүргэх сайн туршлагууд
6. Орон нутгийн нөхцөл байдал (ярилцлага, хэлэлцүүлэг явагдсан 2 сумын хүрээнд)

Асуудал тус бүрийн хувьд үр дүнг дараах дэд бүлгүүдэд авч хэлэлцсэн ба дэлгэрэнгүй шинжилгээг оролцогч тал бүрээр Хавсралт 4 Ярилцлагуудад хийгдсэн шинжилгээний хүснэгт-т харуулсан болно.

### 1.8.1 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх ажлуудын үр дүн

Олон нийтийн оролцооны тухай ойлголт, соёл Монголд барууны хөрөнгө оруулагчид орж ирснээс хойш дөнгөж бий болсон билээ. Үүнээс хойш олборлох салбарын тухай ойлголт нэмэгдэж, олон нийтийн оролцооны ач холбогдлыг талууд илүү сайн ойлгон жил ирэх тутам улам сайжирч байгааг таван жилийн үзүүлэлтүүдийг харьцуулсан судалгаа тодруулан харуулж байна. Том компаниуд КНХ-ын хүрээнд үйл ажиллагааныхаа эхлэлд иргэдэд мэдээлэл өгч, хамтран ажиллаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх алхмуудыг өөрсдийн боломж, хүчин чадлын хүрээнд хийж гүйцэтгэж байгаа ч КНХ-ыг хэрэгжүүлдэггүй жижиг дунд компаниуд олон.

Судалгааны анхдагч мэдээлэлд үндэслэн орон нутагт олон нийтийн оролцоог хангах, хамтран ажиллах 4 хэлбэрийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. “Орон нутгийн удирдлага, уул уурхайн компани хооронд байгуулсан Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ” ил тод байх;
2. “БОНБҮ-ний хэлэлцүүлэг: судалгааны үр дүнгээс харахад иргэдийн оролцоо маш хязгаарлагдмал;
3. “Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг”-ийг “Оюу Толгой” компани орон нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулдаг нь итгэлцлийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй нь амьдралд харагдсан, одоогоор 1-2 компани л хэрэгжүүлж байна;
4. “Санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх механизм”: зарим компани албан ёсоор хэрэгжүүлдэг.

"Орон нутгийн иргэдэд очих мэдээллийн урсгал хязгаарлагдмал, уул уурхайн нөлөөллийн бүсийн ихэнх иргэд тодорхой мэдээлэл авч чаддаггүй. Компанийн олон нийтэд өгч буй мэдээллүүд ихэвчлэн татвар төлөлт, үндэсний эдийн засагт оруулсан хувь нэмэр зэрэг ерөнхий мэдээлэл байдаг нь орон нутгийн хэрэгцээ шаардлага, хүлээлтэд нийцдэггүй.

### 4.8.2 Олон нийтийн ойлголт хандлага, холбогдох эрсдэлүүд

Анхдагч мэдээллийн үр дүнгийн боловсруулалтаар компаниуд газар, ус ашиглалтын асуудалд хариуцлагагүй хандсан, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үүрэг амлалтаа биелүүлээгүйгээс орон нутгийн иргэдийн дунд сөрөг ойлголт хандлага бий болдог харагдана. Байгаль орчны доройтлоос болж уул уурхайн компаниудад итгэх итгэл буурч байна. Үүнтэй холбоотой айдас болгоомжлол өндөр байгаагаас орон нутгийн иргэд сумандаа бүх хэлбэрийн уул уурхай, хайгуулын үйл ажиллагааг эсэргүүцэх хандлагатай болсон. Орон нутгийн иргэд илүү мэдлэг мэдээлэлтэй, болгоомжлолтой болсон ба авлигын асуудлаас болж орон нутгийн удирдлагаа хардах ч нөхцөл үүсдэг аж. Ийнхүү буруу ташаа, өнгөц, дутуу мэдээлэл авснаар иргэд уул уурхай, хайгуулын үйл ажиллагаанд үл итгэх, сөрөг хандлага бий болж байна.

Орон нутгийн иргэд өөрсдөд нь мэдээлэл хүргэлгүй уул уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх, дараа

нь нөхөн сэргээгээгүй ухсан нүх, овоолсон шороо үлдээдэг, КНХ-аа хэрэгжүүлдэггүй зэрэг асуудлаас болон бухимдаж, улмаар энэ салбарыг эсэргүүцэх үндэс суурь эхлэл бий болдог. Зэргэлдээх сумдад хариуцлагагүй уул уурхайгаас үүдсэн байгаль орчин, нийгмийн сөрөг үр дагаврууд өөрсдийнх нь суманд давтагдана гэсэн айдас болгоомжлолтой болсон. Уул уурхайн компаниуд болон уул уурхай хариуцсан төрийн төв байгууллагад итгэх иргэдийн итгэл сул, орон нутгийн удирдлага, багш, мэргэжилтэн зэрэг итгэлтэй хөндлөнгийн хүмүүсийн өгсөн мэдээлэлд илүү итгэх хандлагатай. Компаниуд зөвхөн нөлөөллийн бүсийн цөөн айл өрхөд анхаарал хандуулж, тухайн сум багийн бусад өрхийг орхигдуулдаг нь иргэд сэтгэл дундуур байх үндсэн шалгаан нь ажээ.

Хөндлөнгийн ашиг сонирхлын улмаас буруу ташаа, улс төржүүлсэн мэдээлэл тараах нь түгээмэл энгийн үзэгдэл болсон. Нийгэмд уул уурхайтай холбоотой дуулиант мэдээлэл тархахад сөрөг хандлагатай хүмүүсийн улам эсэргүүцэх байр суурь ихсэх хандлагатай болж, бусад хэсэг нь зөв буруу нь мэдэгдэхгүй хэт их мэдээллээс залхдаг нь олон нийтийн оролцоо улам сулрах эрсдэлтэй байж болох юм.

Зарим нэг хариуцлагагүй уул уурхайн компанийн ба хууль бусаар ашигт малтмал хулгайлан олборлогч нинжа нарын үйл ажиллагааны нөлөөллөөр бий болсон олон нийтийн сөрөг хандлагаас үүдсэн орон нутгийн эсэргүүцлээс болж геологи хайгуулын үйл ажиллагаа хумигдан орон нутагт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн санхүүжилттэй геологийн судалгааны төслүүд зогсоход хүрч байна.

### 4.8.3 Олон нийтийн оролцоо, мэдээлэл харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлс

**<u>Мэдээлэлтэй холбоотой асуудлууд:</u>**

**Олон нийт сөрөг мэдээлэлд илүү ойр байдаг.** Уул уурхайтай холбоотой олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явж буй мэдээ мэдээлэлд эдийн засгийн үр өгөөж зэргийг багтаасан тэнцвэртэй мэдээлэл гэхээс илүүтэй зөрчил маргаан, хариуцлагагүй уурхай зэрэг сөрөг мэдээлэл илүү давамгайлдаг.

**Орон нутгийн түвшинд найдвартай мэдээлэл, мэдээллийн эх сурвалж дутмаг.** Оролцогч талуудын хувьд мэдээллийн үнэн зөвийг ялгахад тун хүндрэлтэй байдаг нь ихэнх мэдээлэл нийгмийн сүлжээ мэтийн баталгаагүй маш олон сувгаар тардаг. Орон нутгийн иргэд Засаг дарга, ИТХ-ын гишүүд, гэр бүл, танил талаасаа аман /цуу яриа/ мэдээлэл авдаг нь мэдээллийн эх сурвалж нь хувь хүн учир бүрэн итгэлтэй, аль нэг талын сонирхол эрх ашгийг илэрхийлээгүй мэдээллийн эх үүсвэр байж чадах эсэх нь эргэлзээтэй. Орон нутгийн түвшинд иргэдийн оролцооны ганц механизм нь ИТХ бөгөөд хязгаарлагдмал тооны гишүүдтэй учир хангалттай үр дүн бүхий мэдээлэл, оролцооны хэлбэр байж чаддаггүй.

**Баримт нотолгоотой, үнэн мэдээлэл дутмагаас болж буруу мэдээлэл ам дамжин тархдаг.** Орон нутгийн иргэд уул уурхайн мэдлэг мэдээлэл дутмаг, ялангуяа компаниудын жинхэнэ эзэн нь хэн болох, орон нутгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулах, ямар эрсдэлүүд учирч болох, тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний талаар мэдэхийг хүсдэг. Хариуцлагагүй уул уурхайгаас гадна хариуцлагатай нь олон байгааг мэдэлгүйгээр байгаль орчны доройтол, авлига, хээл хахууль мэтийн сөрөг мэдээлэл түлхүү ам дамжин тархдаг.

**Санаатайгаар буруу ташаа мэдээлэл тараах.** Уул уурхайн салбар нь их мөнгө эргэлддэг маш том ашиг сонирхлуудын нөлөөнд байнга автаж байдаг салбар тул ганц эх сурвалжаас ирсэн мэдээлэл бодит үнэн, найдвартай байхаасаа илүүтэй аль нэг хүн байгууллага, хүчний ашиг сонирхлыг агуулсан байх магадлал маш өндөр. Энэ нь орон нутгийн иргэдэд очих мэдээллийн урсгалыг хязгаарлахад хүрдэг. Орон нутгийн тэр дундаа нөлөөлөлд өртсөн айл өрхүүд үнэн зөв мэдээлэл авч байж мэдээлэл, харилцаа, ойлголцол илүү эрүүл бодит харилцан итгэлцэлтэй байх

болно.

**Оролцогч талуудын дунд мэдээллийн тэнцвэртэй байдал дутмаг.** MERIT төслөөс явуулсан сургалтын хүрээнд давхардсан тоогоор 3000 оролцогчоос авсан санал асуулгаар олон нийтийн дунд давамгайлаад буй сөрөг хандлагын үндсэн шалтгаан нь бүрэн бус, буруу ташаа, хоорондоо зөрчилдсөн мэдээллээс болдог гэсэн үр дүн гарчээ. Компаниуд тодорхой бус, дутуу мэдээлэл хүргэснээс үүдэж иргэд орон нутгийн удирдлагаа компаниудаас хахууль авсны улмаас байгаль орчны сөрөг нөлөөлөл нэмэгдэж байна хэмээн хардах нөхцөл үүсдэг. Мэдээлэл хүргэх, оролцоог хангахдаа тэнцвэртэй байдлыг хангаснаар УУХҮЯ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, уул уурхайн компани, орон нутгийн удирдлагын эрх ашиг нэгэн цэгт огтлолцож уулзах харилцан ойлголцол, итгэлцэл бий болох боломж бүрдэнэ.

**Иргэд, байгууллага бэлэн нээлттэй мэдээллийг ашигладаггүй.** Тусгай зөвшөөрөл болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны ажлууд холбогдох яам, агентлагийн цахим хуудсан дээр ил тод байршдаг. ОҮИТБС-аас 13 жилийн турш шаардлагатай нарийвчлал, харьцуулалт бүхий 150 төрлийн мэдээлэл бүхий мэдээллийн санг бүрдүүлжээ. Харамсалтай нь, олон нийт уг баялаг мэдээллийн санд нэвтэрч ашигладаггүй, хүсдэг ч үгүй. Тэр байтугай, төрийн байгууллагууд нь ч бодлого төлөвлөлтдөө уг нээлттэй өгөгдлийг ашигладаггүй.

**Мэдээллийн эрэлт, нийлүүлэлт зөрүүтэй.** Дээд шатны байгууллагууд иргэд уул уурхайн компаниас ямар мэдээлэл хүсээд байгааг мэддэггүй, компани болон орон нутгийн удирдлага ч энэ талаар судалж мэддэггүй. Компаниуд нь зөвхөн татвар төлөлт, улсын төсөвт оруулж буй орлогоо мэдээлдэг. Үнэндээ энэ төрлийн мэдээлэл уул уурхайн нөлөөлд өртсөн жирийн малчин иргэнд шууд хамааралгүй тул тэд орон нутгийнхаа бэлчээр, зам, ус ашиглалтын мэдээллийг түлхүү авах хүсэлтэй байдаг.

**Олон нийт эмх цэгцгүй хэт их мэдээллээс залхдаг.** Зарим тохиолдолд ялангуяа нийгмийн сүлжээгээр болон ам дамжин тархсан эмх замбараагүй мэдээллээс олон нийт залхахад хүрдэг. Үүнээс болоод зарим иргэд тухайлбал, Өмнөговь аймгийнхан уул уурхайн судалгаанд хариулт өгөн оролцох сонирхол нь илт буурсан нь салбарт хандах сөрөг хандлага олон нийтийн дунд илүү тархах эрсдэлийг бий болгож байна.

**Буруу ташаа мэдээллээс болж орон нутгийн иргэд хохирч, цөөн хэдэн хүнд давуу тал үүсдэг.** Буруу ташаа мэдээллээс болж олон нийтийн санаа бодол өөр зүг рүү чиглэх тохиолдол маш их. Жишээ нь, Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайн “Friendship Resources” ХХК 800 сая төгрөгөөр орон нутагт цэцэрлэг барьж хүлээлгэн өгсөн байтал уг цэцэрлэгийг тухайн сумаас сонгогдсон УИХ-ын гишүүн барьж байгуулсан гэсэн худал мэдээлэл орон нутгийн иргэдийн дунд тархжээ.

**<u>Харилцаа, хамтын ажиллагааны асуудлууд:</u>**

**Иргэдтэй харилцахдаа харилцааны тохиромжгүй арга барил ашигладаг.** Зарим тохиолдолд компанийн төлөөлөгчийн хийсэн буруу мэдэгдэл, дутуу мэдээллээс үүдэж үл ойлголцол үүсч, сөрөг хандлагыг улам бүр гүнзгийрүүлэхэд хүрдэг. Нэгэн хайгуулын компанийн ажилтан малчин иргэнд “хэрвээ та манай хайгуулын ажлыг эсэргүүцвэл, танай хүүхдийн мөнгө олгогдохгүй” гэж хэлсэн нь иргэдийн эсэргүүцэл улам нэмэгдэх эрсдэл үүссэн жишээг судалгаанд оролцогчдын төлөөлөл дурджээ.

**Орон нутагт оролцогч талуудын уялдаа холбоо сул.** Компаниуд мэдээллийг аймаг, сумын удирдлагад хүргэсэн ч мэдээлэл нь багийн түвшинд хүрч очихгүй байх тохиолдол их. Мэдээлэл албан тушаалтнуудын шүүгээнд цоожлогдон үлдэж цааш дамжихгүйд хүргэдэг албан тушаалтны эс үйлдэл нь оролцогч талууд тухайлбал багийн удирдлага, иргэд чухал мэдээлэл, үйл ажиллагаанаас хоцрох шалтгаан нь болдог.

**<u>Орон нутгийн оролцогч талуудын чадавхтай холбоотой асуудлууд:</u>**

**Орон нутагт хүний нөөц дутагдалтай.** Уул уурхайн талаар томоохон асуудал, эсэргүүцэл тэмцэл гараагүй л бол УУХҮЯ орон нутагт хүрч ажиллаж чаддаггүй. Нэг хүн олон ажил үүргийг давхар хариуцдагаас болж, уул уурхайн асуудалд бүрэн анхаарал хандуулах боломж хомс. Тухайлбал, аймгийн уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн ОҮИТБС-ын санаачилгаар байгуулагдсан олон талт дэд зөвлөлийн ажлын хэсэгт давхар ажилладаг.

**Засгийн газраас орон нутгийн засаг захиргаатай уялдаа холбоотой ажиллахад дэмжлэг үзүүлэх асуудал дутмаг.** Сум, багийн засаг дарга нар иргэдэд ямар мэдээлэл хүргэх, мэдээллээ хэрхэн дамжуулах, талуудын оролцоог хэрхэн хангах талаар ойлголт бага, бараг байхгүйтэй адил. Талуудын оролцоог дэмжих бодлого стратегигүй. Орон нутгийн албан хаагчид төсөл, хөтөлбөрүүдийн санаачилсан олон талын оролцоот арга хэмжээ, уулзалт, хэлэлцүүлгээс талуудын оролцоог хэрхэн дэмжих талаар тодорхой мэдээлэл, дэмжлэг авдаг. Хамтран суралцаж, сурснаа хэрэгжүүлэх нь орон нутгийн албан хаагчдын идэвх, санаачилга, оролцоог нэмэгдүүлэх сайн талтай.

<u>**Хууль эрхзүйн зохицуулалттай холбоотой асуудлууд:**</u>

**Орон нутгийн түвшинд шийдвэр гаргалтад нөлөөлөх эрх мэдэл сул.** Орон нутгийн удирдлага уул уурхай, хайгуулын асуудлаар шийдвэр гаргалтад нөлөөлж чаддаггүй. Шинэчилсэн хуулийн зохицуулалтаар орон нутгийн удирдлага уул уурхайн асуудлаар шийдвэр гаргалтад нөлөөлөх эрх мэдэл нь хумигдаж, ИТХ шийдвэр гаргах эрх мэдэл нь хязгаарлагдсан тухай онцолжээ.

**БОНБҮ-нд олон нийтээс санал авах хугацаа хангалтгүй.** БОНБҮ-нд орон нутгийн иргэдээс санал авах хуулиар олгогдсон ажлын 30 хүртэлх хоног нь санал цуглуулах, хэлэлцэх, Засгийн газарт эргэн хариу өгөхөд хангалттай хугацаа байж чаддаггүй нь орон нутгийн удирдлага, иргэд хоорондын харилцаанд асуудал үүсгэдэг.

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох явц ил тод бус.** Энэхүү мэдээлэл орон нутагт хүрдэггүй тул олон нийтийн итгэл улам суларч, уул уурхай, хайгуулын ажлыг эсэргүүцэх гол хүчин зүйл болжээ.

**Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо сул.** Газрын харилцаа, Кадастрын албаны мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоо зарим тохиолдолд сул байдгаас олгогдсон тусгай зөвшөөрлийн талбай малчдын өвөлжөө, хаваржаатай давхцах асуудал үүсдэг. Хуулийн хүрээнд харилцан тохиролцож нүүлгэн шилжүүлэх, түүний зардал эсвэл нөхөн төлбөр олгох нь амьдрал дээр хэрэгждэггүй нь судалгааны үр дүнгээс харагдана.

<u>**Компанийн засаглалтай холбоотой асуудал:**</u>

**Орон нутагт ажиллаж буй компанийн ажилтнуудын шийдвэр гаргах эрх мэдэл дутмаг.** Ихэнх тохиолдолд уул уурхайн компаниудын олон нийттэй харилцах алба болон байгаль орчны нэгжүүд үндсэн үйл ажиллагаандаа туслах үүрэгтэй байдаг учир талбар дээр шийдвэр гаргах эрх мэдэлгүй. Жижиг, дунд компаниуд байгаль орчин, олон нийттэй харилцах, хөдөлмөрийн эрүүл ахуй-аюулгүй байдал зэрэг асуудлуудыг ихэвчлэн нэг хүнд хариуцуулдаг. Тухайн мэргэжилтэн нь иргэдээс ирсэн санал гомдол, хүсэлтийг удирдлагадаа уламжлан мэдэгдэх үүрэг хүлээдэг. Орон нутгийн иргэд тухай бүрд нь хариу шийдвэр өгөхгүй тохиолдолд үл ойлголцол, үл итгэлцэл үүсч асуудал даамжирдаг байна.

<u>**Хүний нөөцийн асуудал:**</u>

**Хүний нөөцийн чадавх, хүрэлцээ хангалтгүй.** Олон нийттэй харилцах чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг компаниуд авч ажиллуулахгүй, Монголд энэ чиглэлийн мэргэжилтнүүд хангалттай бэлтгэгдээгүй дутмаг. Орон нутгийн иргэдтэй харилцаж буй компанийн төлөөлөгч нар энэ чиглэлээр мэргэшээгүй, ажлын талбарын туршлагадаа үндэслэж ажил үүргээ гүйцэтгэж байна. Ихэнх тохиолдолд байгаль орчны мэргэжилтнүүд олон нийттэй харилцах ажил үүргийг хариуцдаг

ч тэд үнэндээ технократ инженерүүд юм. Өөрсдийн мэргэжилдээ хэдий сайныг үгүйсгэхгүй ч харилцааны ур чадвар нь хангалтгүй байж болно. Зөвхөн байгаль орчны асуудлаар нутгийн иргэдтэй зөвлөлдөн мэдээлэл өгөх хурал, уулзалт хийж байх үеэр нийгмийн асуудлуудыг орон нутгийн иргэд хөнддөг. Зүй нь энэ тохиолдолд хариуцсан мэргэжилтэн нь компанийнхаа бодлого, стратеги, менежмент, санхүүгийн талын хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байх ёстой төдийгүй иргэдийн санал хүсэлт, гомдол шаардлагад газар дээр нь хариу өгч, шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой аж.

**<u>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээтэй холбоотой асуудлууд:</u>**

**Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ ил тод бус.** Орон нутгийн удирдлагууд уул уурхайн компанитай байгуулсан хамтын ажиллагааны гэрээгээ ил тод болгодоггүй. Магадгүй иргэдийн хамгийн их мэдэхийг хүсэж буй асуудлууд энэ гэрээнд тусгагдсан байж болох талтай. Харамсалтай нь, ОҮИТБС-ын 16 дахь тайланд дурдсанаар уул уурхай хөгжсөн аймгууд гэрээгээ ил тод болгох тал дээр учир дутагдалтай гэжээ. Сайн туршлагын жишээнд орон нутгийн хамтын ажиллагааны гэрээгээ ил тодоор нийтэд хүртээлтэй болгодог Сэлэнгэ, Булган, Төв, Завхан аймгуудыг нэрлэжээ.

**Орон нутгийн хамтын ажиллагааны сайн гэрээ байгуулах ойлголт дутмаг.** Орон нутгийн удирдлагууд гэрээний нэг загварыг хуулж ашиглах тохиолдол элбэг. бол компаниуд нь зөвшөөрөл авахын тулд л гэрээ байгуулдаг. Ийм байдлаар байгуулагдсан гэрээ нь орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагыг тусгаагүй, өнгөц гэрээ болдог.

### 4.8.4 Сумын түвшинд хамгийн түгээмэл хэрэглэгддэг мэдээлэл харилцааны хэлбэрүүд

Үндэсний болон орон нутгийн түвшинд явуулсан чанарын судалгаагаар орон нутагт, өөрөөр хэлбэл сум, багийн түвшинд хамгийн түгээмэл хэрэглэгддэг мэдээлэл харилцааны арга хэрэгслүүд нь Facebook групп чат, нийгмийн сүлжээн дэх постууд, үүрэн холбооны мессеж, багийн иргэдийн нийтийн хурал юм. Тухайлбал, бичил уурхайчид нийгмийн сүлжээгээр дамжуулан дээвэр байгууллагаасаа мэдээлэл авдгаа хэлжээ.

Нийгмийн сүлжээнд суурилсан харилцаа нь зар болон богино хэмжээний мэдээлэл түгээхэд үр дүнтэй ч нүүр тулсан харилцаа буюу хурал, уулзалтыг найдвартай мэдээлэл олж авах гол хэрэгсэл, арга зам мөн судалгаанд оролцогчид үзэж байна.

Зорилтот хэрэглэгчдэд мэдээлэл түгээх илүү үр дүнтэй арга нь хэвлэмэл материал буюу өдөр тутмын сонин, сэтгүүл, компанийн бэлдсэн брошюр-тараах материал байж болох юм.

### 4.8.5 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх сайн туршлага

**Иргэдийн оролцоотой усны мониторинг.** Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, итгэлцлийг бий болгох нэг арга зам нь иргэдийн оролцоотой мониторингийн хөтөлбөр бөгөөд цөөн хэдэн компани хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, “Оюу Толгой” ХХК “Хил хязгааргүй алхам” ТББ-тай хамтран зохион байгуулжээ. Хамтын оролцооны энэхүү хэлбэр, үйл явц нь гуравдагч тал хяналтаа тавьж, орон нутгийн иргэд өөрсдөө оролцож, үнэн зөв тайлан гаргадаг тул үр дүнтэйд тооцогдоно.

**Амжилттай байгуулсан орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ.** Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг хэлэлцэх шатанд иргэдийг хамруулж, саналыг нь тусгасан жишээнүүд бий. Тухайлбал, Булган аймгийн Бүрэгхангай сумын удирдлага иргэд болон компаниудыг орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах явцад оролцуулж идэвхи гарган ажилладаг.

**Харилцан ашигтай олон талт оролцоо.** Бодит байдалд орон нутгийн иргэд, оролцогч талуудыг нэг дор цуглуулах амаргүй. MERIT төслөөс орон нутгийн удирдлагатай хамтран сумын төв дээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулжээ. Орон нутгийн иргэд, малчдад эрүүл мэнд, иргэний бүртгэл зэрэг төрийн үйлчилгээг хүргэхийн хамт уул уурхайн мэдээллийг хүргэснээрээ

онцлог буюу компани, орон нутгийн удирдлага, иргэд гээд нийгмийн бүх талуудын төлөөллийн оролцоог хангахыг эрмэлзсэн үр ашигтай арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал, хэдэн жилийн дараа ирээдүйн шийдвэр гаргагчид болно гэдэг үүднээс ахлах ангийн сурагчдыг ч мөн урин оролцуулжээ. Нэг цэгт төрөл бүрийн мэдээлэл, төрийн үйлчилгээний цэгүүд ажиллаж, хоёр өдөрт давхардсан тоогоор 500 орчим хүн сонирхон оролцож, ~250 хүн иргэний бүртгэлийн үйлчилгээ авчээ..

**Иргэд мэргэжлийн байгууллагын өгсөн мэдээлэлд илүү итгэдэг.** Дээр өгүүлсэн нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр орон нутгийн усны мэргэжилтэн усны чанар, хүртээмжийн талаар мэдээлэл өгч, орон нутгийн усны түвшинг хэрхэн хэмждэг арга зүйг тайлбарлахад нутгийн иргэд мэргэжлийн байгууллагын мэдээлэлд илүү итгэж байсан хандлага илт мэдрэгджээ.

**Уурхайн хаалтын талаар эрт мэдээлэх.** Уурхайн хаалтыг иргэдийн оролцоотой төлөвлөх нь хаалтын зардлыг хэмнэж, олон нийтийн дунд итгэлцлийг бэхжүүлэх ач холбогдолтой. Учир нь, өмнөх цаг үеийн хариуцлагагүй уурхайнуудын жишээнээс болж өөрөөр хэлбэл олон нийтийн дунд уурхайн хаалтын үйл ажиллагааны ойлголт дутмаг, баялгийг ашиглаж дуусаад дараа нь ухсан нүхнүүд л үлддэг гэсэн ойлголт хандлага бий болсон.

**Хамгийн эрэлт ихтэй мэдээлэл.** Ажлын байр, худалдан авалтын мэдээллийг иргэд хамгийн ихээр сонирхдог учир Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг компаниуд бүсийн өдөрлөг зохион байгуулж, ажлын байр, худалдан авалтын мэдээлэл өгч, ажлын байрны хүсэлтүүд цуглуулдаг.

**Мэдээллийн сан бүрдүүлэх замаар орон нутгийн худалдан авалтыг дэмжих.** 2022 онд ОҮИТБС мэдээллийн сандаа мах, сүү, ногоо, зөгийн бал зэрэг орон нутгийн бүтээгдэхүүний мэдээллүүдийг нэмэн оруулжээ. Уг мэдээлэлд үндэслэн компаниудтай гэрээ хийхдээ орон нутгийн удирдлага иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжин гэрээнд тусгахад нь тус дөхөмтэй байдаг аж.

**Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах, хянах чадавхыг бэхжүүлэх.** “Нээлттэй нийгэм форум” орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ хийх чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2014 оноос хойш орон нутагт тогтмол зохион байгуулж, цахим хуудсан дээрээ гарын авлагуудаа байршуулж иржээ. Үүний сацуу орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэнд хяналт хийх аргачлал боловсруулж, ТББ-уудтай хамтран хэрэгжүүлж байна. бас нэгэн үр дүнтэй төсөл нь төрийн өмчит компаниудын худалдан авалтын зэрэг уул уурхайтай холбоотой гэрээнүүдийг ил тод нээлттэй мэдээлэл болгох ажлуудыг хийж байгаа явдал юм.

**Зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл түгээлт.** ОҮИТБС-ын ажлын албанаас “Ил тод орон нутаг” нэртэй сонины хоёр дугаарыг эрхлэн гаргаж зорилтот орон нутгийн иргэдэд тэнцвэртэй, найдвартай мэдээлэл хүргэх арга хэмжээ авчээ. Эхний дугаар нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд чиглэсэн ба 300 хувийг “Хил хязгааргүй алхам” ТББ-аар дамжуулан тараагджээ. Хоёр дахь дугаарыг нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын иргэдэд “Нутгийн Зөвлөл” ТББ-аар дамжуулан 1000 хувийг тараасан. Сониныг иргэд ихэд сонирхож байсан ба гол сорилт нь орон нутгийн удирдлагаас мэдээлэл олж авахад хүндрэлтэй байжээ.

**Иргэний нийгмийн үүрэг оролцоо**. Монгол Улс ОҮИТБС-ын стандартын хэрэгжилтээр 70 буюу харьцангуй доогуур үнэлгээ авсан ч ТББ-ын үүрэг оролцооны хувьд өндөр онооны үнэлгээтэй байна. Аймгийн орлогч дарга нарын ахалсан ОҮИТБС-ын олон талт дэд зөвлөлийн үйл ажиллагааны түвшин орон нутагт харилцан адилгүй. Жишээлбэл, Сүхбаатар аймгийн дэд зөвлөл үр дүнтэй ажилладаг гол шалтгаан нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн төлөөлөл болох “Их бага баян шарга” ТББ ба орон нутгийн удирдлагууд нь уул уурхайн компаниуд хариуцлагатай ажиллахад хамтран бүгд идэвх чармайлт гарган хамтран ажилладагт оршино.

### 4.8.6 Судалгаанд хамрагдсан орон нутгийн нөхцөл байдал

Төслийн баг төлөвлөгөөний дагуу 3-р бүлэгт дурдсанчлан АМЕП 2 хөтөлбөрийн “Эрдэс баялгийн салбарын үнэ цэнийг нэмэгдүүлэх нь” төслийн зорилтот 3 сумаас 2-г нь сонгон авч анхдагч мэдээллийг цуглуулсан. Эдгээр сум газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, соёл зэрэг өөр өөрсдийн онцлогтой байлаа. Харин нийтлэг шинж нь уул уурхайн үйл ажиллагаа тэр дундаа томоохон болон бичил уурхай аль алинд нь байдаг. Сум тус бүрийн онцлог, нөхцөл байдлыг доор тайлбарлав.

*Шигтгээ 4. Хулд сумын онцлог.*

**Дундговь аймгийн Хулд сум:**

Хулд суманд бичил уурхайн олборлолт эхлэхээс өмнө буюу 2015 оноос өмнө орон нутгийн иргэд өөр сум, аймгийн төв рүү ажил хайж нүүх тохиолдол түгээмэл байсан учир хүн амын тоо буурч байжээ. (Жишээ нь, сумын ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн нэг ахлах ангид 3 сурагч суралцаж байв) Харин орон нутгийн иргэдэд бичил уурхайн хэлбэрээр олборлолт явуулах боломж нээгдсэнээс хойш сумын хүн ам, сургуулийн хүүхдийн тоо нэмэгджээ.

Бичил уурхайн үйл ажиллагааг хязгаарласнаас шалтгаалан сумын хэмжээнд ажилгүйдлын түвшин эргэн нэмэгдэж, залуучуудын ихэнх нь сумаас шилжин явжээ. Уг шилжих хөдөлгөөнд бичил уурхайг хязгаарласнаас гадна орон нутгийн засаг захиргааны дэмжлэг хангалтгүй, суман дахь боловсролын чанар тааруу байгаа нь бас нөлөөлжээ.

Бичил уурхай эрхлэх асуудлыг зохицуулсан Засгийн газрын .... оны ...-р сарын ....-ний өдрийн №...тоот тогтоолоор хуульд нийцсэн тохиолдолд бичил уурхайн нөхөрлөл тухайн ордыг бүрэн ашиглах боломж бий болсонд бичил уурхай эрхлэгчид сэтгэл хангалуун байна. (Талбарын мэдээлэл цуглуулалтын үед уг тогтоолын танилцуулга бичил уурхай нөхөрлөлүүдийн дунд зохион байгуулагдаж байв.)

Хулд сумын бичил уурхайн нөхөрлөлүүд орон нутгийнхан нөхөн сэргээлт, дүйцүүлэх нөхөн сэргээлт, хог хаягдлын менежмент, мод тарих үйл ажиллагаанд зориулан сумын нөхөн сэргээлтийн санд хандив өгдөг. Өөрсдийн тоног төхөөрөмжөөр сумын бичил бизнест дэмжлэг үзүүлнэ гэсэн хүлээлт ч иргэдийн дунд байна.

*Шигтгээ 5. Бүрэгхангай сумын онцлог.*

**Булган аймгийн Бүрэгхангай сум:**

Бүрэгхангай сум нь Булган аймгийн бусад сумтай харьцуулахад ашигт малтмалын нөөц элбэг, ан амьтан, говь хангай хосолсон үзэсгэлэнтэй байгалиараа онцлог. Улс, аймгийн алдар цолтнууд олноор төрөн гарсан сум бөгөөд хамгийн алдартай хүн нь Дандар баатар юм. Сумын бүх төрийн болон төсвийн байгууллагууд ямар нэгэн алдар цуутай хүний нэрэмжит байдаг. Бүрэгхангай сум нь эрийн гурван наадмын нэг төрөл үндэсний сурын харвааг орон нутгийн брэнд спорт болгосон, хамгийн залуу сур харваач 6-7 настай. 2023 оны зун Бүрэгхангай сум 100 жилийн ойн баяр тохион бэлтгэл ажил нь эхэлсэн харагдана.

Бүрэгхангай сумын төв нь Булган аймгийн бусад сумдаас хамгийн түрүүнд дэд бүтцэд холбогдсон сум юм. Бүрэгхангай суманд ашигт малтмалын нөөцөө даган уул уурхай хөгжсөн нь сайн талтай зүйл боловч сөрөг талууд их байна.

Эерэг тал: Орон нутгийн иргэд ажлын байртай, орлоготой болж, сумын хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна.

Сөрөг тал: Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл.

Одоогийн байдлаар сумын газар нутагт алт олборлодог 10, хайгуулын 10 компани үйл ажиллагаа явуулж байна. Талбарт ажиллан мэдээлэл цуглуулах үед уул уурхайн компаниуд хариуцлагатай олборлолт, хамтын ажиллагааны гэрээгээ биелүүлдэг байдал харилцан адилгүй байгаа нь ажиглагдав. Орон нутгийн гаралтай компанийн хувьд нутгийн засаг захиргаа, иргэдтэй илүү ойр дотно, тогтмол харилцаа, хамтын ажиллагаатай байдаг бол бусад томоохон компаниудын хувьд БИНХ-аар, БОНБҮ -ний танилцуулгаар өгсөн амлалтаа бүрэн биелүүлдэггүй. Орон нутгийн иргэд болон удирдлагууд тухайн компаниуд хамтын ажиллагааны гэрээгээ биелүүлж орон нутагт хөрөнгө оруулдаггүй хэрнээ сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан их хэмжээний орлого олж байгаа гэсэн хандлагатай/хардалттай байдаг. Уул уурхайн компаниуд сумын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулах зэрэг хамтын ажиллагааны гэрээнд туссан үүргээ биелүүлбэл талууд уул уурхайн компанийн талаар эерэг ойлголттой болно.

Орон нутгийн иргэд тахилгат, шүтдэг газар уул усных нь ойролцоо уул уурхайн компани ажиллаж эхэлбэл маш их эсэргүүцдэг. Жишээ нь “Бүргэд” нэртэй сумын бөхчүүдийн тахин, шүтдэг уулын энгэрт “Номадик групп” нэртэй уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж эхлэхэд тухайн багийн иргэд 2022 оны зуны турш эсэргүүцэж байсан.

# 5 Зөрүүний шинжилгээ

Судалгааны үр дүнд үндэслэн, олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх ажлуудын одоогийн нөхцөл байдал болон зорилтот түвшин хоорондын ялгааг тодруулах замаар зөрүүний шинжилгээг боловсруулав. Өөрөөр хэлбэл, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангаж, орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай боловч хангагдаагүй хэрэгцээг доорх дүн шинжилгээгээр гаргаж ирлээ.

Мөн энэ салбарт илүү үр өгөөжтэй, шинэлэг харилцаа, хамтын ажиллагааны стратегийг боловсруулахад чиглэсэн сайжруулах арга замуудыг тусгав.

Доорх шинжилгээг боловсруулахад орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааны гурван хэлбэр (Нэг талт-Transactional[17], Хоёр талт-Translational[18] Хамтарсан-Transformative[19])-ийг харгалзан үзсэн болно.

## 3.1 Олон нийтийн оролцоог хангах, хамтран ажиллах

БОНБҮ боловсруулахад орон нутгийн иргэдийн оролцоог хуулиар зохицуулж өгсөн бөгөөд БОНБҮ болон ОНХАГ нь иргэдийн хувьд санал бодол, тулгамдсан асуудлаа илэрхийлэх боломж юм.

*Хүснэгт 1. Уул уурхайн төслийн БОНБҮ-ний явц дахь иргэдийн оролцоо ба зөрүүний шинжилгээ.*

| Арга зам | Одоогийн нөхцөл байдал | Зорилтот түвшин* | Хангагдаагүй хэрэгцээ | Тайлбар | Сайжруулах зөвлөмж, арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-н дэх иргэдийн оролцоо** | Мэдээлэл өгдөггүй, Хожуу мэдээлдэг, Зөвлөлддөггүй, Зөвлөлдсөн ч санал бодлыг тусгадаггүй, Асуудал шийдэгддэггүй, Оролцоог | Эртнээс мэдээлэл өгч, оролцоог хангадаг байх; Зөвлөлддөг байх; Санал бодлыг тусган хариу өгдөг байх; Асуудлыг зөвлөлдөн шийдвэрлэдэг байх; Хамтран төлөвлөдөг байх, Шат дараалалтай урт | Харилцаа, холбоо дутмаг, Мэдээлэл дутмаг, Бэлчээр, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл тодорхойгүй, Тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхгүй байх, Иргэд уул уурхайн компаниудад итгэх | Зөвлөлдөх уулзалтын талаар цөөхөн иргэд мэдээллээр хангагдах, Тулгаж мэдэгдэх,<br><br>Иргэд өргөнөөр хамрагдах боломжгүй үеэр | 1. Оролцоог өргөн хүрээнд хангах үүднээс зөвлөлдөх уулзалтыг урьдчилан мэдэгдэж, нөлөөллийн бүсийн иргэдэд оролцох боломжтой уулзалтын цаг, өдрийг харилцан тохирч сонгох,<br>2. Мэдээллийн олон сувгаар зар тараах, иргэдийг урих, оролцоог уриалах, уулзалтыг дахин сануулах,<br>3. Уул уурхайн компаниуд/БОНБҮ-ний компаниуд танилцуулгаа иргэдэд мэдээлэл өгөх үүднээс энгийн хэллэг, нэршлээр ойлгож магадгүй боловсролын түвшинд нь тааруулан бэлтгэдэг байх,<br>4. БОНБҮ-ний гол тулгамдсан асуудлуудыг урьдчилж |

[17] Өгч авах, солилцох тохиролцоо. Ямар нэгэн эргэж буцах харилцаа байхгүй. Итгэлцэл байхгүй, шууд өгч авах тохиролцоо.
[18] Тодорхой хугацаа, түвшинд хамтран ажиллах харилцаа, үйл явц, хамтарч юм хийх харилцаа
[19] Харилцан итгэлцэл, хүндэтгэл дээр тулгуурласан харилцаа; хувьсан өөрчлөгдөх, боломж олгодог түншлэл хөгжүүлэх, хамтдаа хөгжих, аль аль талдаа ашигтай байх удаан хугацааны харилцаа.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хангадаггүй | хугацааны хамтын ажиллагаа хөгжүүлэх, Тэгш оролцоог хангадаг байх | итгэл сул эсвэл огт итгэдэггүй, Эргэх холбоо, хамтын ажиллагаа байхгүй, | товлох, Мэдээллийг боловсруулах, эргэцүүлэн бодох хангалттай хугацаа байхгүй | иргэдэд мэдээлэх нь мэдээллийг уншин танилцаж, эргэцүүлэх, шалгах боломжийг иргэдэд олгох ба нухацтай (constructive) санал хүсэлт илэрхийлэх боломж иргэдэд бий болно, 5. Уулзалтад хамрагдах боломжгүй малчид, иргэдээс бичгээр санал хүсэлтийг авдаг байх, 6. Нөлөөллийн бүсийн/нөлөөлөлд өртөх магадлалтай малчид, иргэдийг идэвхтэй сонсох, үйл ажиллагаанд заавал татан оролцуулах |
| **Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ (ОНХАГ)-н дэх иргэдийн оролцоо** | Төсөл хэрэгжихээс өмнө иргэдийн оролцоог хангаагүй Төсөл хэрэгжих явцад оролцоог хангаагүй Хэрэгжилтийн талаар мэдээлэлгүй, хяналт шинжилгээ хийгдээгүй | Ажлын байр, орон нутгийн худалдан авалтын боломжуудын талаарх мэдээлэл хүргэх Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, төлөвлөгөө, иргэдэд очих үр өгөөжийн талаар мэдээлэл өгөх Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, төлөвлөгөөний талаар мэдээлэл өгөх | Төсөл хэрэгжихээс өмнө болон хэрэгжих хугацаанд зөвлөлдөх уулзалт хийгдээгүй | ОНХАГ ил тод биш | ОНХАГ-г олон нийтэд ил нээлттэй болгох ОНХАГ-ний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих Нутгийн иргэдээс санал хүсэлт авах ОНХАГ-ний төлөвлөгөө, ажлуудад нутгийн иргэдийг боломжит хэмжээнд татан оролцуулах ОНХА-нд иргэдийн оролцоог хангах бие даасан арга хэрэгслийг ашиглах |

## 3.2 Уул уурхайн компаниудын орон нутгийн удирдлага болон иргэдтэй хамтран ажиллах арга зам

*Хүснэгт 2. Уул уурхайн төслийн ОНХАГ-д иргэдийн оролцоо ба зөрүүний шинжилгээ.*

| Зорилго | Одоогийн нөхцөл байдал | Зорилтот түвшин* | Хангагдаагүй хэрэгцээ | Тайлбар | Сайжруулах зөвлөмж, арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ (ОНХАГ)** | Нэг загвар дээр үндэслэн ОНХАГ-г байгуулдаг, Ил тод биш ОНХАГ нь орон нутгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөөтэй | Компаниудын оруулсан хувь нэмэр орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжихэд чиглэгддэг байх, Орон нутгийн хөгжлийн урт хугацааны хөтөлбөрт багтсан | ОНХАГ боловсруулах нөхцөл, гэрээнд гарын үсэг зурсан талуудын эрх үүрэг, хариуцлагын талаар олон нийтэд мэдээлэл өгдөггүй | ОНХАГ-г цахим хэлбэрээр байршуулаагүй, Гэрээг олж авахад хүндрэлтэй, | Цахим хэлбэрээр гэрээг унших, хэвлэх боломжтой байх Хэрэгжилтийн талаар мэдээлэх, ОНХАГ-тэй холбоотой уулзалтуудад иргэдийн оролцоог хангах, ОНХАГ-ний хэлэлцүүлэгт иргэдийн төлөөллийг оролцуулж санал авах, хэлэлцсэний үндсэн дээр гэрээнд тодорхой шаардлагыг тусгах. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | уялдаж буй эсэх нь тодорхойгүй | байх | | | |
| **Компанийн нийгмийн хариуцлага (КНХ)** | Тодорхой хэмжээний хандив тусламж үзүүлж, тэтгэлгийн боломжоор хангадаг,<br>Жижиг үйл ажиллагаа, санаачилгыг дэмжих,<br>Орон нутгийн хөгжилд нөлөө, оролцоогүй,<br>Төлсөн татвар хураамж, хандивын талаар зөвхөн орон нутгийн удирдлагад тайлагнадаг,<br>Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсныхаа дараа иргэдтэй уулзалт хийдэггүй | Орон нутгийн хэрэгцээг илүү сайн ойлгодог байх,<br>Орон нутгийн иргэдийн тэргүүлэх чиглэл болон сумын хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг байх,<br>Иргэдийн оролцоо бүхий хяналт, үнэлгээ хийдэг байх: Иргэдийн оролцоонд суурилсан шинжлэх ухаан[20] | Уул уурхайн компаниуд орон нутагтай тогтоосон шууд харилцаа, холбоо байхгүй,<br>Мэдээлэл ихэвчлэн орон нутгийн удирдлага, төлөөллөөр дамжин иргэдэд хүрдэг. | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр КНХ-аа таниулан сурталчлах,<br>Орон нутгийн удирдлага, засаг захиргаа, иргэдэд мэдээлэл өгдөг байх, | Компанийн стратегийн бодлого төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, орон нутагтай хамтран ажиллах бодлого төлөвлөгөөг тусгах,<br>Нутгийн иргэд, малчидтай зөвлөлдсөний үндсэн дээр ОНХАГ-г боловсруулах<br>Орон нутагт тулгарч буй нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудалд шийдвэр гаргах эрх мэдлийг олон нийт хариуцсан мэргэжилтэнд олгох,<br>Орон нутгийн иргэд, удирдлагатай харилцаа, хамтын ажиллагааг тогтооход мэргэжлийн эсвэл зохих мэдлэг туршлагатай хүнийг томилох,<br>Иргэдийн оролцоотой мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулах,<br>Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах: харилцан нэгнээ таньж мэдэхэд чиглэсэн арга хэмжээ (албан бус байж болно)-г зохион байгуулах,<br>Залуучуудын дунд уурхайн амьдралын мөчлөг, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, байгаль орчны менежмент зэрэг сэдвээр мэдлэг ойлголт олгох арга хэмжээг зохион байгуулах |

[20] Шинжлэх ухааны судалгаанд иргэд, олон нийтийг оролцуулах үйл явц, жишээ нь: мэдээлэл цуглуултад оролцуулах гэх мэт.

# 6 Дүгнэлт

Монголд уул уурхайн бүх төрлийн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаагаас цөөн тооны томоохон компани хүний эрхийн зарчмуудыг үйл ажиллагаандаа тусгаж, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа бол жижиг болон дунд  компаниудын хувьд олон нийтийн оролцоог хангах ойлголт мэдлэг хангалтгүй байна. Зарим компани холбогдох хууль тогтоомжийн шаардлагуудаа биелүүлэх төдий ажиллаж байгаа ба орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх бүтэц, чадавх хүрэлцээгүй, цөөн компанийн хариуцлагагүй үйлдэл, алдаа дутагдал зэрэг нь нийт уул уурхайн салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс болсоор байна. Зарим нэг компанийн хариуцлагагүй уул уурхайн ба хууль бусаар ашигт малтмал хулгайлан олборлогч нинжа нарын байгаль орчинд үлэмж хохирол  хорлон сүйтгэсэн шуналын сэдлийн улмаас орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд асар том сорилттой нүүр тулж байна.

Судалгаанаас дараах товч дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

Байгаль орчны стандартыг мөрдөөгүй (нөхөн сэргээгээгүй үлдээсэн нух ухаш, ил уурхайн эдэлбэр, ус, хөрс, агаарын бохирдол, бэлчээрийн доройтол г.м.), ОНХАГ-ээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлээгүй зэрэг зарим нэг компаниудын алдаа дутагдал нь иргэдийн дунд сөрөг ойлголт хандлага бий болгож, улмаар ашигт малтмал олборлолт, хайгуул зэрэг уул уурхайтай холбоотой бүхий л үйл ажиллагааг эсэргүүцэх үндсэн шалтгаан болж байна.

Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд амьдарч буй орон нутгийн иргэд ажлын байрыг нэмэгдүүлэх, компаниудад хүнс бараа нийлүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт, байгаль орчин, усны нөөцийг хамгаалах асуудлуудыг илүүтэй сонирхож байна.

Эргэх холбоо бүхий харилцаа, найдвартай, үнэн зөв, бодит мэдээлэл дутмаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд иргэдэд мэдээлэл хүргэх төрийн үйлчилгээний үүргээ биелүүлдэггүй зэрэг щ нь иргэдийн оролцоог хангах боломжийг хязгаарлаж байна.

Зарим орон нутгийн оролцоо, хамтын ажиллагааны сайн туршлагыг эс тооцвол, БОНБҮ болон ОНХАГ боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэдийн оролцоо бүрэн хангагдахгүй байна.

Сумын түвшинд байгуулагддаг олон талт дэд зөвлөл, иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг, ил тод ОНХАГ зэрэг нь орон нутгийн хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог хангах гол хөшүүрэг гэж үзэж байна.

Компаниудын олон нийтэд өгч буй гол мессежүүд нь ажлын байр бий болгох, орон нутгийн худалдан авалтыг дэмжих, нийгмийн үйлчилгээ болон орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтаа тодотгох, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнүүд, ОНХАГ-ний хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулдаг зэрэгт чиглэж байна. Орон нутгийн харилцааг зохицуулсан баримт бичгийг нээлттэй болгосон, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээлэл түгээх материалаа цахимаар байршуулсан компаниуд цөөхөн байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд уурхайн хаалт хүртэлх бүх үе шатанд мэдээллийг ил тод болгох нь харилцан ойлголцолд хүрэх, иргэдийн оролцоог хангах хамгийн зөв арга гэдгийг оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрч байна.

# 7 Санал зөвлөмж

## 7.1 Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх стратегийн ерөнхий санал зөвлөмжүүд

Талуудын харилцан ойлголцол, итгэлцэл, хамтын ажиллагааг бий болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах ерөнхий зөвлөмжүүдийг судалгааны үр дүнд тулгуурлан санал болгож байна. Үүнд:

**Биечилсэн уулзалтыг чухалчлах:**

Нүүр нүүрээ харсан уулзалт, хэлэлцүүлэг, харилцан яриа нь орон нутаг, ялангуяа малчидтай холбоо харилцаа тогтоох, итгэлцлийг бий болгох хамгийн үр дүнтэй арга болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Энэ нь орон нутгийн иргэдийг хүндэтгэх, тэдний эрх ашгийг харгалзан үзэх, сонирхлоо илэрхийлэх, тэдний хэрэгцээ, үзэл бодлыг сонсох, орон нутгийн нөхцөл байдлыг ойлгох, компанийн үүрэг хариуцлага, оролцоог хангах боломж бий болгох давуу талтай юм.

Орон нутгийн иргэдийн бизнес, иргэдийн амьжиргааг дэмжих хамтын ажиллагааг өрнүүлэх, малчдын бэлчээрийн нөхцөлийг сайжруулах, нөхөн сэргээлтэд оролцох боломжийг нэмэгдүүлэх, усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.

**Найдвартай, үнэн зөв, бодит, хэрэгцээтэй мэдээллээр хангадаг мэдээллийн суваг, арга хэрэгслийг бий болгох**

Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа амжилттай байх гол үндэс нь оролцогч талуудыг цаг тухайд нь үнэн зөв мэдээллээр хангах явдал юм. Үүнд:

- Орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниуд иргэдэд төлөвлөгөөт ажлуудаа танилцуулдаг, иргэд асуулт асуух, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлдэг, оролцоог хангасан, харилцан ярилцах, үзэл санал бодлоо илэрхийлэх уулзалт, хурал зохион байгуулах,
- Уурхайн талбайд практик сургалт хийх: уул уурхайн технологи, компанийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хэрхэн бууруулж байгаатай танилцах, суралцах боломжоор хангах,
- Сайн туршлага бүхий сумдаас суралцах, бусад сумын иргэдийг урьж, харилцан суралцах, туршлагаа хуваалцах боломжоор хангах,
- Уул уурхайн тухай үндсэн ойлголт, биологийн олон янз байдал, үр дүнтэй хамтын ажиллагаа, хүний эрх, зөрчил маргаан шийдвэрлэх зэрэг сэдвээр албан бус боловсрол олгох уулзалтууд зохион байгуулах (жилд 2-4 удаа) зэрэг орно

Эдгээр арга хэмжээ нь мэдээллийн найдвартай эх сурвалж бөгөөд асуулт асууж, хариулт авах, оролцогчдод харилцан суралцах, асуудлыг өөр өөр өнцгөөс харах, нэгдсэн ойлголтыг бий болгох боломжийг олгох юм.

**Орон нутгийн онцлогт тохируулан бага бага зардлаар/нэмэлт хөрөнгө зарахгүйгээр энгийн мэдээлэл түгээх арга замыг бий болгох:**

1. <u>Орон нутгийн мэдээллийн цэг</u>: иргэд хамгийн ихээр цуглардаг байршлууд (худаг, хүнсний дэлгүүр, цайны газар , г.м.)-ыг мэдээлэл түгээх, мэдээлэл солилцох цэг болгон ашиглаж болно.
2. <u>Сар бүр/2 сар тутамд уул уурхайн мэдээлэл солилцох уулзалт хийх</u>: аймаг, сумын ЗДТГ,

уул уурхайн компаниуд хамтран энэхүү мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулж болно.

3. Орон нутгийн түвшний арга хэмжээ: Төрийн үйлчилгээтэй хосолсон уул уурхайн нээлттэй өдөрлөгийг талууд хамтран зохион байгуулах.

**Хамтран суралцах, итгэлцлийг бий болгох боломжууд:**

1. Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг: Иргэдтэй хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх итгэлцлийг бий болгох үр дүнтэй үйл явц юм ("Хил Хязгааргүй Алхам" ТББ-аас холбогдох мэдээллийг авах боломжтой).
2. ОНХАГ боловсруулах, хянах үйл явц: ОНХАГ-г орон нутагт хэлэлцэх, дэд зөвлөл үйл явцыг удирдан чиглүүлэх (иргэдийн оролцоотой ОНХАГ боловсруулах, хянах үйл явцын арга зүйн зөвлөмж, холбогдох мэдээллийг Нээлттэй нийгэм форумаас авах боломжтой).

**Талуудын оролцоо, ил тод байдлыг хангах, түншлэлийг бий болгох:**

1. Сумын түвшинд олон талт дэд зөвлөлийг байгуулж, дотоод журмыг боловсруулан түүний дагуу үйл ажиллагаа явуулах нь зүйтэй. Орон нутгийн оролцогч талууд хэзээ хэрхэн уулзахаа ярилцан зөвшилцөж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлагатай. Энэ нь орон нутгийн оролцогч талуудын манлайлал, санаачилгаас бүрэн хамаарч хэрэгжих үйл явц буюу талууд харилцан нэгнээ ойлгох, улмаар харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэх үр дүнтэй арга зам юм. Дэд зөвлөлийн ажлын хүрээнд олон нийтийн хэрэгцээг тодорхойлж, компаниуд дэмжих боломжтой ажлуудыг тодорхойлж, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал. Тухайлбал, бэлчээрийн нөхцөлийг сайжруулах, иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөр хөгжүүлэх, усны нөөц, хүртээмжийг сайжруулах чиглэлээр иргэдтэй хамтарсан төсөл хэрэгжүүлж болох юм. Талуудын уулзах боломжтой тохиромжтой өдөр цагт, тодорхой зорилгын дор уулзалтуудыг зохион байгуулах нь чухал.
2. Орон нутгийн сэтгүүлчдийг татан оролцуулах. Орон нутгийн сэтгүүлчид нь томоохон нөөц, боломж бөгөөд сэтгүүлчдийг хамруулан мэдээлэл түгээх чиглэлийн сургалт явуулах нь илүү өргөн хүрээнд олон нийтэд хүрч ажиллах түлхэц өгөх бас нэгэн боломж хөшүүрэг болно.
3. Уул уурхайн үндэсний хэмжээний арга хэмжээ. "Уул уурхайн долоо хоног" (Mongolian Mining Week) зэрэг үндэсний хэмжээний олон талт арга хэмжээнд сум орон нутгийн удирдлагууд, иргэд, тэр дундаа малчдын төлөөллийг түлхүү оролцуулах хэрэгцээ байгааг судалгааны үр дүн харууллаа. Жишээ нь, мянга гаран хүн оролцсон 2022 оны "Уул уурхайн долоо хоног" өдөрлөгт ердөө 10 сумын засаг дарга ТББ-уудын урилгаар оролцсон мэдээллийг судалгаанд оролцогчдын төлөөлөл өгсөн нь гол оролцогч тал болох орон нутгийн төлөөллийг хангалттай хэмжээнд оролцуулаагүйг илтгэн харуулсан. Цаашид энэхүү арга хэмжээг орон нутагтай урт хугацааны харилцаа, хамтын ажиллагааг бий болгох явцад шат ахиулсан хэлэлцүүлгийн талбар болгон ашиглах нь зүйтэй.

**Иргэд, орон нутгаас гарсан санаачилгуудыг дэмжих:**

Монгол Улсад хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд өөрсдийн боловсруулсан арга, аргачлалын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Зөв зохистой шийдэл нь том хэмжээний нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн санаачилга иргэд, орон нутгаас гарч, тэдгээр санаачилгыг төсөл хөтөлбөрүүд санхүүжүүлэх замаар дэмжин хамтран ажиллах нь илүү өргөн хүрээний үр нөлөө авчрах ач холбогдолтой юм.

## 7.2 Оролцогч талуудад чиглэсэн зөвлөмжүүд

**Засгийн газар болон орон нутгийн удирдлагад:**

Уул уурхайн орон нутгийн хамтын ажиллагааны бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хүний эрхэд суурилсан хандлагыг баримтлах:

1. Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах;
2. Одоо байгуулагдсан ОНХАГ-үүдийг ил тод болгон e-Mongolia зэрэг үндэсний хэмжээний цахим платформ ашиглан нээлттэй болгох;
3. Уул уурхайн компани болон олон нийтийн хамтын ажиллагааг бодлогоор дэмжих, зохицуулах;
4. БОНБҮ-ний одоо хэрэгжиж буй орон нутагт хэлэлцүүлэх, санал авах хугацааг эргэн харах: БОНБҮ-ний хэлэлцүүлэгт иргэдийг оролцуулах нь маш чухал гэж олон улсын зөвлөмж болон одоогийн чиг хандлагаас харагдаж байна. Энэ оролцоог хангахад цаг хугацаа хэрэгтэй байгааг судалгааны үр дүн харуулж буй учир, энэ хугацаатай холбоотой асуудлыг эргэн харах шаардлагатай. Жишээ нь, зарим ургамал, усны урсгалд тодорхой хугацаанд хэмжилт хийх, ажиглах хэрэгцээ гарч болно. Олон улсын туршлагаас харахад БОНБҮ-ний явц газарзүйн онцлог, экологийн бүрэлдэхүүн хэсгүүдийн амьдрах чадвар, мэдрэг байдлаас хамаарч 1-5 жил, түүнээс ч илүү хугацаа шаардагддаг. БОНБҮ-ний иргэдээр хэлэлцүүлэх, зөвлөлдөх хангалттай хугацаа (3-12 сар) олгох нь уул уурхайн компани болон иргэд аль аль талд нь үр ашигтай юм.
5. Уул уурхайн компаниудын (хариуцлагагүй уул уурхайн) байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны хуулиудыг хэрэгжүүлэх мөрдүүлэх.

**Аж ахуйн нэгж, компаниудад:**

1. Хүний эрхийг дээдэлж, компанийн бодлогод тусгах;
2. Компанийн стратеги төлөвлөгөөний хүрээнд орон нутагтай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөг боловсруулах, орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг судалж тусгах;
3. Шийдвэр гаргах эрх мэдлийг олон нийттэй харилцах ажилтнуудад олгох, шийдвэрийг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийг хуваарилах;
4. Байгаль орчны багц хуулийг дагаж мөрдөх;
5. Орон нутагт хамааралтай, үнэн зөв мэдээллийг ил тод, нээлттэй болгох;
6. Орон нутгийн нөхцөл байдалтай танилцах: нөлөөллийн бүсийн айл өрхүүдтэй уулзах, албан бус уулзалтууд зохион байгуулах, холбоо барих мэдээллээ иргэдэд өгөх, шаардлагатай үед биечилсэн уулзалтыг тогтмол давтамжтай хийх;
7. Орон нутгийн иргэдэд мэдээллийн хэвлэмэл материал тараах;
8. Албан ёсны цахим хуудас, олон нийттэй харилцах цахим хуудаснуудаа шинэчлэх, хүлээн авсан санал, хүсэлтийн мэдээлэл, худалдан авалтын зар, орон нутгийн иргэдэд зориулсан цахим мэдээллийн товхимол, сонин, сэтгүүл, холбоо барих хаягаа ил тод байршуулах.

**Орон нутгийн иргэдэд:**

1. ОНХАГ-г ил болгох, боловсруулах хянах явцад өөрсдөө оролцохыг холбогдох талуудаас шаардах;
2. Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн үйл ажиллагаанд оролцох хүсэлтээ илэрхийлэх, оролцох;
3. Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй компаниудын байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлуудад хяналт тавих;
4. Уул уурхайн компаниудтай хийх уулзалтуудад идэвхтэй оролцох;
5. Орон нутгийн хөгжилд чиглэсэн төслүүдийг санаачлан ОНХАГ-д тусгуулах.

***Санал болгож буй цаашид зайлшгүй хийх судалгааны сэдэв***

1. *Хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой уул уурхай, хайгуулын компаниудад тулгарч буй саад бэрхшээл, сорилтууд;*
2. *Уул уурхайн төслүүд дэх олон нийтийн оролцоог хангахад орон нутгийн удирдлагуудад тулгарч буй саад бэрхшээл, сорилтууд.*

# Хавсралтууд

## Хавсралт 1 Чанарын судалгаанд оролцогч талууд

| Оролцогч тал | Хийгдсэн ярилцлага | Хандалтын төрөл | Байгууллагын албан ёсны нэр |
|---|---|---|---|
| **Үндэсний түвшинд** | | | |
| Төрийн байгууллага | 2 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | УУХҮЯ-ны Геологийн бодлогын газар<br>АМГТГ-ын Олон нийттэй харилцах хэлтэс |
| Олон улсын төсөл хөтөлбөр | 2 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | Олон улсын санхүүгийн корпорацын “Хөгжлийн төлөөх ил тод байдал” төсөл<br>MERIT (Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь) төсөл |
| ТББ | 2 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | Нээлттэй нийгэм форум |
| Холбоо | 1 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци (МУУҮА) |
| Салбар дундын байгууллага | 1 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС) |
| Уул уурхайн компани | 2 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт<br>*/34 компанийн 8 компани руу албан бичиг илгээхэд 1 компани хариу өгсөн/* | *“Хос Хас” ХХК,* Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулдаг<br>“Монполимет” *ХХК* (Хувийн шугамаар холбогдсон) |
| Хэвлэл мэдээллийн байгууллага | 2 | Цахим шуудангаар албан бичиг илгээх<br>Утсан хандалт | “Майнинг Инсайт” сэтгүүл<br>*“The Mongolian mining journal” сэтгүүл / Уул уурхайн тойм сонин* |
| **Орон нутгийн түвшинд** | | | |
| Орон нутгийн удирдлага | 2 | Албан бичиг<br>Талбарт очиж уулзах | Сумын засаг дарга<br>Сумын засаг даргын орлогч |
| Орон нутгийн ТББ, ИНБ болон нөлөө бүхий иргэн | 2 | Албан бичиг<br>Талбарт очиж уулзах | Сумын ИТХ -ийн төлөөлөгч |
| Сумын төвийн болон малчин иргэд | ФБЯ – 2 | Албан бичиг<br>Талбарт очиж уулзах | Сумын төвийн болон малчин иргэд |
| Ажиглалт | 2 | Талбарт зочилж ажиллах | Сумын төв болон хөдөөгийн бэлчээрийн бүс |
| **Нийт ярилцлага - 17** | | | |

### Талбарын судлаачийн тэмдэглэл: Булган аймгийн Бүрэгхангай сум

| Мэдээлэл цуглуулах арга | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Талбарын судлаачийн тэмдэглэл |
|---|---|---|---|
| **Ганцаарчилсан ярилцлага** | Сумын засаг дарга - 1<br>Орон нутгийн ТББ, ИНБ эсвэл нөлөө бүхий иргэн - 1<br>Уул уурхайн компани - 1 | Сумын засаг дарга - 1<br>Орон нутгийн ТББ, ИНБ эсвэл нөлөө бүхий иргэн - 1<br>Уул уурхайн компани - 0 | Сумын засаг даргатай ганцаарчилсан ярилцлага хийсэн. Суманд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй, мэдээлэл түгээгч субъектээр Загас гэх ИТХ-ийн төлөөлөгчийг сонгож ярилцлага хийсэн. Харин сумын гаралтай “Өгөөж Баян Хангай” нэртэй уул уурхайн компанийн төлөөлөл энд байдаг ч мэдээлэл цуглуулалтын үед суманд байхгүй байлаа. Сумын удирдлагууд болон бусад талуудаас идэвхтэй ажилладаг уул уурхайн компаниудын жагсаалтыг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | авсан. |
| **Фокус бүлгийн ярилцлага** | Сумын төвийн болон малчин иргэд - 8 оролцогч | Сумын төвийн болон малчин иргэд - 7 оролцогч | Орон нутгийн иргэдийн дийлэнх нь 2021 он хүртэл бичил уурхайн нөхөрлөлд элссэн. Зарим нөхөрлөл нь холбогдох журмын дагуу хүнээ гүйцээхийн тулд ойр дотны хүмүүсийг гишүүнээр элсүүлсэн. Санамсаргүй түүврийн аргаар бүлгийн ярилцлагад оролцох зөвшөөрөл авч, зөвшөөрсөн иргэдийн дийлэнх нь бичил уурхайн нөхөрлөлтэй ямар нэг байдлаар холбоотой байлаа. Хөдөөгийн иргэн 2, сумын төвийн иргэн 5, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан. |
| **Ажиглалт** | Талбарын ажиглалт - 1 | Талбарын ажиглалт - 2 | Сумын төв болон олборлох үйл ажиллагаа явуулдаг багийн 2 малчин өрхөөр зочилж ажиглалт, ярилцлага хийсэн. Уг 2 өрхийн 1 өрхийн өвөлжөөнөөс 2 км зайд уурхай болон баяжуулах үйлдвэр байдаг. Мөн сумаас дараах нээлттэй баримт бичгүүдийг цуглуулсан.<br>• Сумын засаг даргын 2021 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт /хэвлэмэл/<br>• Ил тод байдлын санаачилга /2014/ -ийн сумын түвшний тайлан /хэвлэмэл/<br>• Бүрэгхангай сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр 2020-2024 /софт/<br>• Бүрэгхангай сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр 2020-2024 биелэлт /софт/ |

**Талбарын судлаачийн тэмдэглэл: Дундговь аймгийн Хулд сум**

| Мэдээлэл цуглуулах арга | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Талбарын судлаачийн тэмдэглэл |
|---|---|---|---|
| **Ганцаарчилсан ярилцлага** | Сумын засаг дарга - 1<br>Орон нутгийн ТББ, ИНБ болон нөлөө бүхий иргэн - 1<br>Уул уурхайн компани - 1 | Сумын засаг дарга - 1<br>Орон нутгийн ТББ, ИНБ болон нөлөө бүхий иргэн - 1<br>Уул уурхайн компани - 0 | Одоогийн сумын засаг дарга нь шинээр томилогдсон бөгөөд тухайн үнэлгээний сэдвийн талаар сайн ойлголтгүй байсан учир сумын засаг даргын орлогчтой ганцаарчилсан ярилцлага хийсэн. Харин сумын хэмжээнд мэдээлэл түгээгч, идэвхитэй орон нутгийн иргэнээр Эрдэнэбаатар гэх нөхөрлөлийн гишүүнийг сонгон авч ганцаарчилсан ярилцлага хийсэн. Уул уурхайн компанийн төлөөлөл талбарт ажиллах үед байхгүй байсан учир холбогдох мэдээллийг авсан. Орон нутгийн дийлэнх иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтаар жонш олборлодог байсан. ЗГ-ын сүүлд гаргасан тогтоолоор өмнөх бичил уурхай эрхлэгчид аймгийн төв рүү сертификат олгох сургалтад хамрагдах шаардлагатай болсон. Уг сертификаттай бичил уурхай эрхлэгчдийг Сумын засаг дарга суманд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг "Голден Санрайс"/"Golden Sunrise" компанийн олборлолт явуулдаг газрын ойролцоо олборлолт явуулах эрх өгөхөөр төлөвлөж байгаа. Бичил уурхайн үйл ажиллагааг зогсоосноос хойш сумын хүн ам багассан. Орон нутгийн захиргаанаас зохион байгуулж буй өдөрлөг, тэмцээн, уралдаан, баяр ёслолоор уг компани санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, орон нутгийн захиргаатай найрсаг харилцаатай. Нөлөөллийн бүсийн бус, бусад багийн өрхүүдтэй холбоо харилцаа байхгүй. |
| **Фокус бүлгийн ярилцлага** | Сумын төвийн болон | Сумын төвийн болон | Орон нутгийн иргэдийн ихэнх нь ямар нэг нөхөрлөлийн гишүүнээр элссэн байдаг талаар оролцогчид дурдаж |

| | | | |
|---|---|---|---|
| | малчин иргэд - 8 оролцогч | малчин иргэд - 7 оролцогч | байсан. Мөн орон нутгийн иргэд уул уурхайн компанийн талаар мэдээлэл байдаггүй. Уурхайгаас холдох тусам суманд уул уурхайн компани үйл ажиллагаа явуулдаг талаар иргэдийн мэдээлэл, ойлголт багасдаг. Дээр дурдсан компанийн олборлолт явуулдаг газарт буюу нөлөөллийн бүсийн 4-5 өрх байдаг бөгөөд уг компанийн зүгээс тэдний амьжиргааг дэмжих, амралтын газар амраах, мал мах худалдаж авах, өвөлжилт хүндэрсэн үед материаллаг дэмжлэг үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг ч багийн бусад өрхүүдэд ямар нэг дэмжлэг байдаггүй учир багийн бусад малчин өрхүүдийн сэтгэл дундуур байдаг. Уг сэтгэл дундуур байдлыг багасгах үүднээс тухайн компани үйл ажиллагаа явуулдаг багийн бүх өрхөд даралтны аппарат тараасан. |
| **Ажиглалт** | Талбарын ажиглалт - 1 | Талбарын ажиглалт - 2 | Хөдөөгийн малчид тоосжилтоос үүдэлтэй малын уушги өвчилж байгаа талаар дурдаж байлаа. Орон нутгийн иргэд бичил уурхай эрхэлж эхэлснээс хойш сум хөгжиж эхэлсэн гэж үздэг. Ажилгүй иргэд орлоготой болж ажилтай иргэд нэмэлт орлоготой болсон гэж үздэг. Бичил уурхай эрхлэх зөвшөөрөл өгөхөө больсноос хойш хүн амын тоо багасч байгаа. |

## Хавсралт 2 Судлагдсан байдлын тойм: PICOC[21] дүн шинжилгээ. Монголын туршлага

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Т.Батдэлгэр (олон зохиогчтой судалгааны ажил), 2022<br>“Уул уурхайн орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл ба үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл” | Дундговь аймгийн Гурвансайхан сумын<br>“Эрдэнэс Монгол” ХХК (төрийн өмчит компани)-ийн охин компани “Эрдэнэс силвер ресурс” ХХК | Олон нийт хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах түгээмэл арга нь “Social Acceptance Survey” судалгаа юм.<br>“Эрдэнэс Силвер Ресурс”-ын жишээ | Уул уурхайн нийгэмд үзүүлэх нөлөөллийн чанарын болон тоон хэмжигдэхүүн, уул уурхайн компанийн ил тод шударга байдал, итгэлцэл, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг судалгаанд оролцогчдын үнэлэлтээр дүгнэв. | Хэдийгээр Монголд уул уурхайн олон компани үйл ажиллагаа явуулж байгаа ч үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрлийг (SLO) чухалчилдаггүй, энэ талаарх ойлголт бага. Ихэнх компани өөрсдийн үйл ажиллагааны талаар орон нутгийн иргэдэд хангалттай мэдээлэл өгдөггүй. Судалгаанд оролцогчдын 64% нь уг компанийг мэддэггүй гэсэн хариулт өгсөн. Судалгаанд оролцогчид “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-тай харилцах давтамжийг дунджаар 1.2 оноогоор үнэлсэн бөгөөд ихэнх оролцогчид компанийн ажилчид болон төлөөлөгч нартай нэг ч удаа уулзаж байгаагүй гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь нийгмийн бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөллийг 3 оноогоор үнэлсэн (огт өөрчлөгдөөгүй). “Эрдэнэс силвер ресурс” ХХК нь Гурвансайхан сумын хөгжилд дорвитой нөлөө үзүүлээгүй. Оролцогчдын итгэлцлийн түвшин 3.5 оноо. Хэдийгээр “Эрдэнэс силвер ресурс” ХХК иргэдтэй уулзалт | Монгол Улсын хэмжээнд 2014 онд 41, 2015 онд 70, 2016 онд 58 арбитрын хэрэг (орон нутаг, уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаа хооронд) гарчээ.<br>Энэхүү судалгаагаар Оюутолгой, Гацууртын алтны уурхай гэсэн хоёр том уул уурхайн Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ (ННБҮ) хийсэн. ННБҮ нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй эерэг ба сөрөг өөрчлөлтүүдийг үнэлж, эерэг үр дагаврыг нэмэгдүүлэх зорилготой. Үүнд дэд бүтэц, ажил эрхлэлт, ус болон | Ихэнх тохиолдолд оролцоо бараг байдаггүй<br>Мэдээлэл өгсөн цөөн тохиолдол бий | Шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрлийг сайжруулахад нэн чухал юм. |

[21] Population-хүн ам, Intervention-арга хэмжээ, Comparison-харьцуулалт, Outcome-үр дүн, Context-нөхцөл байдал

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж, үйл ажиллагаанызхаа мэдээллийг тайлагнадаггүй, орон нутгийн хөгжилд дорвитой нөлөө үзүүлээгүй ч судалгаанд оролцогчдын итгэлцлийн түвшин 3.5 оноо байна. Магадгүй тус компани 3Г-ын шийдвэрээр ахмадуудын тэтгэврийн зээлийг нэг удаа тэглэхэд санхүүжилт олгосон явдал нөлөөлсөн байж болох талтай. | газрын хүртээмж, халамж зэрэг багтана. | | |
| 2 | Л.Дагвадорж, 2018<br>“Орон нутгийн иргэдийн байгаль орчны талаарх ойлголт уул уурхайн компанид итгэх итгэлд нөлөөлөх нь: Монголын жишээ” | Нутгийн иргэд, малчид | Итгэлцлийг тодорхойлогч хүчин зүйлс болох байгаль орчныг хамгаалахад чиглэсэн компанийн хүчин чармайлт, бохирдлын талаарх иргэдийн ойлголт. | | Уурхайн ойролцоо амьдардаг малчдын тухайн компанид итгэх итгэлд нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг нь байгаль орчныг хамгаалах компанийн хүчин чармайлт ба уурхайгаас хол суурьшдаг малчид төвийг сахисан байр суурьтай, хот суурин газрын иргэд уул уурхайн компаниудад итгэх итгэл дээгүүр байдаг. Компанийн иргэдтэй харилцах арга хэлбэр иргэдийн дунд эерэг эсвэл сөрөг ойлголт үүсэхэд нөлөөлдөг. Итгэлцэл бага байх тусам зөрчилдөөн үүсэхэд хүргэдэг. Иймд аж ахуйн нэгжүүд орон нутгийн иргэдээс, тэр дундаа байгаль | Эхний тодорхойлогч хүчин зүйл бол сэдэл юм. Итгэлцэл нь үр өгөөжийг шударгаар хуваарилж буй эсэх дээр үндэслэж бий болно. Хоёр дахь тодорхойлогч хүчин зүйл бол чадамж бөгөөд энэ нь мэдлэг, оюун ухаан, мэргэжлийн ур чадвар дээр үндэслэн хөгжинэ. | Мэдээлэх түвшинд | Холимог арга.<br>Чанарын мэдээлэл: Тоон асуултууд нь компанийн мэдээлэл дамжуулах чадавхид чиглэсэн ба тухайн компани уул уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны бохирдол, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийн талаар орон нутгийн иргэдэд |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орчны өөрчлөлтөд өртөх эрсдэл бүхий бүлгээс санал асуулга болон зохих арга хэмжээ авах хэрэгтэй. Судалгаанд оролцсон бүлгүүдийн итгэлцлийн түвшин олон янз байсан бөгөөд итгэлцлийг тодорхойлогч хүчин зүйл, төлөв байдлыг харилцан адилгүй тайлбарласан байна. | | | мэдээлэл өгч байгаа эсэхийг судлав. Хариултын сонголтууд нь огт үгүй, тун ховор, ховор, ихэвчлэн, нэлээд олон удаа гэсэн сонголттой. |
| **3** | 3. Алтанчимэг, Б.Баттуяа 2019 он “Монгол Улс дахь нийгмийн хариуцлагын өнөөгийн байдал” | Уул уурхайн компаниуд | Орон нутгийн иргэдийн харилцаа холбоо | Монголд уул уурхай, тоног төхөөрөмжийн худалдаа эрхэлдэг 85 компани | КНХ-ын тухай ойлголтыг уул уурхайн компаниуд тэдийлэн сайн ойлгодоггүй. Компаниудын 80% нь (Судалгаанд хамрагдсан, МҮХАҮТ-д бүртгэлтэй) нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлдэггүй, ерөнхийдөө КНХ маш бага байна. | Байгаа боловч хэрэгждэггүй стандартууд: ISO 26000, НББОУС, СТОУС, ОҮИТБС ISO 14001, ISO 19001, OHSAS 18001 | Олон нийтийн оролцоо бараг тэг байна | Хариуцлагатай уул уурхай 2006 оноос эхэлсэн. Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт ба түүний зарчим |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4** | П. Мижиддорж<br>2021 он<br>“Уул уурхайн дуулиан, Гурвантэсийн жишээ” | Орон нутгийн иргэд, уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа | Уг судалгаа нь уул уурхайн талаарх Оролцогч талуудын харилцан адилгүй үзэл бодлуудыг тусгасан. | Төрөл бүрийн уул уурхайн компаниудын КНХ .<br>Малчид уурхайн олборлолт хэрхэн газар нутаг, булаг шандад нөлөөлж байгааг мэддэг болсон тул үлдсэн газраа хамгаалах эрмэлзэлтэй болсон. | Энэхүү судалгаа нь уул уурхайн олон нийтийн сайн туршлагыг нэвтрүүлэхэд тулгамдаж буй түгээмэл асуудлуудыг онцолсон.<br>Мөн уул уурхайн нөлөөлөлд өртсөн бүс нутгийн өнөөгийн нөхцөл байдал, компаниуд, орон нутгийн шийдвэр гаргагчид болон малчин иргэд хоорондын харилцаанд тулгарч буй сорилтуудыг жишээ болгон харуулав.<br>Иргэд компаниудын ус ашиглалт, нутгийн иргэдийг ажилд авдаггүй зэрэг асуудалд бухимдалтай. Иргэд "Бид олон компани өөр газар нутгийг сүйтгээсэй гэж хүсэхгүй байна", “Тэр том техник, төхөөрөмжийг хараад биширч байсан боловч байгаль орчин, мал аж ахуй, мөн эрүүл мэндэд ямар хор хөнөөлтэй болохыг ер ойлгоогүй гэжээ.  Булаг шанд, гол ус, бэлчээр сүйдсэн учир нөхөж баршгүй хохирол учирсан” гэв. | Гурвантэс сум нь Өмнөговь аймагт оршдог бөгөөд Монголын уул уурхайн асуудлын төв гэж хэлж болно. 2000 оны эхээр уул уурхай эрчимтэй хөгжиж ирсэн.<br>Одоогоор Гурвантэс орчмын 268708 га талбай буюу 14.2 хувьд олборлолтын тусгай зөвшөөрөл олгоод байна. Мэдэгдэж байгаагаар 27 ашиглалтын лиценз олгосон бөгөөд бичил уурхайн олборлолт мөн ихэссэн.<br>Уул уурхай нь ард түмний амьжиргааны гол хэрэгсэл болох уламжлалт мал аж ахуйтай зөрчилддөг.<br>(Маршалл, 2001; Снеат, 2006). | Мэдээлэх түвшинд.<br>Зөвлөлдөх явц байхгүй | Иргэдийн дундах хамгийн гол асуудал бол цахилгаан эрчим хүч байлаа.<br>Гурвантэс сум Хятадаас цахилгаанаа авдаг.<br>Хятад-Монголын Чинхуа МАК компани Өмнөговийн гурван сумдад цахилгаан түгээдэг.<br>Систем нь эвдрэлд өртөмтгий. Хэрэв цахилгаан тасарвал засварлахад долоо хоног ба түүнээс дээш хугацаа шаардагддаг. |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5** | Ж.Фрейзер, Н.Кунц<br>2018 он<br>“Усны аюулгүй байдал: уул уурхайн компани болон иргэд хоорондын түншлэлийн онцлог” | Уул уурхайн компаниуд, орон нутгийн иргэд | Уул уурхайн компаниудад зориулсан сургалт. Тогтвортой үр дүнг дэмжих хамтын түншлэлийн стратеги.<br>Судалгааны асуулт: Уул уурхайн компаниуд болон иргэд хамтран үр дүнтэй усны менежмент хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлс нөлөөлдөг вэ? | Судалгааны кейсүүд: Монгол, Перу.<br>Перу болон Монгол дахь уул уурхайн оролцогч талуудын зөрчил маргааныг судалсан бөгөөд гол судлагдахуун нь усны маргаан.<br>Аж үйлдвэрийн хурдацтай хөгжил уламжлалт мал аж ахуйгаар амьжиргаагаа залгуулдаг орон нутгийн иргэдийн хувьд зарим асуудал дагуулж байна. | Хамтын ажиллагаа нь уул уурхайн компаниуд болон бусад ус хэрэглэгчдэд усны менежментийг сайжруулах боломж бүрдүүлнэ.<br>Энэ хөтөлбөрийн гол хэсэг нь нэг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын дунд улирал бүр дугуй ширээний уулзалт зохион байгуулах байв. Уулзалтын зорилго нь компаниудын өөрсдийнх нь усны менежмент, олон нийтийн оролцооны туршлагыг сайжруулах; итгэмжлэгдсэн гуравдагч талыг оролцуулж иргэдийн саналыг сонсох, компанийн хүчин чармайлтыг таниулахад чиглэсэн. Ус ашиглалтын мэдээллийг орон нутгийн иргэдтэй хуваалцсан нь ил тод байдлыг хангахад чухал алхам болсон. Мөн оролцогчид ус ба уул уурхайн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмээ оруулсан. 2014-2016 оны хугацаанд 1000 гаруй хүн сургалтад хамрагдсан. | Монгол Улсад 2012-1016 оны хооронд уул уурхайн асуудлаар 5 удаагийн зөрчил мөргөлдөөн үүссэн.<br>Перу - 17.<br>Усны хомсдолоос улбаалж Перу дэх Конга, Лас Бамбас, Тиа Мариа зэрэг олон тооны уул уурхайн төслүүд нийгмийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарчээ. | Перу: хамтын оролцоо: зөвлөлдөх, татан оролцуулах<br>Монгол: хамтын үйл ажиллагаа: зөвлөлдөх, татан оролцуулах | Оролцогч талуудыг хамруулах нь чухал ач холбогдолтой. Компани усны нөөцийг бусад оролцогч талуудтай булаацалдахаас илүүтэй усны өөр эх үүсвэр олох нь чухал. Тухайлбал хотын захиргаа бохир усыг авч цэвэршүүлж, уурхайн үйл ажиллагаандаа ашигласан.<br>Суурь мэдээлэл, үр дүнтэй засаглалын механизм дутмаг байгаа нь тодорхойгүй байдлыг үүсгэж, орон нутгийн иргэдийн дунд компанид үл итгэх байдлыг бий болгодог. |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **6** | Д. Бямбажав<br>2022 он<br>"Монголд уул уурхай ба бэлчээрийн мал аж ахуй зэрэгцэн орших гэрээ хэлэлцээрүүд" | Орон нутгийн иргэд, засаг захиргаа, компаниудын харилцаа хамтын ажиллагаа | Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хянаж, орон нутгийн иргэдэд ашиг сонирхлоо хамгаалахад дэмжлэг болж чадсан эсэхийг авч үзсэн.<br>Уул уурхайн компаниуд болон орон нутгийн удирдлага хооронд гэрээ байгуулах боломж бүрдсэн нь ЗГ-аас авч хэрэгжүүлж буй бодлогын нэг алхам болсон. | Австрали, Канадад хуулийн дагуу хайгуулын эхний үе шатнаас нутгийн иргэд болон компаниуд хоорондоо зөвшилцөлд хүрч, гэрээ байгуулах журамтай байдаг. | Гэрээ байгуулах үйл явцад уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн оролцоог хангах үүднээс уул уурхайн төслийн нөлөөлөлд өртсөн иргэд малчдын эрх ашиг, шаардлагуудыг ОНХАГ-д тусгах ёстой.<br>Монголын уул уурхайн салбар сүүлийн хорин жилд үлэмж өссөн ч цар тахал болон уламжлалт мал аж ахуйд эдийн засгийн бусад салбараас бага нөлөө үзүүлсэн зэрэг шалтгаанаар амьжиргааг тогтвортой байлгахад мал аж ахуйн гүйцэтгэх үүргийг илүүд үзэж байна. | Уул уурхайн компаниуд болон орон нутгийн иргэд хоорондын харилцаа зөрчилтэй явж ирсэн. Орон нутгийн иргэдийн оролцоог уул уурхайн чиглэлээр төрөөс явуулж буй бодлого, зохицуулалтад хангалттай тусгаагүй байна. Хууль ёсны шаардлага нь 2006 оноос хойш мөрдөгдөж байсан ч ОНХАГ-ний үр дүн тийм ч сайн биш байна. | Олон нийтийн оролцоо хамгийн доод түвшинд байна. Мэдээллээр хангадаг. | Оюу Толгойн жишээ нь уул уурхай урт хугацаанд орон нутгийн иргэдтэй зэрэгцэн оршихын тулд олон нийтийг хамарсан давтамжтай, олон үе шат бүхий хэлэлцээ нэн шаардлагатайг харуулж байна. |
| **7** | Т. Стернберг, Ж. Майауд. А. Ахим<br>2022 он<br>"Цөлжиж буй говьд бэлчээрийн мал аж ахуй хэрхэн | Малчид, орон нутгийн иргэд | Бэлчээрийн мал аж ахуйн арга барил өөрчлөгдөхөд малчид, засгийн газар, уурхайн үүрэг оролцоог судалсан огц | Томоохон уул уурхайн төслүүдийн Ханбогд сумын байгаль орчин, нийгмийн нөхцөл байдалд үзүүлэх | Ханбогд суманд уул уурхай, мал аж ахуй зэрэгцэн орших боломжтой. Харин ирээдүйд уул уурхай өргөжин тэлбэл малчдад томоохон сорилт авчрах магадлалтай байна. Засаглалын асуудал, байгаль орчны стандартыг мөрддөггүй явдал, ил тод байдал дутмаг | Цөлийн бүс нутаг, орон нутгийн иргэдийн оролцоо, томоохон олборлолтод дасан зохицох. Усны хүртээмжийн | Зөвлөлдөх,<br>татан оролцуулах,<br>дэмжлэг үзүүлэх | Салбар дундын арга хэмжээ: Байгаль орчны өөрчлөлтийн шилжилтийг ойлгоход ашигладаг байгалийн болон нийгмийн |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оршин тогтнох вэ?” | | үнэлгээ.<br>Олон нийт болон засгийн газар хөдөөгийн хүн амд ээлтэй байгаль орчны хамгаалалтыг дэмжсэн дадал бий болгож чадах уу? | нөлөөлөл. | байгаа нь цаашид тулгарах асуудлыг даван туулах, шийдвэрлэхэд томоохон сорилт болж хувирна. Бодлого боловсруулахдаа уул уурхай болон холбогдох дэд бүтцийн хуримтлагдсан нөлөөллийг анхаарч үзвэл нийгэм, байгаль орчныг хамгаалахад дэмжлэг болно. Бүтээн байгуулалтын шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах орон нутгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх хэрэгтэй. | асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа нь нутгийн малчид болон уурхай хооронд үргэлжилсэн зөрчилдөөнд хүргэж буй. | | шинжлэх ухааны аргууд. |
| 8 | Ч.Чойжинжав, М.Посенте 2022<br>“Салхитын мөнгөний уурхайн хаалтын төлөвлөгөө” | Төрийн албан хаагчид, уул уурхайн компаниуд, зөвлөхүүд, төслийн оролцогч талууд | Салхитын уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах.<br>Хууль эрхзүйн орчны шинжилгээ, талбайн үнэлгээний тайлан, уурхайн хаалтын зорилтуудыг боловсруулах, эрсдэлийн үнэлгээ.<br>Чадавхийг бэхжүүлэх, жендерийн тэгш байдлыг | Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө нь үр дүнтэй оролцооны аргууд. Гол оролцогч талуудыг тодорхойлсон. Мэргэжлийн оролцогч талууд уурхайн хаалтыг гүйцэтгэхтэй холбоотой мэдээлэх, сургах, туслах зорилготой зорилтот, холбогдох мэдээллийг | Орон нутгийн иргэдийн хэлэлцүүлэг, оролцооны арга хэмжээг төлөвлөх, хянах, үнэлэх үе шатанд хэлэлцүүлгийн удирдамжийг (MERIT 2017) ашигласан.<br>Тодорхой үүрэг хариуцлагыг багийн гишүүдийн дунд хуваарилж, авч хэрэгжүүлсэн алхмууд:<br>1.Хуулийн хяналт: Ашигт малтмалын тухай хууль болон БОНБҮ-ний тухай хуулийн хооронд уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулах эцсийн хугацаатай холбоотой зөрчилдөх заалт, зөрүүг илрүүлсэн.<br>2. Талбайн байгаль орчны төлөв байдлын тайлан: хаалтын үйл ажиллагаа болон нөхөн сэргээлтийн стратегийг | Дэлхийн банкнаас дундаж болон түүнээс доогуур орлоготой орнуудын ангилалд багтсан хөгжиж буй улс. Дотоодын уул уурхайн компаниуд уурхайн хаалтын төлөвлөлтийн туршлага бага. Уурхайн хаалтын төлөвлөлтөд хамрагдаж буй мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, компаниуд хаалтын төлөвлөлтийн | Мэдээлэх, оролцуулах түвшинд.<br>Талуудын оролцоог хангах арга хэмжээнд илүү хөрөнгө оруулалт хүчин чармайлт гаргаснаар урт хугацаанд зардал хэмнэх боломжтой. Компаниуд талуудын оролцоог дэмжих чадвар дутмаг байдаг. | Уурхайн хаалтын төлөвлөлт нь Монголын хувьд шинэ ойлголт.<br>MERIT төсөл, УУХҮЯ, БОАЖЯ, ESR компаниуд Салхитын уурхайг хаах гэрээнд гарын үсэг зурсан.<br>Төсөл төлөвлөх, зорилго, үр дүн, ерөнхий үүрэг, хариуцлагыг тодорхойлох, түншийн дэмжлэгийг шууд хөрөнгө оруулалт эсвэл биет бус хэлбэрээр хийх. Төслийн 1-р шат 2021 оны 9-р |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангах нь төслийн гол зорилтууд юм.<br><br>Хууль тогтоомжийг сайжруулах замаар уул уурхай, байгаль орчны салбарын засаглалыг бэхжүүлэх. Төлөвлөлтийн үйл явцыг стандартчилах замаар уурхайн хаалтын төлөвлөлтийг сайжруулах, уурхай хаагдсаны дараа эвдэрсэн газар нутаг нь иргэдэд үнэ цэнэтэй байхаар сэргээх явдлыг чухалчилна. | хүлээн авсан. Нутгийн иргэд, малчид уурхайн үйл ажиллагаа, уурхайн ашиглалтын хугацаа, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авсан. | боловсруулахад ашиглахаар бэлтгэсэн суурь үзүүлэлт, мониторингийн өгөгдөл<br><br>3.Уурхайн хаалтын зорилго, зорилтыг боловсруулах: Зорилт 1- нөхөн сэргээлт хийсэн газрууд нь тухайн газрын экосистемийн төлөв байдалд ойр, нутгийн иргэдийн газар ашиглалтын уламжлалт хэлбэрийг дэмжсэн шинж чанартай байх 2- уурхайн дэд бүтцэд түшиглэн эдийн засгийн өсөлт, нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих бизнесийн боломжийг хөгжүүлэх<br><br>4.Эрсдэлийн үнэлгээ: 10 эмзэг байдлыг тодорхойлсон.<br><br>Чадавхийг бэхжүүлэх нь гол оролцогч талуудыг хаалтын хэлэлцүүлэгт бодитой хувь нэмэр оруулахад бэлтгэх чухал асуудал байсан.<br><br>Төлөвлөлтийн үйл явцын эхний шатанд оролцогч талуудыг ойлгох, санаа зовоож буй асуудлуудыг шийдвэрлэх нь ирээдүйд гарч болох зардал, хүндрэлээс сэргийлэх  боломж олгоно. Нөлөөлөлд өртсөн оролцогч талуудтай үйл явцын эхэн үед бат бөх харилцаа тогтоох, ил тод байх, шийдэлд оролцогч талуудын санал хүсэлтийг эрэлхийлэх нь амжилтанд | хүлээлтийг хангахуйц нөөцийг бүрдүүлэх, оролцогч талууд, ялангуяа орон нутгийн иргэдийн чадавхийг нэмэгдүүлэх, ингэснээр тэднийг татан оролцуулах чухал ач холбогдолтой. | | сарын 1-нд эхэлсэн ба<br><br>2022 оны дөрөвдүгээр сарын 30-нд дууссан. |

| № | Зохиогч(ид), өгүүллийн гарчиг | Хүн ам | Арга хэмжээ | Харьцуулалт | Үр дүн | Суурь нөхцөл байдал | Оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрэх чухал хувь нэмэр болно. | | | |
| **9** | Э. Чимэдлхам<br>2019 он<br>“Хамтын ажиллагааны гэрээний талаарх олон нийтийн ойлголт” | Малчид, орон нутгийн иргэд | “Оюу Толгой” компанийн орон нутагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний үр нөлөө, гэрээний хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, ололт амжилтыг судалсан. | Орон нутгийн иргэд ба уул уурхайн компанийн харилцаа, хамтын ажиллагаа | Орон нутгийн иргэд ажил эрхлэлт, эдийн засгийн үр өгөөжийг бодож уурхайг дэмждэг. Судалгаагаар олон нийтийг хамарсан үр дүнтэй хэлэлцүүлэг, гэрээний хэрэгжилтэд олон нийт болон компани хоорондын харилцаа холбоо дутмаг, орон нутагт ажлын байр хуваарилах ил тод үйл явц байхгүй байгааг тогтоосон.<br>Уул уурхайн компаниуд болон орон нутгийн иргэд хоорондын зөрчил маргаан газрын асуудлаас ихэвчлэн үүддэг болохыг онцолж, газар эзэмшлийн талаар төрөөс баримталж буй бодлого илүү хоёр талын эрх ашгийг хамгаалсан нэгдсэн арга барил руу чиглэх нь чухал. | “Оюу Толгой” компани Өмнөговийн нутгийн иргэдийн тогтвортой хөгжлийг хангах төслийг дэмжих зорилгоор жил бүр 5 сая орчим ам.долларыг Говийн Оюу санд хуваарилдаг. | Зөвлөлдөх, татан оролцуулах | Жишээнд суурилсан судалгааны арга. Харилцаа холбоо, хамтын ажиллагааны гэрээний талаарх олон нийтийн ойлголт, хөдөлмөр эрхлэлт ба шилжилт хөдөлгөөний нөлөөлөл, усны нөөц ба нүүлгэн шилжүүлэлт зэрэг таван гол сэдэв дээр үндэслэсэн. |

## Хавсралт 3 Судлагдсан байдлын тойм: PICOC дүн шинжилгээ. Олон улсын туршлага

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Прно Ж Пикард М Кайеогана Ж, 2021<br><br>“Канадын хойд бүсэд хэрэгжих уул уурхайн төслийн БОНБҮ-ний явцад иргэдийн оролцоог үр дүнтэй хангасан туршлага” | Нунавут дахь Инуит нэртэй уугуул үндэстэн | Төслийг дэмжигчид манлайлан оролцсон.<br>Гэрээ байгуулж, хамтарсан менежмент хэрэгжүүлсэн.<br>Соёлын онцлог, уламжлалт мэдлэгийг тусгасан.<br><br>1.Эхнээс нь оролцуулж, нөхцөл байдалд тохирсон арга замуудыг хэрэгжүүлсэн<br>2. Мэдээллийг цогц байдлаар тогтмол бүртгэж, тайлагнасан<br>3.Иргэдийн санаа бодлыг жинхэнэ утгаар тусгасан<br>4.Урт хугацааны харилцаа хамтын ажиллагаа, орон нутагт ирэх үр өгөөжийг чухалчилсан | Орон нутгийн иргэдэд хүндэтгэлтэй ханддаг;<br><br>Газрын баялгийнхаа талаар илүү мэдээлэлтэй, илүү эрх мэдэлтэй БОНБҮ-ний явц илүү удаан үргэлжилдэг | Орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тусгасан.<br><br>Олон нийтээс дэмжлэг авсан.<br><br>Төслийн баримт бичгүүд батлагдахад дэмжлэг болсон.<br><br>Иргэдийг үр дүнтэй хамруулсан | Байгалийн баялгаас ихээхэн хамааралтай (цаа буга);<br><br>Ажилгүйдлийн түвшин өндөр, боловсрол нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдах түвшин доогуур | Хамтын ажиллагаа | Шийдвэр гаргалтад жинхэнэ утгаараа оролцдог эсэх<br><br>Иргэдийн санаа бодол бодитоор туссан эсэх<br><br>Төслөөс хангалттай дэмжлэг авч чадах эсэх<br><br>Олон нийт хүлээн зөвшөөрсөн эсэх<br><br>Эсэргүүцэл, тэмцэл, хууль эрхзүйн сорилт байгаа эсэх, ямар арга хэмжээ авсан<br><br>Олон нийттэй харилцах багийн ур чадвар |
| 2 | Сэлоа П, Нголе-Жеме В, 2022<br><br>“Өмнөд Африкийн Лимпопо дахь уул уурхайн | Өмнөд Африкийн Лимпопо орчмын орон нутгийн иргэд | КНХ-ын хүрээнд хөгжлийн төслүүд хэрэгжүүлсэн: хүний нөөц, дэд бүтэц, ядуурлыг бууруулах, боловсрол | Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар сөрөг ойлголттой, эдийн засгийн нөлөөллийг | Ажлын байр бий болгох хүлээлтэд хүрээгүй<br><br>Сөрөг хандлагаас | Олон нийтийн ерөнхий сөрөг хандлагаас болж КНХ, түүнийг хүрээнд хийгдэх зорилтуудыг урий лоозонгийн | Мэдээлэх | Олон нийтийн ойлголт хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс – уурхайгаас хэр ойр оршдог, хэр удаан амьдарч буй, нас, ажил эрхлэлт, боловсрол |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаарх олон нийтийн ойлголт хандлага ба КНХ-ын зарим асуудал” | | | илүү эерэгээр хүлээн авдагаараа Монголтой төстэй | болж итгэл буурч, эсэргүүцэл нэмэгдсэн<br><br>КНХ-ын бодлого нь дэд бүтцээс илүүтэй нийгмийн асуудлын суурь шалтгааныг шийдвэрлэхэд чиглэж, хэрэгжилтийг хянах нь зүйтэй. | шинжтэй хэмээн сөргөөр хүлээн авч, хамтын ажиллагаа үр дүнтэй муутай болсон.<br><br>Нийгмийн нөлөөллийн талаарх үзэл бодол байгаль орчны нөлөөллийн талаар үзэл бодолтой харьцуулахад бүр ч илүү сөрөг (уурхай эхэлснээс хойш амьдрал нь улам доройтсон гэж үздэг) | | КНХ-ын илрэл– бодитой хэрэгжиж байна уу, эсвэл уриа лоозонгийн шинжтэй байна уу?<br><br>Сөрөг хандлагаас болж иргэдийн итгэл буурч, хамтрах хүсэлгүй болсноор хамтарч хэрэгжүүлэх КНХ амжилттай хэрэгжээгүй байх магадлалтай |
| 3 | Мэрсэр-Мэпстөүн Л.Д, Рифкин В, Моффат К, Луйс В, 2018<br><br>“Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл олж авах хүрээнд иргэдийн оролцоог хангах ажлыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ? Харилцан санал солилцох явцын талаарх мэргэжилтнүүди | Олон нийттэй харилцах ажлыг хэрэгжүүлдэг мэргэжилтнү үдийн дунд үг судалгаа явуулсан | Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл – хамтын оролцоотой шийдвэр гаргалтыг дэмжих нийгмийн хариуцлагын асуудалд илүү анхаарал хандуулж эхэлсэн.<br><br>Нэг арга зам нь орон нутгийн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талыг хамарсан харилцан санал солилцох явц: 1.Харилцан санал солилцох стратеги загвар (тодорхой | Энэ нь “хэлэлцүүлэг”-ээс ялгаатай юм. Учир нь хэлэлцүүлэг бол нэг тал нь чиглүүлдэг бол харилцан санал солилцох нь өөр өөр талууд нэг ширээний ард ижил тэгш эрх оролцоотойгоо р суух боломжийг бүрдүүлдэг | Мэдээлэл оролцоо сул байвал сөрөг ойлголт нэмэгдэж, эсэргүүцэх хандлагатай болдог | Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрлийн хүрээнд эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нь зүйтэй.<br>Харилцан санал солилцох нэг үр дүнтэй арга нь иргэд болон компанийн төлөөлөл нүүр тулан ярилцах явдал юм. Энэ нь үзэл бодол, санаа зорилго, үнэт зүйлс болон байгаа мэдээллээ | Бүрэн утгаар нь хэрэгжүүлбэл эрх мэдлийг олгох түвшинд хүрэх боломжтой | Компаниудын гарын авлага?<br><br>Олон нийтийн оролцоог хангах арга хэрэгслүүдийн гарын авлага?<br><br>Орон нутгийн удирдлагын эрх мэдэл?<br><br>Нийгмийн зөвшөөрөл олж авахад нөлөөлөх хүчин зүйлс: итгэл, үнэнч байдал, хуулиар олгогдсон эрх мэдэл, найдвартай байдал |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | йн ойлголт” | | зорилго, үр дүнд чиглэсэн илүү бүтэцлэгдсэн уулзалт яриа) нь талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхэд чиглэсэн байдаг. 2.Харилцан суралцахад чиглэсэн уулзалт яриа (талууд төрөл бүрийн асуудлаар илүү чөлөөтэй ярилцаж, харилцан нэгнээсээ суралцахад чиглэсэн) нь зөвшилцөлд хүрэх зэрэг тодорхой зорилготой байж болно. Хоёр талын урсгал бүхий шууд харилцаа үүсгэдэг тул аль аль арга нь үр дүнтэй бөгөөд бусдынхаа нөлөөгөөр оролцогч талуудын үзэл бодол өөрчлөгдөх магадлалтай гэдэг утгаараа хувь хүний болон нийгмийн түвшинд өөрчлөлт авчрах боломжтой (гэвч амьдрал дээр ховор). | | | солилцож хөгжүүлэх замаар харилцан ойлголцлыг бий болгох ач холбогдолтой. | | |
| 4 | Пажера С, Хани-Рөүзэс Ж, Кунз Н С, Фрейзер Ж, | Латин Америкийн орнуудад | Иргэдийн оролцоотой усны мониторинг (ИОУМ) | Усны асуудлаас үүдэж | Дараах загварын дагуу ИОУМ-ын | Латин Америкийн уул уурхайн төслүүдэд | Иргэдийн оролцооны түвшин | Иргэний шинжлэх ухаан (citizen science) - олон нийт дээж цуглуулж өгөх |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хавиер А , 2018<br><br>“Оролцооны нэг хэлбэр болох уул уурхайн бүсийн иргэдийн оролцоотой усны мониторингийн хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ” | хэрэгжсэн 20 хөтөлбөрийг хамруулсан | нь олон нийтийн оролцоог хангах нэг хэлбэр. Мэдээлэл цуглуулах, шинжлэх явцад иргэд оролцдогоороо онцлог. Энэ нь байгаль орчны суурь мэдээлэл бүрдүүлэх, өөрчлөлтийг хянах, шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх, орон нутгийн мэдлэгийг тусгах, иргэдийг идэвхижүүлэх, усны аюулгүй байдлыг хамгаалах ач холбогдолтой. Компанийн хувьд зөрчил маргаантай асуудлыг илрүүлэх, харилцан санал солилцох, итгэлцлийг бий болгоход дэмжлэг болдог. | болзошгүй зөрчил маргаанаас сэргийлэх үүднээс компаниуд талуудыг энэхүү үйл ажиллагаанд хамруулдаг. Талууд ИОУМ-ын талаар ямар ойлголт хандлагатай байгаагаас хамаарч оролцооны түвшин харилцан адилгүй. Зарим улсын хуулиар ИОУМ-ын зөвлөл байгуулах ёстой байдаг, ж, Перу. | хөтөлбөрууд дэх талуудын оролцооны түвшинг шинжилсэн:<br>1. Гаднаас удирдсан, мэргэжлийн түвшинд зохион байгуулагдсан (хамгийн түгээмэл хэлбэр),<br>2.Гаднаас удирдсан, орон нутгийн иргэд мэдээлэл цуглуулсан,<br>3.Хөндлөнгийн тал мэдээллийг хөрвүүлсэн, хамтарсан мониторинг,<br>4.Орон нутгийн оролцогчид мэдээллийг хөрвүүлсэн хамтарсан мониторинг,<br>5.Орон нутгийн талууд бие даан мониторинг хийх (2 дахь түгээмэл хэлбэр) | гаргасан гомдлын 58% нь устай холбоотой. Боломжит эрсдэлээс сэргийлэх үүднээс монирторинг, аюулгүй байдал эрсдэлийн шинжилгээг тогтмол хийдэг. ИОУС-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс нь найдвартай мэдээлэл, санхүүжилт, орон нутгийн мэдлэг туршлага. | харилцан адилгүй. Ерөнхийдөө ИОУС нь шийдвэр гаргалтад нөлөөлөхөөс илүүтэй мэдээлэл өгөх ач холбогдолт ой. Харин тогтмол зохион байгуулсна ар иргэдийн шийдвэр гаргалтад оролцох идэвх санаачилгы г нэмэгдүүлн э. | зэргээр шинжлэх ухааны судалгааны үйл явцад оролцох.<br>ИОУМ-ын загварууд:<br>1.Төлөвлөлт: гадны удирдлагатай, хамтарсан, орон нутгийн удирдлагатай;<br>2.Мэдээлэл цуглуулалт: орон нутгийн, мэргэжлийн;<br>3.Мэдээллийг хөрвүүлэх: орон нутгийн, гадны |
| 5 | Малоне А, Смит Н. М, Зебаллос Е. З, 2021<br><br>“Бичил уурхай, загасны аж ахуй, | Перу дахь бичил уурхайн тосгон | Бичил уурхай урьд нь уламжлалт аж ахуй хэмээн тооцогдож байсан ба 2000 оноос хойш хурдтай өссөн. | Үр нөлөө, асуудлууд, нийгмийн харилцаа холбоо нь тестэй. | усны бохирдол, усан дахь хавчны нөөц багасах, газар ашиглалтын маргаан, | Бичил уурхай амьжиргааны бусад эх үүсвэрүүдтэй зэрэгцэн оршдог. | Иргэдийн хувьд мэдээлэх түвшинд байна. | Нийгмийн харилцаа, эрх мэдлийн нөлөөлөл,<br><br>Түүх болон өмнөх туршлага, |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ферм хоорондын зохицол ба зөрчил, Перу дахь нэгэн бичил уурхайн тосгоны жишээ” | | Том болон дунд хэмжээний уурхай голын эхээр оршдог. | | нийгмийн хагарал хуваагдал зэрэг зөрчил маргаантай асуудлуудыг тэсвэрлэн оршсоор байдаг<br><br>Орон нутгийн иргэдэд ирэх эдийн засгийн үр өгөөжөөс гадна нийгмийн харилцаан дахь эрх мэдэл ашиг сонирхлын нөлөөлөл, ялангуяа бичил уурхайн бүлгийн ахлагч нар орон нутгийн удирдлагатай ойр байдгаас эсэргүүцдэг иргэдийн дуу хоолой дарагдаж, бичил уурхайг илүү хариуцлагатай ажиллуулах тэмцлийн хүч суларчээ | Зарим бүсэд бичил уурхай орон нутгийн иргэдийн амьжиргааны нэг эх үүсвэр болж, ихэнх өрх ямар нэгэн байдлаар энэ үйл явцтай холбогдсон байдаг тул харьцангүй хүлээн зөвшөөрөгдөх хандлагатай болжээ.. | Харин бичил уурхайн ахлагч нарын хувьд эрх мэдлийг олгох түвшинд байна. | Хүн амын дундах бичил уурхайн талаарх ойлголт хандлага,<br><br>Байгаль орчны нөлөөллийн талаарх харилцан адилгүй үзэл бодлууд,<br><br>Эдийн засгийн давуу болон сул тал. |
| 6 | Килажиана А, Чареонсуджай П, 2021<br><br>“БОНБҮ-ний менежментийн төлөвлөгөөг | Бан-У-Мунг нэртэй уул уурхайн тосгон орших орон нутгийн иргэд | Иргэд, уул уурхай компани хоорондын зөрчлийг тодорхойлох, хяналт шалгалт хийсний дараа БОНҮБ-д иргэдийг оролцуулах | Мэдээлэл дутмаг байдлаас болж зөрчил маргаан үүсэх магадлал өндөр гэдэг утгаараа ижил | Хүнцэлээс бусад хүнд металын агууламж улсын стандартаас доогуур байсан ба суурь | Меконг мөрний зүүн урд хэсэгт, хоёр том төмрийн уурхайн дунд орших жижигхэн газар тариалангийн | Мэдээлэх | Орон нутгийн иргэдэд мэдээллийг хүртээмжтэй олгох,<br><br>Иргэдийн амжиргаанд шууд нөлөөлөл бүхий төслүүдийн талаарх |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх явцад гарсан зөрчил маргаан, хяналт шалгалтын дараах иргэдийн оролцоо: Тайланд дахь уул уурхайн тосгоны жишээ” | | байдлаар зөрчлийг бууруулах арга хэмжээ.<br><br>Орон нутгийн хөрс, усны бохирдол, тухайлбал хүнд металын агууламж нэмэгдсэн гэсэн иргэдийн санаа зовнилд хариу өгч, ус, хөрсний шинжилгээ хийж, суурь үзүүлэлттэй харьцуулсан. | төстэй | үзүүлэлттэй харьцуулахад төдийлөн ихсээгүй байсан.<br><br>Иргэд мэдээлэл дутмаг байдлаас болж санаа зовниж байсан ба улмаар итгэл буурсан тул хяналт шалтгалтын дараа ч зөрчил маргаан байсаар байсан. | тосгон. Нэг ил уурхайгаас 2 км зайтай ба удахгүй 3 уурхай нэмж байгуулагдахаар төлөвлөгдсөн. | | шийдвэр гаргалтад иргэдийг оролцуулах боломж, арга хэрэгсэл. |
| 7 | Гава А, Ф, Грейс М, 2019<br><br>“Олон нийтийн оролцоог хангах үйл явцын хүрээн дэх эрх мэдлийн харилцааг тодорхойлох нь” | Индонезийн Сумбава арал дахь уул уурхайн төсөл | Компанийн зүгээс үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын тулд КНХ-ын бодлогоор дамжуулан иргэдэд зориулсан хөгжлийн төсөл хэрэгжүүлэх үүднээс сан байгуулж, иргэдээс ирэх эсэргүүцлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | Уул уурхайн үйл ажиллагааг тогтвортой явуулах үүднээс орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлдэг туршлагаараа ижил | Орон нутгийн хөгжилд чиглэсэн хөтөлбөр нь хүлээгдээгүй үр дүн авчирсан. Өөрөөр хэлбэл, иргэд санхүүгийн хувьд уул уурхайгаас хамааралтай болж, хугацаа хэтэрсэн зээл ихсэх, мөнгө хөөцөлдсөн сэтгэлгээ бий болох зэрэг үр дагаврууд гарч иргэд уул уурхайг эцэргүүцэх болж, тэднийг | Санхүүгийн хөтөлбөр хэрэгжсэн тосгод урд нь алслагдсан хөдөө аж ахуйн тосгод байсан. Иргэд нь газар тариалан, мал аж ахуй эрхэлж, морь унадаг байсан. Уул уурхайн нөлөөгөөр эдгээр тосгодын эдийн засаг хөгжиж, олны хөлийн газар болсон. | Хамтран ажиллах | Иргэдийн өөрсдийнхөө замаар хөгжих чадавхи бололцоог дэмжсэн цогц бөгөөд байгаа нөөц бололцоонд нь түшиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрх мэдлийг хуваарилах.<br><br>Иргэдэд санхүүгийн дэмжлэгийг оновчгүй байдлаар үзүүлснээс үүссэн сургамжууд. |

| № | Зохиогч(ид), өгүүллэгийн нэр | Хүн ам (Population) | Арга хэмжээ (Intervention) | Харьцуулалт (Comparison) | Үр дүн (Outcome) | Нөхцөл байдал (Context) | Иргэдийн оролцооны түвшин | Дүн шинжилгээнд ашиглах асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэр гаргалтад оролцуулах оролдлого амжилт олоогүй. | | | |

## Хавсралт 4 Ярилцлагуудад хийгдсэн шинжилгээний хүснэгт

### Хавсралт 4.1 Салбарын мэргэжилтнүүд

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, санаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| 1.Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачилга" (MERIT) төсөл | 5 жилийн өмнөхтэй харьцуулахад иргэдийн оролцоо, түүний ач холбогдлын талаарх ойлголт нэмэгдсэн<br><br>Харилцан ашигтай хамтын ажиллагаа хамгийн үр дүнтэй | 2018 оноос хойш Дорнодод уурхайн амьдралын мөчлөгийн талаар сургалт тогтмол хийж байгаа.<br><br>Уурхайн хаалтын төлөвлөгөө иргэдийн оролцоотой хийж байгаа.<br><br>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг иргэдийн оролцоотой байгуулж, хяналт тавих хэрэгтэй. Харин компаниуд зөвшөөрлөө батлуулахын тулд л гэрээ байгуулдаг, ингэснээр өнгөц гэрээ бий болдог.<br><br>Суман дээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан: эрүүл мэнд, иргэний бүртгэл зэрэг төрийн үйлчилгээг хүргэхийн | Хэн мэдээлэл өгч байгаагаас хамааран иргэд харилцан адилгүй хүлээн авдаг.<br><br>Ганц удаагийн мэдээлэл уулзалт хүнд үлдэхгүй, үр дүнгүй.<br><br>Орон нутгийн оролцогч талууд хоорондоо уялдаа холбоо сул.<br><br>Оролцогч талуудын дунд тэнцвэртэй мэдээлэл очдоггүй. | Орон нутагт найдвартай мэдээлэл цаг тухайдаа очдоггүй.<br><br>Орон нутгийн талууд чадавхи, мэдээлэл дутмаг.<br><br>Иргэдийн оролцоо нь хэдхэн хүний бүрэлдэхүүнтэй ИТХ-аар л хязгаарлагдаж байна.<br><br>Мэдээлэл бүх оролцогч талд тэнцвэртэй хүрдэггүйгээс болж зарим чухал мэдээлэл, үйл ажиллагаанаас хоцордог.<br><br>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулдаг орон нутгийн удирдлага, албан хаагчдын чадавхи сул. Тэд нэг гэрээгээ хуулбарладаг ба аль заалтыг оруулах, алийг хасах талаар ойлголт бага. | Мэдээллийн өргөн хүрээнд аль болох олон хүнд хүргэх.<br><br>Мэдээллийг давтамжтай өгч, хамтын ажиллагааг өргөжүүлэх.<br><br>Зарын чанартай мэдээллийг нийгмийн сүлжээгээр өгч, албан болон албан бус бүх талын мэдээллийн сувгийг үр дүнтэй ашиглах.<br><br>Сумын төвд уул уурхайн мэдээллийн цэг байгуулах санал олон иргэд, оролцогч талуудаас гарсан. | Орон нутгийн мэргэжилтэн, багш нарын өгсөн мэдээлэлд иргэд илүү итгэх хандлагатай.<br><br>Компаниуд дутуу мэдээлэл өгөх, үр дүнгүй аргаар мэдээлэл түгээснээс болж иргэд байгаль орчны сөрөг нөлөөллийг орон нутгийн удирдлага компаниудаас авилга авсантай холбож ойлгодог. Ийнхүү нийтлэг сөрөг хандлага нь хайгуул зэрэг уул уурхайн бүх үйл ажиллагааг эсэргүүцэх үндэс болдог<br><br>Уурхайн хаалтын талаар иргэдэд эртнээс мэдээлэл өгөх нь иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Учир нь, ухсан нүх үлддэг сөрөг туршлагаас болж иргэд үл итгэх |

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, санаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| | | хажуугаар иргэдэд мэдээлэл өгсөн нь хэн хэндээ ашигтай сайн туршлага болсон | | | | хандлагатай болсон. |
| 2. Олон улсын санхүүгийн корпорацийн “Хөгжлийн төлөөх ил тод байдал” (D2D) хөтөлбөр | Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрөөр дамжулан оролцоог хангаж, итгэлцлийг бий болгох боломжтой.<br><br>Гэрээ байгуулах нь оролцооны нэг хэлбэр. ОНХАГ-нд орон нутгийн хэрэгцээ шаардлагыг сайн тусгадаг компаниуд бий (ж, Булган аймгийн Бүрэгхангай сум). Орон нутаг, компани бүр дээр харилцан адилгүй. Гэвч ерөнхий дүр зургаар ОНХАГ байгуулах явцад иргэдийн оролцоо хангалтгүй. | Оюу Толгой ХХК болон Төв аймгийн сумдад “Хил хязгааргүй алхам” ТББ иргэдийн оролцоотой усны мониторинг хийсэн. | ЗГ чухал мэдээллийг ил тод болгох асуудал дээр хойрго хандаж байгаагаас холбогдох мэдээллийг иргэдэд дамжуулахад хүндрэлтэй байдаг.<br><br>Гэвч иргэд ЗГ-ийг хүлээлгүй өөрсдөө байхгүй мэдээллээ эрж хайж, хяналт тавих хэрэгтэй.<br><br>Дээрээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудыг тархи угаах ажил гэж хүлээн авдаг болсон байна. Тиймээс баримт нотолгоотой өгөгдөл дээр үндэслэж ярих хэрэгтэй. Өгөгдөлд суурилсан яриа хэлэлцүүлэг хийх шаардлагатай. | Уул уурхайн үр өгөөжийн талаарх олон нийтийн ойлголт дутмаг. Жишээ нь, улсад төлж буй татварын 80 хувийг 10-аад компани л төлж байна. Гэвч жижиг компаниуд эдийн засагт төдийлөн хувь нэмэр оруулдаггүй.<br><br>Мэдээллийг тохиромжгүй байдлаар хүргэх тохиолдол элбэг байна.<br><br>Компаниуд тусгай зөвшөөрөл олж авахын тулд хуурамч нөөцийн тайлан гаргах асуудал бий.<br><br>Компаниуд дан дангаараа мэдээлэл сурталчилгаа хийх нь төдийлөн үр дүнтэй биш. | Иргэдэд холбогдох мэдээллийг давтамжтай өгөх.<br><br>Өгөгдлийн тусламжтай иргэд мэдээллийн үнэн худлыг ялгаж чадна.<br><br>Нийгэм, засаглалын асуудлыг шийдэхэд чиглэсэн баримт нотолгоотой, нарийвчлалтай, үнэн бодит мэдээллийг ил тод болгох хэрэгцээ шаардлага өндөр байна.<br><br>Сэтгүүлчид мэдээлэл цуглуулж, иргэдэд дамжуулдаг ч одоо өгөгдөлд үндэслэж нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөлөл, түүний учир шалтгааныг иргэдэд тайлбарлаж хүргэх шаардлага бий болж байна.<br><br>Компаниуд хамтарч тухайн аймаг, сумандаа олон нийтэд мэдээлэл түгээх, оролцоог хангах | Мэдээллийг хэрхэн ил тод болгож буй хэлбэрээс шалтгаалан олон нийтийн ойлголт хандлага төлөвшдөг. Харин одоогийн байдлаар мэдээллийг ил тод болгож буй байдал нь хэтэрхий өнгөц, доороос дээш чиглэсэн (органик) биш байна.<br><br>Уул уурхайн талаар шуугиан дэгдэхэд мэдээллээс хомс байсан олон нийт гэнэт гарч ирсэн хэт их мэдээллээс залхах, улстөржсөн эсвэл санаатай тараасан ташаа мэдээлэл их байдаг учир мэдээлэлд итгэхгүй байх явдал их.<br><br>Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингоор |

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, санаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажил зохион байгуулбал үр дүнтэй.<br>Орон нутагт мэдээлэл түгээдэг идэвхитэй иргэд, орон нутгийн удирдлага, улстөрчид, олон нийттэй харилцах мэргэжилтнүүдийн өгөгдөл ашиглах, танилцуулах чадавхийг бэхжүүлэх. | дамжуулж итгэлцлийг бэхжүүлэх боломжтой. |
| 3. Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци | Компаниуд өөр өөрсдийн олон нийттэй харилцах бодлого хөтөлбөр хэрэгжүүлдэг<br>Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, барууны хөрөнгө оруулагчид орж ирснээс хойш иргэдийн оролцоо гэдэг ойлголт бий болж, иргэд мэдэх эрхээ эдэлж эхэлсэн. | Иргэдийн оролцоотой байгаль орчны мониторинг иргэд өөрсдөө оролцож, байгаль орчны гол асуудлуудыг тодорхойлдгоороо үр дүнтэй байдаг.<br>Энэ нь хөндлөнгийн хяналт хийх, иргэдийн оролцоог хангах, итгэлцлийг бэхжүүлдгээрээ давуу талтай. | Иргэдийн оролцоотой усны мониторинг хязгаарлагдмал хүрээнд хийгдэж байна.<br>Өнгөрсөн болон одоогийн зөрчил маргаантай асуудлууд, эдийн засгийн хүндрэл.<br>Компанийн иргэдийн оролцоог хангах засаглал сул: ажилтнууд нь шийдвэр гаргах эрх мэдэл бага, харилцааны ур чадвар сул, мэргэжлийн олон нийттэй харилцах хүний нөөц байхгүй.<br>Олон нийттэй харилцах чиглэлээр сургалт, боловсролын | Уул уурхай Зөвлөлтийн соёлд зндэслэн хөгжсөн тул олон нийтийн оролцоо, байгаль орчны асуудлууд орхигддог байсан.<br>Орон нутгийн удирдлага шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал. | Ассоциацын дэргэд мэдлэгийн төв юмуу клуб байгуулж, туршлага солилцох боломж бүрдүүлэх.<br>Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) болон хариуцлагатай уул уурхайн стандартуудыг компаниудад нэвтрүүлэх<br>КНХ болон холбоодод түшиглэх нь үр дүнтэй механизм<br>Хууль эрхзүй, ялангуяа эрх тэдийгүй үүргийнх нь талаар иргэд, компаниудад мэдээлэл сайн өгөх | |

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, санаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөр байхгүй.<br>Улстөржсөн мэдээлэл их | | | |
| 4. ОҮИТБС | Олон нийтэд зориулсан мэдээллийн урсгал хомс байдаг. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа, хамгийн их ачаалал авч байгаа сум, орон нутгийн иргэд бодит мэдээлэл авч чадахгүй байна. Компаниуд төлсөн татвар, улс орны эдийн засагт оруулж байгаа хувь нэмрээрээ пи ар хийж байгаа нь орон нутгийн иргэдэд хамааралгүй байдаг. “Ил тод орон нутаг” сонины хоёр дугаарыг 300, 1000 хувь хэвлэж орон нутгийн иргэдэд тараасан. Ийм сонины эрэлт хэрэгцээ их байгаа нь ажиглагдсан. | Чадавхжсан ИНБ-уудын оролцоо, нөлөөлөл чухал үүрэг гүйцэтгэж байгаа. ОҮИТБС-ын 2022 оны баталгаажуулалтын үнэлгээнд Монгол Улс дунд түвшинд, 70 оноо авсан. Оролцогч талуудыг тус тусад нь үнэлэхэд иргэний нийгэм л хамгийн өндөр оноог нь авч байсан. | Үнэн бодит мэдээлэл олдоцгүй байхаар орон нутгийн иргэд худал ташаа мэдээлэл авч, эцсийн дүндээ ам дамжсан худал мэдээлэл тарж эхэлдэг. Иймэрхүү мэдээлэл тарсанаас иргэд компанийг эсэргүүцэхдээ буруу үйл ажиллагааг нь залруулах тийшээ биш, бүр хориглоод, тусгай зөвшөөрлийг нь эрсдэлд оруулаад, бүр хаалгаа хаах хэмжээнд уур амьсгал, иргэдийн хандлага хөөрч, дэвэрч байгаа.<br>Сонин гаргахад орон нутгийн удирдлагаас мэдээлэл олж авах хамгийн бэрхшээлтэй байсан. Мэдээллүүдээ сумын удирдлага нь өгөөд, нэг хэсэг нь мэдээлэл дээр нь ажиллаад, нэг хэсэг нь тараагаад явах хэрэгтэй. Ядаж л сумын түвшинд | Шийдвэр гаргах түвшний хүмүүс, компани талдаа ч, орон нутгийн удирдлагууд талдаа ч иргэд юу, ямар мэдээлэл хүсдийг сайн мэддэггүй. Тэгээд дээрээс гарч ирж байгаа мэдээлэл, доор үүсээд байгаа мэдээллийн хэрэгцээний зөрүү гэж асар ялгаатай харагдсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төлөөлөл орон нутагт дутагдаж байгаа.<br>Хэдийгээр хуулиар шаардсан байдаг ч орон нутгийн удирдлагууд гэрээгээ ил тод болгохгүй байна. Орон нутгийн иргэдийн хамгийн их сонирхдог мэдээлэл тэр гэрээнд байдаг. | Компаниуд мэдээлэл харилцааны ажлаа үр ашигтай байлгахын тулд тухайн нутаг орны онцлогийг сайтар мэддэг байх хэрэгтэй. Тухайлбал, Говийн бүсэд иргэд байгаль орчин, ашигт малтмалын тээвэрлэлтэд илүү санаа зовж, тэр талаарх мэдээллийг сонирхох жишээтэй. ОҮИТБС-аар ил болдоггүй, гэхдээ орон нутгийн иргэдэд хэрэгтэй мэдээллийг ил болгох зорилгоор Говийн бүсийн аймгуудын ил тод байдал гээд санаачилга гаргасан. Ус, ажлын байр, хандивын зарцуулалт гэх мэт задаргаатай мэдээллийг ил болгоё гээд говийн дөрвөн аймгийн уул уурхайн мэргэжилтнүүд, компаниуд, ИНБ, сэтгүүлчдийн төлөөллийг оруулаад цахимаар хуралдсан. Тэрийг ганцхан Дундговь л ирүүлсэн. | Уул уурхай том эрх ашиг хөндөгддөг, их мөнгө эргэлддэг салбар гэдэг утгаараа нэг сувгаас гарч байгаа мэдээлэл үнэн бодит байх гэхээсээ илүү, аль эрх ашиг давамгайлсан байна, тэрэндээ үйлчлэх магадлал анзаарагддаг. |

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, санаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллээ ил болгох хэрэгтэй юм байна гэдгийг орон нутгийн удирдлага ойлгох нь зүйтэй. | | | |
| 5. “Монголиан Майнинг Журнал” сэтгүүл | ММЖ орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан цуврал сургалт зохион байгуулснаар орон нутгийн сэтгүүлчид болон уул уурхайн компаниудын хоорондын ойлголцол сайжирсан. Мөн иргэдэд илүү олон талт, үнэн бодитой мэдээлэл өгдөг болсон. Орон нутгийн сэтгүүлчдийн ажиллах арга барил сургалтаас өмнөх 2010 оныхоос өөр түвшинд шилжсэн. Өмнөговийн Алтанговь телевиз, melmii.mn зэрэг редакцуудад өөрчлөлт ажиглагдаж байсан. | Сэтгүүлчид уурхайг газар дээрээс нь сурвалжилж, янз бүрийн хүмүүсээс ярилцлага авч, илүү олон талт, үнэн зөв мэдээлэл бэлтгэх хүсэл эрмэлзэлтэй болсон. Орон нутгийн сэтгүүлчид хөгжиж, мэдлэгтэй болохын хэрээр редакцууд хөгжиж, зарим нь дрон гэх мэт технологийн дэвшлийг ашиглаж эхэлсэн. | 2019 оноос хойш цар тахал болон бусад шалтгааны улмаас ММЖ сургалтын үйл ажиллагаагаа зогсоосон. Үүнээс болж орон нутгийн сэтгүүлчидтэй харилцах байнгын харилцаа муудаж байна.<br><br>Компаниудын хувьд орон нутгийн иргэдэд хүрч ажиллах, мэдээлэл түгээх үр дүнтэй сувгийн талаар ойлголт дутмаг байдаг. | Компаниуд компанийн засаглалыг мөрддөггүйгээс болж, иргэдэд мэдээллээ өгдөггүйгээс болж асуудал үүсдэг. | Улаанбаатар хотод байгаа хэвлэл мэдээллийн байгууллагууд орон нутгийн сэтгүүлчидтэй хамтран ажиллаад, уул уурхайн чиглэлээр сэтгүүл зүйн бүтээлүүд хийж үндэсний хэмжээнд гаргах боломжтой. Оролцогч талууд орон нутгийн редакцууд, сэтгүүлчид рүү чиглэсэн уул уурхай, мэргэжлийн сэтгүүл зүйн чадавхжуулах сургалт, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлж болно. Хөгжлийн сэтгүүл зүйг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ажиглагдаж байгаа. | Оролцоо сайтай малчны талаар хэрэг, сурвалжилга хийх зэргээр хүн төвтэй бүтээл хийж, орон нутгийн иргэдийн түүхийг хуваалцах хэрэгтэй байна. Нэг хүнээр дамжуулж иргэдийн оролцоог сайжруулж болно. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. “Майнинг Инсайт” сэтгүүл | 2015-2016 онд хаа сайгүй л жагсаал хийдэг болчихсон байсан. Одоо бол зөвшилцлийн арга бий болоод байгаа юм болов уу гэж хараад байна. Олон нийтийн оролцоог хангах талаарх ойлголт сүүлийн таван жилд сайжирсан. | Дугуй ширээний уулзалт, хэлцэл хийх, орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх зэргийг хийж эхлээд байгаа.<br><br>Сэтгүүлчид ч олон талт мэдээллийг, ялангуяа орон нутгийн иргэдийн дуу хоолойг орхигдуулдаг байснаа ойлгож, тэдний туршлагыг хүргэх тал дээр анхаарч эхэлж байна. Майнинг Инсайт сэтгүүл эх сурвалжийн олон талт, тэнцвэртэй байдлыг хангах тал дээр ажиллаж эхлээд байгаа. | Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчид компаниудын, мөн төрөөс өгч байгаа зарим нэг мэдээллийг нэлээд ул суурьтай хардаг байсан. Гэтэл цаана нь хүнтэй холбоотой асуудал орхигдсон байснаас болоод маш их бухимдал, үл ойлголцол бий болчихсон. Шинэ хайгуулын лиценз өгсөн ч гэсэн нутгийн иргэд дэмжихгүй, эсэргүүцэл гараад байгаа нь мэдээллийн тэнцвэртэй байдал байхгүйтэй холбоотой. Эцсийн мөчид л нутгийн иргэдийн эсэргүүцлийн дуу хоолойг л түгээх болчихоод байна. Орон нутгийн удирдлага иргэддээ мэдээллээ өгч чаддаггүй, энэ нь хүний нөөцтэй холбоотой болов уу. | Орон нутагт уул уурхай хариуцсан мэргэжилтэн байхгүй, хавсарч ажилладаг учраас салбараа сайн мэдэхгүй, хэнд ямар мэдээлэл өгөхөө мэдэхгүй, иргэдэд хэлэлцүүлэгт оролцох боломж олгодоггүй байх талтай. Мөн уул уурхай гэхээр орон нутагт дандаа мөнгө харагддаг. Жишээ нь сум, аймгийн ой, сонгууль гээд хуулиас давсан гэдэг ч юм уу, өөр хандив, дэмжлэг хүсдэг. Компаниудын хандив ил тод биш учраас нутгийн иргэд орон нутгийн удирдлагуудаа хээл хахууль, авлига авсан гэж хардах тохиолдол ч гардаг. | Уул уурхайн сэтгүүлчдийн шинэ үеийг бэлтгэх, чадавхжуулах хэрэгцээ байна. Сэтгүүлчдэд суралцах, туршлага солилцох боломж олгох зорилгоор аялал, сургалт семинарууд зохион байгуулж болно.<br><br>Компани олон талт уулзалтыг нэг удаа хийгээд өнгөрөх биш, тогтмол зохион байгуулж, мэдээллийг янз бүрийн сувгаар дамжуулж байх хэрэгтэй. Тухайлбал, онлайн харилцаа холбоо, мэдээлэлд анхаарах хэрэгтэй байна. | Говь-Алтайн Цээл суманд тоосжилтоос болж зам дагуух мал, малчид экологийн сөрөг нөлөөнд өртөж байна. Компани байгаль орчны тал дээр хариуцлагатай ажиллаагүйгээс орон нутгийн иргэдэд уул уурхай Монголд хэрэгтэй юм уу, ийм байдлаар байгаль орчноо сүйтгүүлэх ёстой юм уу гэсэн бодол төрүүлж, уул уурхайд итгэх итгэл нь унасан байсан. Ер нь Говь-Алтай гэлтгүй, маш олон газар уул уурхайд итгэх итгэл доошилсон. |

| Оролцогчид | Иргэдийн оролцоо | Сайн туршлага | Сорилт | Иргэдийн оролцоо сул байгаагийн шалтгаан | Санал болгосон зөвлөмж | Иргэдийн итгэл, саналаа бодолтой холбоотой асуудлууд |
|---|---|---|---|---|---|---|
| 7. Нээлттэй Нийгэм Форум | Ашигт малтмалын хуулиар тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргалтад оролцох иргэдийн эрх олгогдоогүй.<br><br>Мянгаад хүн оролцсон Mining Week чуулганд 10-хан сумын удирдлгаа ТББ-ын урилгаар ирж оролцсон. Хамгийн чухал асуудлын гол оролцогч талууд уригдаагүй нь төрийн засгийн удирдлага иргэд, орон нутгийнхантай нүүр тулахаас зайлсхийж байх магадлалтай гэж дүгнэхэд хүрч байна. | Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах чадавхи, хэрэгжилтийг хянах талаар сургалт явуулж, гарын авлагаа сайт дээрээ тавьдаг. ТББ-уудтай хамтран гэрээний хэрэгжилтэд хяналт тавьдаг.<br><br>Төрийн өмчит компаниудын худалдан авалтын гэрээг ил тод болгох зэргээр уул уурхайтай холбоотой гэрээнүүдийг ил тод болгож, хууль эрхзүйн хүрээнд бодлогын үнэлгээ судалгаа хийдэг (тайлангууд нь цахим хуудсан дээр байгаа). | Малчид, хөдөөгийн иргэдэд цахим мэдээлэл олж авах боломж хомс.<br><br>Уул уурхайтай холбоотой мэдээ мэдээлэл зөрчил маргаан, хариуцлагагүй уул уурхайн талаар давамгай байдаг.<br><br>Засгийн газар тусгай зөвшөөрөл олгох явцыг хэрхэн ил тод болгохоо шийдэж чадахгүй, чадавхи бололцоо нь хангалтгүй байгаагаас болж уул уурхайг зөвөөр таниулахад орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах тал дээр асуудал үүсч байна.<br><br>Нээлттэй мэдээлэл иргэдэд хүртээмжгүй, төрийн байгууллагууд ч авч ашигладаггүй. | Хууль боловсруулах, шийдвэр гаргах явцад иргэний нийгэм, иргэдийн оролцоо хангагдаагүй. ТББ-ууд хэлэлцүүлэг зөвлөгөөн хийж, хуулинд санал оруулдаг ч саналыг хуулиндаа тусгадаггүй.<br><br>Тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгодгоос зөрчил маргаан үүсдэг.<br><br>Нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтийн талаар хууль амьдрал дээр хэрэгждэггүй. Учир нь, хуулинд ерөнхий заасан байдаг ба хэрэгжүүлэх журам нь батлагдаагүй.<br><br>Төрийн байгууллагууд нээлттэй өгөгдлийг бодлого, төлөвлөлтдөө ашигладаггүй.<br><br>Орон нутгийн иргэд эдгээр бодлогын хэлэлцүүлгүүдэд оролцдоггүй, оролцсон ч хангалттай нөлөөлж чаддаггүй. | Хууль болон бодлого боловсруулах явц, захирганы актуудад нэмэлт өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн тухай журам шинэчлэх явцад нийтийн сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах.<br><br>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд эрсдэлийг үнэлж, шийдвэр гаргахаас өмнө төлөвлөлтийн шатанд иргэдэд мэдээлж байж тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс болсон харилцан ойлголцол, зөвшилцөл бий болно.<br><br>Уул уурхайн бодлогыг Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлэх. Хуулийн төсөл, бодлогын баримт бичгүүдийг орон нутгийн түвшинд хэлэлцэж, орон нутгийн иргэдийн дуу хоолойг тусгах.<br><br>Нээлттэй, давтамжтай уулзалт хэлэлцүүлгийг иргэдийг хамруулан өргөн хүрээнд зохион байгуулах. | Хариуцлагагүй уурхайн туршлагаас болж үүссэн сөрөг хандлагын улмаас орон нутгийн иргэд хайгуулын үйл ажиллагаа эсэргүүцэж, улмаар ихээхэн хумигдсан (80 орчим хувиар буурсан).<br><br>Орон нутгийн иргэд хажуудах суманд гарсан байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл өөрсдийнх нь суманд давтагдана гэсэн айдастай болсон. |

## Хавсралт 4.2 Орон нутгийн удирдлага

| Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг дарга | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Бодлого** | **Иргэдийн оролцоо** | **Орон нутгийн хамтын ажиллагаа** | **Сайн туршлага** | **Сорилтууд** | **Санал болгож буй зөвлөмжүүд** | **Итгэл, олон нийтийн ойлголт** |
| 2015-2024 Сумын хөгжлийн мастер төлөвлөгөө;<br><br>ИТХ-аар батлуулсан уул уурхайн хөгжлийн дэд хөтөлбөр | Багийн иргэдийн нийтийн хурлаар БОНБҮ -ний үр дүнг танилцуулдаг, үг танилцуулгаар үнэлгээний үр дүнг танилцуулахаас илүү орон нутагт оруулах хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл өгдөг.<br><br>Орон нутгийн иргэд ямар газар ашиглалтын зөвшөөрөл өгсөн, өгөх гэж байгаа талаар мэдээлэл байхгүй. | Бичил уурхай хумигдсанаас хойш ямар нэгэн оролцоо, хамтын ажиллагаа байхгүй болсон.<br><br>Өмнө нь уг суманд 80 орчим бичил уурхайн нөхөрлөл ажиллаж, жилдээ сумын төсөвт 2-3 зуун сая төгрөгийн татвар төлдөг байсан. Өрхийн болон орон нутгийн эдийн засгийн үр өгөөж хумигдсанаас гадна бичил уурхайг зогсоосноор хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх магадлалтай.<br><br>3Г-ын шийдвэр ойр ойрхон өөрчлөгддөгөөс болж орон нутгийнхан тодорхойгүй байдал их ордог. Тэд бичил уурхайг ТББ, аж ахуйн нэгж, орон нутгийн удирдлагын гурвалсан гэрээний дагуу бичил уурхай эрхлэх боломжийг нээх шинээр гарсан 296-р тогтоол хэрэгжихийг хүлээж байгаа.<br><br>Албан ёсны уурхайн үйл ажиллагаа ч мөн багассан. Засаг даргатай гэрээ хийсэн компаниудын тоо 2021 оныхоос багассан. Гэрээ байгуулсан компаниудын зөвхөн тал хувь нь гэрээгээ биелүүлж байна. Зарим нь КНХ-ын амлалт (ж, спорт заал барих)-аа биелүүлээгүй байгаа. Компаниудын хандлага өөр болж, КНХ-ын үүргээ биелүүлэхээс зайлсхийдэг болсон. Эдгээр | Орон нутгийн гаралтай хүний уул уурхайн компани болон нөхөн сэргээлт сайн хийдэг, түүнийгээ иргэдэд мэдээлдэг уул уурхайн компанийг иргэд сайн компани гэж үздэг. | Орон нутгийн иргэдийн зөвшөөрөлгүй ашиглалтын зөвшөөрөлтэй компани орон нутагт ажиллаж эхэлж байгаад иргэдийн сэтгэл дундуур байдаг. Иргэд анхан шатандаа баг болон сумын засаг даргын өгч буй хариу итгэдэггүй, харин дараагийн шатанд уг зөвшөөрөл өгч буй АМГТГ-ын шийдвэрт итгэдэггүй, авлигад автсан гэж үздэг. | Нийгмийн зөвшөөрөл буюу орон нутгийн иргэдээс тодорхой түвшинд зөвшөөрөл авдаг байх. Мөн орон нутагт, тухайн нөлөөллийн бүсийн иргэдэд ямар хөрөнгө оруулалт хийж байгаа талаар мэдээллийг бүх талуудад ижил тэгш өгч, эргэх холбоотой байх. | Орон нутгийн гаралтай хүний компани, орон нутгийн иргэдийн бичил уурхайн нөхөрлөлд илүү итгэдэг. Уул уурхайн компани, сумын захиргаанд итгэх итгэл бага байдаг. Орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ байдаггүй. ОУБ - ийн оролцоо ямар байх талаар төсөөлөл орон нутгийн иргэдэд байдаггүй. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | компаниудад ирэх жилээс зөвшөөрөл өгөхгүй гэж төлөвлөж байна. | | | | |

**Дундговь аймгийн Хулд сумын засаг дарга**

| Бодлого | Иргэдийн оролцоо | Орон нутгийн хамтын ажиллагаа | Сайн туршлага | Сорилтууд | Санал болгож буй зөвлөмжүүд | Итгэл, олон нийтийн ойлголт |
|---|---|---|---|---|---|---|
| 2020-2024 сумын мастер төлөвлөлөө: орон нутагт уул уурхайгаас ирэх үр өгөөжийг нэмэгдүүлж, хариуцлагатай уурхайг дэмжих, сумандлицензтэй уул уурхайн компаниудтай хамтран ажиллах, жилд дор хаяж 2 удаа хууль хяналтын байгууллагатай хамтарч суманд үйл ажиллагаа явуулж буй олборлолт, хайгуулын үйл ажиллагааг шалгах тухай заасан. | Орон нутгийн иргэд уул уурхайн компанийн өөрсдийн нөлөөллийн бүсийн иргэдэд илүү анхаарал хандуулдагт сэтгэл дундуур байдаг. Орон нутгийн иргэдийн зөвшөөлийг авалгүй үйл ажиллагаа явуулж эхэлдэгт иргэд сэтгэл дундуур байдаг. | Уурхайн нөлөөллийн бүсийн 3-4 км зайд 5-6 өрх багтдаг. Компани тэдгээр өрхөд дэмжлэг үзүүлдэг. Жишээ нь, малын тэжээл өгөх, Манжуур, Улаан-Үдэ рүү аялуулах, г.м. Эдгээр өрх махаа уул уурхайн компани худалдан борлуулдаг.<br><br>Багийн бусад иргэд уг компанийг зөвхөн хэдхэн айл өрхөд анхаарал хандуулж, бусдыг нь орхигдуулаа гэсэн хэл ам гарсны улмаас багийн бүх айл өрхөд даралтны аппарат тараасан (2021 онд).<br><br>Иргэдээс санал гомдол ирсэн тохиолдолд багийн дарга оролцдоггүй, гомдол саналыг сум, аймаг руу хүргүүлдэг. | Өмнө дурдсан сэтгэл дундуур байдлыг бууруулахын тулд багийн бүх иргэдэд материаллаг дэмжлэг үзүүлсэнд иргэд болон тухайн багийн дарга сэтгэл хангалуун байдаг болсон. Баг хөдөөгийн малчдын хувьд өвөлжилтийн хүнд үед болон байгалийн гамшгийн үед өөрсдийн санхүүжилт, материаллаг баазыг ашиглан тусламж үзүүлдэг | Тээврийн машинуудаас гарч буй тоосжилттой холбоотой малчин иргэдийн дунд малын уушги өвчилж байгаа гэсэн байдаг. Энэ асуудлаар санал гомдол гаргасан ч шийдэгдэхгүй гэсэн ойлголттой. Уул уурхайтай холбоотой иргэдийн гаргасан санал гомдол хэрхэн шийдэгдсэн талаар мэдээлэл байхгүй, өгсөн мэдээлэл нь иргэдэд ойлгомжтой биш байдаг. | Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл буюу орон нутгийн иргэдээс тодорхой түвшинд зөвшөөрөл авдаг байх. Мөн орон нутагт, тухайн нөлөөллийн бүсийн иргэдэд ямар хөрөнгө оруулалт хийж байгаа талаар мэдээллийг бүх талуудад ижил тэгш өгч, эргэх холбоотой байх. | Иргэдийн санал авахгүй болохоор итгэл төрөхгүй байх гэх мэт. Асуудал хэлсэн ч шийдэгдэхгүй, ойлгомжгүй хариу өгдөг. |

## Хавсралт 4.3 Орон нутгийн иргэд

| # | Олон нийтийн оролцоо | Сайн туршлагууд | Сорилтууд | Үр дүнгүй байгаа шалтгаан | Санал болгож буй зөвлөмжүүд | Итгэл, олон нийтийн ойлголт | Доноруудын оролцоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бүрэгхангай сум | БИНХ -аар БОНБҮ -ний үр дүнг танилцуулдаг, уг танилцуулгаар уг үнэлгээний үр дүнг танилцуулахаас илүү орон нутагт оруулах хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл өгдөг. Орон нутгийн иргэд ямар газар ашиглалтын зөвшөөрөл өгсөн, өгөх гэж байгаа талаар мэдээлэл байхгүй. | Орон нутгийн гаралтай хүний уул уурхайн компани болон нөхөн сэргээлт сайн хийдэг, түүнийгээ иргэдэд мэдээлдэг уул уурхайн компанийг иргэд сайн компани гэж үздэг. | Орон нутгийн иргэдийн зөвшөөрөлгүй ашиглалтын зөвшөөрөлтэй компани орон нутагт ажиллаж эхэлж байгаад иргэдийн сэтгэл дундуур байдаг. Иргэд анхан шатандаа баг болон сумын засаг даргын өгч буй хариу итгэдэггүй, харин дараагийн шатанд уг зөвшөөрөл өгч буй АМГТГ -ийн шийдвэрт итгэдэггүй, авлигад автсан гэж үздэг. | Хамтын ажиллагааны гэрээний биелэлт муу байх, нөхөн сэргээлт хийхгүй байх, хийсэн ч түүнийг тухайн багийн иргэд тэр дундаа суман нийт иргэдэд мэдээлдэггүй байдал. Бусад хариуцлагагүй компаниас болж бусад компанийн БОНБҮ -ний тайланг БИНХ-ийн хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасдаг. Мөн орон нутгийн иргэдийн тахилгат хайрхны өвөрт баяжуулах үйлдвэр ажиллаж байгаа нь орон нутгийн иргэдийн дургүйцлийг хүргэж байна. | Нийгмийн зөвшөөрөл буюу орон нутгийн иргэдээс тодорхой түвшинд зөвшөөрөл авдаг байх. Мөн орон нутагт, тухайн нөлөөллийн бүсийн иргэдэд ямар хөрөнгө оруулалт хийж байгаа талаар мэдээллийг бүх талуудад ижил тэгш өгч, эргэх холбоотой байх. | Орон нутгийн гаралтай хүний компани, орон нутгийн иргэдийн бичил уурхайн нөхөрлөлд илүү итгэдэг. Уул уурхайн компани, сумын захиргаанд итгэх итгэл бага байдаг. | Орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ байдаггүй. ОУБ -ийн оролцоо ямар байх талаар төсөөлөл орон нутгийн иргэдэд байдаггүй. |

| # | Олон нийтийн оролцоо | Сайн туршлагууд | Сорилтууд | Үр дүнгүй байгаа шалтгаан | Санал болгож буй зөвлөмжүүд | Итгэл, олон нийтийн ойлголт | Доноруудын оролцоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хулд сум | Орон нутгийн иргэд уул уурхайн компанийн өөрсдийн нөлөөллийн бүсийн иргэдэд илүү анхаарал хандуулдагт сэтгэл дундуур байдаг. Орон нутгийн иргэдийн зөвшөөрлийг авалгүй үйл ажиллагаа явуулж эхэлдэгт иргэд сэтгэл дундуур байдаг. | Өмнө дурдсан сэтгэл дундуур байдлыг бууруулахын тулд багийн бүх өрхөд материаллаг дэмжлэг үзүүлсэн. Малчдад өвөлжилтийн хүнд үед болон байгалийн гамшгийн үед өөрсдийн санхүүжилт, материаллаг баазыг ашиглан тусламж үзүүлдэг. | Тээврийн машинуудын үүсгэж буй тоосжилттой холбоотой малчин иргэдийн дунд малын уушги өвчилж байгаа гэсэн хандлага байдаг. Энэ асуудлаар санал гомдол гаргасан ч шийдэгдэхгүй гэсэн ойлголттой. Уул уурхайтай холбоотой иргэдийн гаргасан санал гомдол хэрхэн шийдэгдсэн талаар мэдээлэл байхгүй, өгсөн мэдээлэл нь иргэдэд ойлгомжтой биш байдаг. | Компани орон нутгийн удирдлагатай хэт ойр ажиллах нь иргэд удирдлага, уул уурхайн компанид үл итгэх нөхцөл үүсдэг.<br>Мөн нөлөөллийн бүсийн өрхийн иргэдэд илүү анхаарал хандуулдаг. /Санхүүгийн дэмжлэг, аялуулах, худалдан авалт, гэх мэт/ | | Иргэдийн саналыг авахгүй болохоор итгэл төрөхгүй байх гэх мэт. Асуудал хэлсэн ч шийдэгдэхгүй, ойлгомжгүй хариу өгдөг. | |

## Хавсралт 4.4 Засгийн газар

| Оролцогч | Сорилтууд | Иргэдийн оролцоо | Бодлогын орчин | Орон нутгийн хамтын ажиллагаа |
|---|---|---|---|---|
| Уул уурхайн яамны Геологийн бодлогын газрын дарга | “Мэдээлэл хомс байдлаас зөрчил их үүсдэг. Төрийн байгууллага мэдээллээ дутуу өгдөг. Мэдээлэл иргэдэд хүрдэггүй эцсийн шалтгаан нь мэдээллээ тараах ёстой нэгж /Сумдын ЗДТГ/ нь түгээдэггүй. Мэдээлэл хомс байдал нь иргэдийн өөрсдийнх нь санаачилгаас мөн хамаардаг. Засгийн газрын харьяа яам, байгууллагуудын хувьд мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалт нээлттэй байдаг. Жишээ нь, тусгай зөвшөөрөл, улсын хэмжээний судалгааны ажлуудтай холбоотой мэдээлэл тухайн ажлыг хариуцсан агентлагуудын сайт дээр байдаг ч иргэд өөрсдөө хайж олдоггүй, ханддаггүй. | Иргэдийн санал, гомдол яаманд ирсэн тохиолдолд яамны зүгээс хариуг нь 30 хоног дотор өгнө. Шаардлагатай тохиолдолд нэг удаа сунгахаар зохицуулсан байдаг. Яаманд иргэдийн гомдол, саналыг архивладаг. Гэхдээ тэр нь олон нийтэд нээлттэй эсэх нь тодорхойгүй. | Бодлогыг нь яам гаргаад, түүнийг хэрэгжүүлдэг газар нь Ашигт Малтмал Газрын Тосны Газар. Бид мэдээллээ ил тод байлгах өөрсдийн механизмаа хэрэгжүүлж байгаа. Манай сайтаас статистик, мэдээ мэдээллээс нь болж буй үйл явдлуудыг харж болно. | Уул уурхайн компани, байгаль орчны хайгуул хийж буй компани нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулахдаа мэдээллээ иргэдэд өгч байх ёстой. Үүнийхээ дагуу байгаль орчны байцаагч нь мэдээллээ ард иргэддээ зөв түгээгээгүйгээс болоод асуудал үүсдэг. Яг иргэд мэдээлэлтэй байвал асуудал бага үүсдэг. Тэгэхээр мэдээллээ бүрэн авчихвал хандлага нь өөрчлөгдөх бүрэн боломжтой.<br><br>Танайх энд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа бол хариуд нь бүтээн байгуулалт хийх хэрэгтэй гэж иргэд шаардах хэрэгтэй. Уул уурхайн тухай зөв ойлголтыг бүүр цэцэрлэгээс нь эхэлж олгох ёстой. Тэгэхээр энэ нь 1 жилийн асуудал бус үе шаттай мэдлэг эзэмшинэ гэсэн үг. Одоо бол чадлаараа л үргэлжлүүлээд явж байвал хүүхдүүд маань ерөнхий мэдлэг сайтай байгаа гэж найдаж байна. Эсвэл 14-15 насны хүүхдүүд рүү төвлөрч, шинжлэх ухааны хүнд сэдвүүдэд суралцдаг үед нь энд бид ажиллаж байна, гэхдээ уурхай үүсэх магадлал 0.020% гэх мэтээр мэдээлэл олгох юм. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулахыг хүсч байгаа компаниудтай хамтраад нийгмийн хариуцлагын хүрээнд багачуудаа сургаж болно гэж харж байна. |
| АМГТГ-ын Хэвлэлийн төлөөлөгч | Монгол хүмүүсийн тахилга шүтээнтэй уул усны ойролцоо тусгай зөвшөөрөл олгосноос ихэнх зөрчил үүсдэг. жишээтэй. Үүнээс болоод газар нутгаа ухуулахгүй гэх мэт. Сэтгэхүйд нь энэ бол миний өвөг дээдсийн нутаг гэсэн үзэл бодолтой. Нэг талаас амьдрах орчноо алдахгүй гэсэн хүний зөрчил, нөгөө | Иргэдээс АМГТГ-т шууд гомдол, саналаа иргүүлж болдог. Жилдээ 100 гаруй гомдол ирдэг. Засгийн газрын 1111 төвөөр, яамаар дамжаад, эсвэл малчид өөрсдөө манай байгууллагын гадаа үүдэнд ирээд сэтгүүлчдийг дуудаж байгаад мэдээлэл хийх гэх мэтээр гомдлоо өгдөг. Нутгийн иргэд ихэвчлэн газар нутгаа ухуулмааргүй байна, энэ | Байгаль орчны үнэлгээ хийх ажилд иргэдийг оролцуулах үүрэг сумын ИТХ-д байдаг. Тэр хүмүүс чадавхжих ёстой.<br><br>Иргэдийн байр сууръ, санал гомдлыг уул уурхайн компани боломжоороо судлаад үйл ажиллагаандаа тусгадаг.<br><br>Сум болгонтой компаниуд нийгмийн хариуцлагын гэрээ гэж хийдэг. Газрын тосны | Австрали, Канад, Америк орнуудын жишээгээр хайгуул хийж байх явцдаа яаж орон нутгийн харилцаагаа зохицуулдаг вэ гээд аваад үзэхээр тэр үедээ сайн багш нийгмийн зүтгэлтнүүдийг орон нутагтаа байршуулдаг. Тухайн хүмүүстээ сар болгон компаниас урамшуулал олгодог нууцын гэрээгээр. 50-100 өрх байршуулаад орон нутагт нөлөөллийн замаар ажилладаг. Канад, Австралид байсан. Үүнийг Монголд хэрэгжүүлэх боломжтой.<br><br>Манай агентлагийн зүгээс тэр аймгийн тэр нутаг дэвсгэрт тийм тусгай зөвшөөрөл тэдэн сарын |

| Оролцогч | Сорилтууд | Иргэдийн оролцоо | Бодлогын орчин | Орон нутгийн хамтын ажиллагаа |
|---|---|---|---|---|
| | талаас ажил хийх гээд тодорхой хэмжээний эрсдэл үүрээд очиж буй иргэдийн зөрчил, гуравдагч талаас өөрийн сонгох сонгогдох эрхийг хамгаалах гэж буй сумын удирдлага гэсэн 3 талын зөрчил байна. Үүнийг засгийн газрын түвшинд, хуулийн түвшинд зохицуулалт хийхгүй бол уул уурхайн компаниуд энэ байдлаараа удаан хол явахгүй.<br><br>Мөн тухайн суманд олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг ЗГ батлахаас өмнө аймгийн Засаг дарга, ИТХ-д өгдөг ч тэд цаашаагаа иргэддээ мэдээллээ өгдөггүйгээс зөрчил үүсдэг.<br><br>Иргэдэд хүргэх мэдээлэл хангалтгүй байдгаас бас үл ойлголцол үүсдэг. Компаниудад иргэдтэй хэрхэн харилцаж мэдээлэл хүргэх тухай ойлголт дутмаг байдаг. Орон нутгийн захиргаа нь ч иргэддээ яаж мэдээллээ өгөх арга ухаанаа олдоггүй. | компанийн лицензийг цуцлаад өгнө үү гэж хүсдэг.<br><br>Компани газар ухчихаад нөхөн сэргээлт хийхгүй байна, байгаль орчныг бохирдуулж байна, уул ус ширгэж байна, химийн бодис хэрэглэж байна гэсэн шалтгаанаар иргэд малчид гомдол гаргаж байна.<br><br>Тэдгээр гомдлыг хариуг манай газрын уул уурхайн хэлтсээс иргэнд 3 хоногийн дотор хариу өгнө.<br><br>Мөн тухайн компанитай холбогдож гомдлыг танилцуулаад хэрхэн анхаарч ажиллах чиглэл өгдөг.<br><br>Тэрний мөрөөр компани хэр ажилладаг мэдээлэл буцаж ирүүлдэггүй, эргэх холбоо байхгүй.<br><br>Иргэд ч эргэж холбогдсон тохиолдол одоогоор нэг ч алга.<br><br>Иргэдийн гомдлыг хэрхэн барагдуулахыг зохицуулсан дүрэм журам манай газар байхгүй. | тухай хуульд тодорхой тусгаж өгсөн байдаг. Танай компани хайгуул хийж буй явцдаа тийм төгрөг төлнө гэх жишээтэй. Газрын тосны тухай хуульд дэлгэрэнгүй ойлгомжтой тусгасан байдаг. Компани, сумын Засаг дарга хоёр нийгмийн хариуцлагын гэрээгээ хийхдээ юу юу хийх боломжтой гэдгээ ярилцдаг. | тэдний өдөр тийм сонгон шалгаруулалтаар зарлалаа гээд явуулдаг. Аймгийн орон нутгийн сайтаар дамжуулаад иргэдэд аль болох нээлттэй байдлаар хийх хэрэгтэй.<br><br>Тухайн суманд бүтээн байгуулалтын ажил чухал уу чухал. Гэхдээ үүнээс урьтаж хүний хөгжилд анхаарах нь чухал. Жишээ нь иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын удирдлагууд дунд уул уурхайн наад захын зүйл ойлгохгүй хүмүүс байдаг ба тэр хүмүүс иргэддээ юу ойлгуулахыг хэлж мэдэхгүй байна. Эхлээд сумын иргэдээ мэдлэгтэй, мэдрэмжтэй болгохын тулд сумын төрийн албан хаагчид болон ИТХ-ын гишүүдийг чадавхжуулах хэрэгтэй байна. |

## Хавсралт 4.5 Уул уурхайн компанийн төлөөлөл

| Оролцогч | Сорилтууд | Иргэдийн оролцоо | Бодлогын орчин | Орон нутгийн хамтын ажиллагаа |
|---|---|---|---|---|
| “Хос хас” компанийн байгаль орчны зохицуулагч | Иргэд дутуу юм уу эсвэл буруу мэдээлэлтэй байгаагаас гол маргаан үүсдэг. Тухайлбал тэд нөхөн сэргээлт хийх ач холбогдол нь юу вэ? Уул уурхайн процесс өөрөө яаж явдаг гэдгийг бүрэн дүүрэн ойлгоогүй байна. | Орон нутгийн иргэд багийн иргэдийн нийтийн хурал дээрээ асуудлуудаа гаргаж ирдэг. Компанийн зүгээс би төлөөлөөд уурхайн нөлөөллийн бүс орчмын айл өрхүүдээр жилд нэг удаа явж уулзсан. Ингээд явж байхад иргэдийн санал санаачилга гарч ирдэг.<br><br>Иргэддээ мэдээллээ түгээнгээ бас судалгаа, тандалт авдаг гэсэн үг.<br><br>Тэгээд түүнийгээ удирдлагуудад танилцуулдаг. | Бид нийгмийн хариуцлагын гэрээнийхээ хүрээнд харьяа орон нутгийн байгууллагуудтай хамтарч хийсэн ажил олон байгаа. Орон нутгийг удирдлагуудын зорилго ч гэсэн аль болох дэд бүтцийн, цаашдаа үлдэхээр ажлууд дээр хамтарч ажиллах сонирхолтой байдаг. Тухайлбал сумын төвд хатуу хучилттай зам байгуулах, малчдын унд ахуйн ус, худгийн барилга байгууламжийг нь шийдэж өгсөн. Эдгээр ажлыг бид өөрсдөө санаачлаад хэрэгжүүлээгүй. Иргэдээс илүү төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн удирдлагууд санаачилсан. Харин худаг усны ажлуудыг малчид өөрсдөө санаачилсан. | Иргэдийн ойлголтыг сайжруулах нь төрийн байгууллагын хийх ёстой ажил шүү дээ. Манай компанийн тухайд энэ чиглэлээр яг бодлого, төлөвлөгөө гаргасан зүйл бол байхгүй. |
| “Монполимет” компанийн газрын дарга, Олон нийттэй харилцах мэргэжилтэн нар | Манай компани олон жил ажилласан туршлагатай, нөхөн сэргээлтээ сайн хийсэн учраас сүүлийн 5 жилийн байдлаар иргэдтэй үл ойлголцол, томоохон зөрчил байхгүй.<br><br>Гэхдээ нөхөн сэргээлт хийсэн талбай руу малчид малаа бэлчээж бүхэн ургаагүй өвс, мод сүйтгэснээс болж хааяа багахан хэмжээний зөрчил гардаг. | Манай компанид иргэдээс гомдол санал ирээгүй. Бид үйл ажиллагаагаа багийн иргэдийн хурал дээр нээлттэй тайлагнадаг. | Бид жилдээ 4-5 удаа орон нутгийн иргэдтэйгээ уулзалт хийдэг. Бид нар тухайн жил хийсэн нөхөн сэргэлтийн ажлаа жил болгон тайлагнадаг. Тэгэхээр орон нутгаас бас комисс гарч ирж ажилладаг. Засаг дарга, байгаль орчны байцаагч гэх мэт хүмүүс нь аймгаас нь ирээд түүн дээр нь бид энэ жил ийм газрыг нөхөн сэргээсэн гэдгээ хүлээлгэж өгдөг.<br><br>Хоёрдугаарт нь бид жил бүр нийгмийн хариуцлагын гэрээ хийдэг. Үүн дээр орон нутаг өөрсдөө саналаа гаргадаг. Ийм ажлууд хийх боломжтой байна, Танайх үүнээс алийг нь хийх вэ гээд. Түүнийг нь бид дотроо өөрсдөө ярилцаж орон нутагтай зөвшилцөж байгаад ийм ийм ажлуудыг нь манай зүгээс хийх боломжтой гээд ярилцдаг. Гуравдугаарт нь бид аль болох худалдан авалтаа орон нутгаас хийхийг | Орон нутагт ямар нэгэн төсөл эхлүүлэхтэй зэрэгцээд тухайн иргэдийн ойлголтыг тандах, эрэлт хэрэгцээг нь тандах, хамтын ажиллагаагаа амжилттай болгох нөхцөл байдлын үнэлгээ судалгааг манай компани Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр дамжуулаад авчихдаг. Энэ сайн үр дүнтэй.<br><br>Орон нутгийн иргэдэд ямар хэрэгцээ байна, ямар саналтай байна, юу хүсч байна гээд бүх юм нь тэнд байж байдаг.<br><br>Судалгааг 5 жилд 1 хийнэ. Тэгээд үүндээ тулгуурлаад хамтын ажиллагаагаа хийвэл үр дүнтэй болдог.<br><br>Аливаа төсөл эхлэхээс нь л бүх мэдээллээ |

| Оролцогч | Сорилтууд | Иргэдийн оролцоо | Бодлогын орчин | Орон нутгийн хамтын ажиллагаа |
|---|---|---|---|---|
| | | | зорьдог. Уурхай ажилчдын мах, сүү зэргээ орон нутгаасаа авах бас зарим шаардлагатай тохиолдолд хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг орон нутагт хийж байгаа тохиолдолд авдаг.<br><br>Жил бүр манай уурхай дээр л гэхэд дор хаяж 10 гаруй удаа Төрийн байгууллагын хяналт шалгалт явдаг. Энэ болгон дээр орон нутгаас төлөөлөл заавал байлгадаг. | иргэдэд өгөх хэрэгтэй. Тухайлбал энэ төсөл иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх вэ? Компани ямар бүтээн байгуулалтууд хийх вэ? Үр дүнд нь ажлын байр нэмэгдэх үү гэх мэт ойлголтыг зөв өгчихвөл орон нутгийн иргэд, малчид ойлголцдог. Хандлага нь зөв болдог. |

## Хавсралт 5 Компаниудын цахим хуудасны контент дүн шинжилгээ

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Багануур ХК | baganuurmine.mn | Багануур ХК нь тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болох эрхэм зорилготой. | Цахим хуудас “Тогтвортой хөгжил” цэстэй нь нийгмийн хариуцлага, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал дэд бүлэгт хуваагддаг. Тус компани 2013 онд Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, “Normisur International”-ын зөвлөхүүдтэй хамтран 2014-2016 оны Нийгмийн хариуцлагын стратеги төлөвлөгөөгөө гаргажээ. | Компанийн 2021 оны жилийн тайланд байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт, орон нутгийн хамтын ажиллагааны бүлэг багтаасан бөгөөд байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгчээ. Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс хэрэгжүүлэх санамж бичигйг Багануур ХК Багануур дүүргийн төр захиргааны байгууллагатай үйлдэж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр ажилласан. Дүүргийн Онцгой комисс, Эрүүл мэндийн төвд 11 сая төгрөгийн COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх бүтээгдэхүүн хандивлах, хүчилтөрөгчөөр хангах зэрэг ажил багтаж байна. Мөн ЖДҮ-ийг дэмжих төвөөр дамжуулан ажлын хувцас, бээлий хийлгэжээ. | Цахим хуудас нь "Мэдээ" цэстэй бөгөөд байнга шинэчилдэг. Нийгмийн хариуцлагын хүрээнд эмзэг бүлгийн 283 өрхөд нүүрс хандивласан, "Архигүй Монгол" хөдөлгөөнд нэгдсэн, Монголын Улаан Загалмайн нийгэмлэгт компанийн ажилчид хандив өгсөн тухай мэдээ мэдээллийг хүргэжээ. Байгаль орчны хүрээнд тус компани “Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 4000 мод тарьснаа мэдээлжээ. Мөн тус компанийн биологийн төрөл зүйл, хог хаягдлын менежмент, усны менежмент, байгаль орчны хяналт, нөхөн сэргээлтийн талаарх зурагт хуудсыг гаргасан байна. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Бадрах Энержи ХХК | www.badrakhenergy.com | Бадрах Энержи өөрийн танилцуулгадаа “олон улсад шалгарсан туршлага бүхий стандартыг мөрдөж, байгаль орчин хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн салбарт шилдэг үзүүлэлттэй ажиллаж буй” хариуцлагатай уул уурхай хэрэгжүүлэгч хэмээн заажээ. Мөн компанийн нийт 86 ажилтны 96 хувь нь монголчууд гэдгийг онцолж байна. | Цахим хуудас нь "Байгаль орчин," “Орон нутаг" гэсэн цэстэй. Тус компани 2013 оноос байгаль орчны хяналтыг компани, орон нутгийн удирдлага, иргэд гэсэн гурван талт хамтын ажиллагааны үндсэн дээр явуулдаг. Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналтын хөтөлбөр хэрэгжүүлдгээ онцолжээ. Компани нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дараах байдлаар удирддаг:<br>-Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм, эдийн засгийн орчны талаарх бүрэн ойлголттой болох зорилгоор судалгааны ажил хийх,<br>-Ажлын байр бий болгож, нутгийн иргэдэд үйлдвэрлэлийн болон бусад ур чадвар олгох сургалт зохион байгуулах,<br>-Орон нутагт үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг худалдан авах,<br>-Нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх дэд бүтцийг хөгжүүлэхийг дэмжин ажиллах. | Тогтвортой хөгжлийн 2020 оны тайланд компанийн нийгмийн хариуцлага, орон нутгийн ард иргэд, байгаль орчин, хүний нөөц, эрүүл мэнд, аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, хангамжийн сүлжээ зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл багтаажээ. Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөл, мэдээллийн өдөрлөг, малчдын өдөрлөг, мөн хоёр жилд нэг удаа хийдэг иргэдийн судалгаа, зөвлөгөөн, орон нутгийн арга хэмжээнүүд нь орон нутаг, малчдын оролцоог хангах арга хэлбэр аж. Тус компани 2006 оноос хойш орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд 5.6 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Мөн оролцогч талуудыг төлөөлсөн Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх хороо нь төсөл, хөтөлбөрүүдийг сонгодог. Энэ хүрээнд оюутны тэтгэлэгт хөтөлбөр, сумын эрүүл мэндийн төвд эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх, малжуулах төсөл зэрэгт 90 гаруй сая төгрөг зарцуулжээ. | Олон нийтэд цаг үеийн мэдээлэл өгөх "Мэдээ" цэс байхгүй. Гэхдээ "Байгаль орчин", "Орон нутаг" цэсэнд гэрэл зураг, видео, инфографик бүхий мэдээлэл түгээх материалууд бий. Мөн мэдээллийн хуудас, кейс судалгаа, товхимол зэргийг татаж авах боломжтой. Тухайлбал, Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөл, оюутны тэтгэлэгт хөтөлбөр, малчдад зориулсан төсөл хөтөлбөрүүдийн товхимлуудыг монгол хэлээр татан авч болно. Гэхдээ эдгээр товхимол 2019 оны 7-р сард гарсан тул мэдээллийг шинэчлэх шаардлагатай. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Монголросцветмет ТӨҮГ | www.mongolros.mn | Тус компанийн эрхэм зорилгод “нийгмийн бөгөөд экологийн хариуцлагатай уул уурхайн байгууллага” байх талаар багтжээ. | "Бидний тухай" цэсэд ажиллагсдынхаа болон орон нутгийн иргэдийн мэдлэг, ур чадварыг эрс дээшлүүлснээ онцолж байна. Тухайлбал, “Бор-Өндөр”-ийн уулын баяжуулах үйлдвэр Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын хөдөлмөрийн насны иргэдийн 20%, “Шижир алт” алтны үйлдвэр нь Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг, Өгөөмөр тосгоны хөдөлмөрийн насны иргэдийн 34%-ийг ажлын байраар хангадаг. Түүнчлэн нийгмийн дэд бүтцийг бий болгох, орон сууц, сургууль цэцэрлэг, нийгэм соёл, спорт, ахуйн үйлчилгээний зориулалттай иж бүрэн барилга байгууламжид нийт хөрөнгө оруулалтынхаа 40%-ийг зориулж байна. Үүний үр дүнд үйлдвэрийн газрын харьяа үйлдвэрүүдийг түшиглэн байгуулагдсан хот, суурин газруудад 15 мянга гаруй хүн амьдардаг гэжээ. | Цахим хуудасны "Ил тод байдал" дэд цэсээр дамжуулан ТӨҮГ-ын тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын жагсаалт, байгаль орчны нөхөн сэргээлт, 2021 оны санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг өгсөн байна. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг "Мэдээ" цэсэд JPEG файл хэлбэрээр нийтэлжээ. Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд дөрвөн тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Төв аймгийн Заамар сумын Өгөөмөр тосгоныг ус, дулаанаар хангасныг дурджээ. | "Мэдээ" цэс тогтмол шинэчлэгдэж, компанийн үйл ажиллагаа, ажлын байрны зарын мэдээллийг өгдөг байна. Байгаль орчны менежментийн тухайд Байгаль орчныг нөхөн сэргээх сангийн үйл ажиллагаа, “Нөхөн сэргээлт-2024” хөтөлбөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он гэхэд 2 сая мод тарих амлалт өгсөн талаар мэдээлэл өгчээ. Мөн ТӨҮГ-аас мод тарих, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт явуулж, Өгөөмөр тосгоны орон нутгийн айл өрхүүдийг мод тарих ажилд татан оролцуулах замаар ард иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, оюутны тэтгэлэгт хөтөлбөр, мөн ОБЕГ-т 88 сая төгрөг хандивласан зэрэг мэдээлэл гаргажээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Таваантолгой ХК | www.tavantolgoi.mn | Мэдээлэл олдоогүй | Уг цахим хуудас "Танилцуулга" цэсээрээ "Нийгмийн хариуцлага" гэсэн мэдээлэл өгч байна. Үүнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж Өмнөговь аймагт 7.5 сая мод тарихаар төлөвлөж байгаа, мөн МУИС-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсны хүрээнд байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор мод үржүүлэх, нутгийн уугуул ургамлыг судлах сургалт судалгааны төв байгуулах талаар дурджээ. Орон нутгийн хөгжил, олон нийтийн оролцооны талаар мэдээлэл өгөөгүй байна. | Компани 2022 оны эхний хагас жилийн тайландаа 300 оюутанд 660 сая төгрөгийн тэтгэлэг, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд 80 сая төгрөг, 22,500 өрхөд 3 тонн нүүрс (2.6 тэрбум төгрөгийн үнэлгээтэй) олгосон, мөн эрүүл мэндийн салбарыг дэмжихэд 336 сая төгрөг зарцуулснаа тусгажээ. | "Мэдээ мэдээлэл" цэс нь "Орон нутгийн мэдээ" гэсэн дэд ангилалтай бөгөөд үүгээрээ компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж. Нийгмийн хариуцлагын хүрээнд Таваантолгой ХК-иас өндөр настангуудад нүүрс хандивлах, аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааг дэмжих, малчдад хандив өгөх зэрэг мэдээ мэдээллийг хүргэжээ. Түүнчлэн малчдад зориулсан үйл ажиллагаа, тендерийн урилга зэрэг орон нутгийн иргэдэд хамааралтай мэдээллийг энэ ангилалд нийтэлсэн байна.<br>Орон нутгийн иргэдтэй уулзалт хийсэн, сургалт семинар зохион байгуулсан тухай цөөн мэдээ оржээ. Гэсэн хэдий ч юу хэлэлцсэн, үүний үр дүнд юунд хүрсэн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй байна. Мөн "Видео мэдээ" гэсэн дэд ангилал байдаг бөгөөд үүнд ихэвчлэн компанийн ажилчдыг оролцуулжээ. |
| 5 | Улаанбаатар төмөр зам | https://ubtz.mn/ | Мэдээлэл олдоогүй | Улаанбаатар төмөр зам "Бидний тухай" цэс "Нийгмийн хариуцлага сайтай том ажил олгогч" хэмээн тодорхойлжээ. Компанийн менежментийн нэгдсэн тогтолцооны танилцуулгад заасанаар MNS ISO 26000 : 2012 Нийгмийн хариуцлагын удирдамж, MNS ISO 14001 : 2016 Байгаль орчны менежментийн тогтолцооны зааврыг хэрэгжүүлж байна. | Мэдээлэл олдоогүй | Тус цахим хуудас "Мэдээ" гэсэн цэстэй бөгөөд компани "Ган зам" сониныг эрхлэн гаргадаг. Уул уурхайн салбар дахь олон нийтийн оролцооны талаар холбогдох мэдээлэл олдсонгүй. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Шивээ Овоо ХК | https://shivee-ovoo.mn/ | Шивээ Овоо компанийн эрхэм зорилгод "Байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмжтэй уул уурхайн салбарын жишиг компани" байхаар тусгажээ. | Цахим хуудасны "Нийгмийн хариуцлага" цэс нь нийгмийн харилцаа ба хөгжил, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал гэсэн ангилалд хуваагддаг. 2019 оны зургаадугаар сараас нийгмийн харилцааны талаарх мэдээлэл шинэчлэгдээгүй. Байгаль орчныг хамгаалах талаар 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай мэдээ гарчээ. | Мэдээлэл олдоогүй | Нүүр хуудсанд байрлах "Мэдээ мэдээлэл" цэс компанийн үйл ажиллагааны талаарх мэдээ гаргадаг. 2022 оны 10, 11-р сард Шивээговь сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчид уурхайтай танилцсан, байгаль орчны нөхөн сэргээлт, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажлын талаар мэдээлэл авсан тухай мэдээ гарчээ. Гэхдээ сурагчдын сэтгэгдэл, нэмэлт мэдээлэл өгөөгүй байна. Мөн 2022 оны 10-р сард Говьсүмбэр аймгийн "Нэг өрх-Нэг ажлын байр" хөдөлмөрийн өдөрлөгт оролцож, ажлын байраар хангах талаар мэдээлэл өгснөө онцолжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Эрдэнэс Монгол | http://erdenesmongol.mn/index.php | Компанийн баримтлах зарчимд сайн засаглал, ил тод байдлыг багтаасан бөгөөд үүнийгээ "ажиллагаатай холбогдолтой мэдээллийг олон нийтэд хүргэх тогтолцоог бий болгоно" гэж тодорхойлжээ. “Эрдэнэсийг иргэн бүрт” уриатай тус компани тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна. | “Ил тод” цэс нь “Тогтвортой хөгжил” дэд хэсэгтэй бөгөөд энэ нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон бусад зохицуулалтад тулгуурлан MNS ISO 26000: 2012 Нийгмийн хариуцлагын удирдамж, ОҮИТБС, Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн зөвлөлийн 10 зарчим, ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартуудыг хэрэгжүүлэхээ мэдэгджээ. Түүнчлэн “Стратеги” дэд хэсэгтэй бөгөөд үүнд “Эрдэнэс Монгол” компанийн 2019-2023 оны стратегийн хүрээнд хариуцлагатай уул уурхайн стандартыг охин болон хараат компаниуддаа нэвтрүүлэх талаар тусгасан байна. | Мэдээлэл олдоогүй | "Мэдээлэл" цэс нь "Хэвлэлийн мэдээ", "Зураг, видео", "Сэтгүүлчийн булан" зэргээр хуваагдах бөгөөд үүнд ихэвчлэн ажлын байр, тендерийн мэдээлэл нийтлэгдсэн байна. Мөн тус компанийн гүйцэтгэх захиралтай хийсэн ярилцлага, Эрдэнэс Монгол компанийн охин компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл түлхүү гарчээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Эрдэнэс Силвер Ресурс | erdenessilver.mn | Компанийн үнэт зүйлд "тогтвортой хөгжил" багтдаг бөгөөд зарчмууд нь "сайн засаглал", "ил тод байдал"-ыг тусгажээ. | Нүүр хуудасны "Үйл ажиллагаа" цэс нь "Байгаль орчин", "Нийгмийн хариуцлага" гэсэн дэд хэсгүүдийг багтаасан. Гэсэн хэдий ч энэ судалгааны явцад мэдээлэл, файлууд шинэчлэгдэж байсан бөгөөд ашиглах боломжгүй байв. | Мэдээлэл олдоогүй | "Мэдээ" цэс сүүлийн саруудад байнга шинэчлэгдэж ирсэн бөгөөд голчлон МЕРИТ төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй уурхайн хаалтын ажлын талаарх мэдээллүүдийг багтаасан. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр орон нутгийн удирдлагууд, иргэдийн төлөөлөл зэрэг холбогдох талуудаас бүрдсэн ажлын хэсэг Салхитын уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, 2023 оны төлөвлөгөөнд тусгуулах талаар санал солилцсон, 1-р сарын 24-27-ны өдрүүдэд Салхитын уурхайн талбайд уурхайн хаалтын байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг танилцуулах, орон нутгийн иргэдийн саналыг тусгах зорилгоор оролцогч талуудын уулзалт, мэдээлэл солилцох "нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулсан зэрэг олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны талаар өгүүлжээ. "Иргэний оролцоотой жишиг сум" гэсэн гарчигтай мэдээнд МЕРИТ төслийн 2022 оны есдүгээр сард орон нутгийн иргэдтэй хийсэн анхны уулзалтын талаар өгүүлжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | Эрдэнэс Тавантолгой | http://www.ett.mn | Эрдэнэс Тавантолгой компанийн эрхэм зорилгод “Ажилчид болон оролцогч талуудад тогтвортой хөгжлийг хангах” гэж онцолсон. Мөн үнэт зүйлд “олон нийт, үйлчлүүлэгчид, түншүүд, олон нийтийн эрх ашгийг дээдлэх”, “хамтын ажиллагаа, нээлттэй харилцааг эрхэмлэн дээдлэх, шударга, ил тод, хариуцлагатай байх зарчмыг чанд баримтлах” багтжээ. | Тус компанийн “Бидний тухай” цэсэд “Нийгмийн хариуцлагын тухай” дэд хэсэгт сайжруулсан түлшний үнийн зөрүүг олгох, COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн салбарт хандив, тэтгэлэг олгох зэрэг мэдээлэл багтсан байна. Харамсалтай нь, 2020 оноос хойш мэдээлэл шинэчлэгдээгүй байна. | 2021 оны үйл ажиллагааны тайланд "Орон нутгийн хамтын ажиллагаа" гэсэн бүлэг орсон. Тус компанийн 2018 оны хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг 92.6 хувь буюу бүрэн хангалттай гэж үнэлж, 2021 оны тавдугаар сарын 7-ны өдөр гэрээг шинээр байгуулсан. Энэ хүрээнд 2021 онд гурван тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Эрдэнэс Тавантолгой Хөгжлийг дэмжих сан"-г байгуулсан. Тайланд үерийн гамшигт нэрвэгдсэн айл өрхүүдэд гэр хандивласан, Тавантолгойн ордыг түшиглэн Уул уурхайн дэд бүтэц-аж үйлдвэрийн цогцолбор байгуулах дунд хугацааны төлөвлөгөөний талаар нутгийн иргэдтэй уулзаж ярилцсан, ахмадууд, нутгийн малчдад гарын бэлэг, хандив өгсөн, Даланзадгад сумын Дулааны цахилгаан станцад нүүрс нийлүүлсэн, орон нутгийн сургуулиудад ном хандивлаж, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн Цагаан-Овоо багийн иргэдэд 1.4 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосон зэргийг дурджээ. Нийгмийн хариуцлагын талаар тус компани "Хүүхдийн төлөө ЭТТ" хөтөлбөр, "Утаагүй Улаанбаатар", "КОВИД-19-ийн эсрэг" гэсэн гурван үндсэн төслийг онцолж байна. | "Мэдээ" цэсийг компанийн үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээллээр тогтмол шинэчилж байна. Тухайлбал, 2022 оны 12-р сард нийтлэгдсэн “Эрдэнэс Тавантолгой компани Цогтцэций сумын шилдэг хөрөнгө оруулагч боллоо” гэсэн гарчигтай мэдээнд нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлуудыг тодорхойлсон байна. Тус компани 2022 онд Цогтцэций сумын эмнэлгийн яаралтай тусламжийн болон эмэгтэйчүүдийн төрөх тасгийг тохижуулж, цагаан сар, тэмээний баяр, хурдан морины уралдаан, ахмадын болон хүүхдийн баярыг ивээн тэтгэж, 30 оюутанд сургалтын тэтгэлэг олгож, малчдад хандив өгчээ. Мөн дэд бүтцийн чиглэлээр Цогтцэций сумын 13.5 км хатуу хучилттай авто зам, сумын төв доторх 1.11 км, 0.834 км авто зам, шинэ суурьшлын бүсэд 10/0.4 кВт-ын дэд станцуудыг барьжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ | https://www.erdenetmc.mn/ | “Эрдэнэт” үйлдвэрийн эрхэм зорилго нь “Тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайг нэн тэргүүнд тавьж үндэсний баялгийг бүтээх”. Тус компани нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт засаглалыг эрхэмлэдэг. | Цахим хуудас "Нийгмийн хариуцлага" булантай бөгөөд 1300 айлын орон сууцнаас бүрдсэн "Уурхайчин" орон сууцны хөтөлбөр, "Эрдэнэт" ТӨҮГ-ын нийт ажилтан, албан хаагчид, ахмадуудыг оношлох, эмчлэх, эрүүлжүүлэх "Эрдэнэт" сувилал цогцолборын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж байна. “Эрдэнэт” цогцолбор дээд боловсролын сургууль нь 1975 онд байгуулагдаж, 1996 онд ШУТИС-ийн харьяа Технологийн сургууль болон өргөжсөн. Цаашлаад энэ хэсэгт Эрдэнэт спорт цогцолбор, Соёл урлагийн цогцолбор, "Сэлэнгэ" амралт, "Найрамдлын эрдэнэс" хүүхдийн зуслангийн тухай түүхэн мэдээллийг багтаасан болно. Түүнчлэн "Үйл ажиллагаа" хэсэгт "Байгаль орчин" гэсэн дэд хэсэг багтсан бөгөөд Эрдэнэт үйлдвэр нь байгаль орчны менежментийн ISO 14001:2004 стандартыг хэрэгжүүлсэн Монгол Улсын анхны уурхай гэдгийг онцолсон байна. | Мэдээлэл олдоогүй | "Мэдээ" цэс компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр байнга шинэчлэгддэг. Тухайлбал, хэт хүйтэн өдрүүдэд тус компани цахилгаан эрчим хүчний хэрэгцээгээ 50 мВт хүртэл нэмэгдүүлж, эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангах үүднээс Төвийн эрчим хүчний системийг дэмжсэн. Нийгмийн хариуцлагын тухайд "Эрдэнэт үйлдвэр"-ийн 384 ажилтан шинэ орон сууцанд нүүж орсныг онцолж байна. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд тус компани 1490 ажилчдынхаа орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд зориулж 16.8 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. Бүх мэдээг тусдаа Erdenettoday.mn мэдээллийн сайтад нийтэлсэн байна. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | МоЭнКо | www.moenco.mn | МоЭнКо компанийн эрхэм зорилго бол хариуцлагатай уул уурхайн шилдэг туршлага, аюулгүй ажиллагааны стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх явдал юм. Тус компани нь уул уурхайтай холбоотой дэд бүтцийг бий болгохоос гадна орон нутгийн иргэдийг сургаж, ажлын байр бий болгож, орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих төсөлд хөрөнгө оруулалтыг чиглүүлдэг. Төсөлд 2200 гаруй хүн ажиллаж байгаагийн 70 хувь нь орон нутгийн иргэд юм. | “Нийгмийн хариуцлага” цэстэй. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Ажлын хэсэг жил бүр хянаж баталгаажуулдаг. 2014-2021 онд байгаль орчныг хамгаалахад 6.2 тэрбум төгрөг зарцуулсан. Нийгмийн хариуцлагын тухайд 2014, 2017, 2021 онуудад байгуулсан гэрээний талаар дурдсан боловч дэлгэрэнгүй мэдээлэл олдоогүй. МоЭнКо ХХК нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хөшөөт хөгжлийн сан”-г санхүүжүүлж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг жил бүр Ховд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулдаг. Үүний үр дүнд 2021 онд 2.2 тэрбум, 2022 оны эхний хагас жилд 4.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Орон нутгийн хэрэглэгчдийг чанартай, хямд нүүрсээр хангах нь компанийн нийгмийн хариуцлагын нэг юм. 2018-2019 онд Ховд аймгийн 215 айл өрх бүхий Хөшөөт багийн төвийг засаг захиргааны нэгж болгон иж бүрэн нүүлгэн шилжүүлэх төсөл 10 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтээр амжилттай хэрэгжсэн. | Мэдээлэл олдоогүй | Цаг үеийн мэдээ хүргэх тусгай цэс байхгүй. Гэсэн хэдий ч тус компани орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд ажилд орох, худалдан авах боломжуудын талаарх мэдээлэл, хүсэлт гаргах өргөдлийг байршуулжээ. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд зааснаар Хөшөөт төслийн нийт ажилчдын 70-аас доошгүй хувийг орон нутгаас авах ёстой. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар МоЭнКо ХХК-д 497, гэрээлэгч компанид 1965 ажилтан, албан хаагч байна. МоЭнКо компанийн нийт ажилчдын 89 хувь нь, гэрээлэгч компанийн нийт ажилчдын 77 хувь нь Ховд аймгийн иргэд байгааг онцолжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Онтрэ | https://www.entreeresourcesltd.com/ | Тус компани "нийгмийн хариуцлагыг анхаарах замаар компанийн ирээдүйг баталгаажуулахад тусалдаг" гэж онцолжээ. | Мэдээлэл олдоогүй, цахим хуудас нь монгол хэл дээр ажилладаггүй. | Техникийн тайланг зөвхөн англи хэл дээр нийтэлсэн байв. | Мэдээлэл олдоогүй, цахим хуудас нь монгол хэл дээр ажилладаггүй. |
| 13 | Саусгоби Ресурс Лимитед | https://www.southgobi.com/html/index.php | Саусгоби Ресурс нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг. | "Нийгмийн хариуцлага" цэсэд "Компанийн нийгмийн хариуцлага", "Байгаль орчны менежмент", "Эрүүл мэнд, аюулгүй байдал" гэсэн дэд ангилал багтсан болно. Нийгмийн хариуцлагын тухайд тус компани хариуцлагатай эдийн засгийн өсөлт, байгаль орчин, хүний капитал, олон нийт гэсэн дөрвөн сэдвээр ажилладаг. Түүнчлэн, Саусгоби компани нь бизнесийн үйл ажиллагаанаасаа болж нөлөөлөлд өртсөн иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын тулд иргэдийн санаа зовнил, хүсэл эрмэлзлийг ойлгож, хариу арга хэмжээ авах үүрэг хүлээдэг. | Жилийн мэдээллийн тайлан нь нийгэм, байгаль орчны бодлогын тухай хэсэгтэй. Нарийн сухайтын уул уурхайн компаниудтай хамтран байгаль орчны мониторингийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Орон нутгийн бүтээн байгуулалтын тухайд тус компани Овоот толгойн нисэх онгоцны буудлын хөөрөх зурвасын хучилтын ажилд хувь нэмрээ оруулсан. Гурвантэс, Шивээ хүрэнгийн боомт хүртэлх замыг сайжруулж, шинэчилсэн.<br>Нийгмийн хариуцлагын тухайд 2021 онд хандивын зардалд 532,436,732 төгрөг зарцуулсан байна. Үүнд 15 оюутанд тэтгэлэг олгох, нутгийн иргэдэд нүүрс, малын тэжээл хандивлах, Амьтан хамгаалах санд олгох хөрөнгө багтжээ. Түүнчлэн тогтвортой төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор байгууллагын иргэдийн хороог байгуулсан. | Монгол хэлээр ховорхон шинэчлэгддэг “Мэдээ мэдээлэл” булан бий. Удирдлагын нэгдсэн тогтолцооны сургалтын талаарх мэдээ 2022 оны 4-р сард гарсан. “Шагнал” дэд хэсэгт 2019 оны ТОП 100 аж ахуйн нэгжийн нэг, 2018 оны “Шилдэг ажил олгогч”, Сүхбаатар аймгийн “Шилдэг нийгмийн даатгал төлөгч”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2018 оны “Эрүүл, аюулгүй ажлын байрны тэргүүн” болсныг онцолжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | Степ Голд | https://steppegold.com/ | "Бидний үүрэг" хэсэгтээ "хамтрагчид, харилцагчид болон Монгол Улсын засгийн газрын бүх түвшинд тогтвортой харилцааг бий болгох" тухай онцолжээ. | "Тогтвортой хөгжил", "Нийгмийн хариуцлага", "Байгаль орчин", "Эрүүл мэнд, аюулгүй байдал" гэсэн хэсэгт хуваагдсан "Тогтвортой хөгжил" гэсэн цэстэй. Тус компани нь бүх талуудад ашигтай ажиллах орчныг баталгаажуулсан орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. Нийгмийн хариуцлагын тухайд 300 гаруй албан хаагчийг шууд болон шууд бусаар ажилд авах, 36 хүнийг сургах, ажлын байраар хангах, тэтгэлэг олгох зэрэг мэдээллийг инфографик, видео бичлэгээр хүргэж байна. Мөн тус компанийн цагаан идээ, махны хэрэгцээг орон нутгаас 100 хувь хангадаг тухай онцолжээ. | Степ Голд компани 2021 оны Техникийн тайландаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. | "Мэдээ" буланд тус компани үйл ажиллагааны шинэчилсэн мэдээг англи, монгол хэлээр нийтэлдэг. Гэсэн хэдий ч ихэнх контент нь хувьцаа эзэмшигчдэд чиглэсэн, орон нутгийн иргэдэд хамааралгүй байна. "Хэвлэл мэдээлэл" дэд хэсэгт бүх видеонууд англи хэл дээр байсан. |
| 15 | Наран Мандал | https://naranmandal.com | "Хамт олон, хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг даасан, орон нутагтаа өгөөжтэй, байгаль орчинд ээлтэй олон улсын шилдэг стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласнаар Монголын хариуцлагатай уул уурхайн тэргүүлэгч компани болох" алсын хараатай. | "Үйл ажиллагаа" хэсэгт "Үнэт зүйлс", "Орон нутаг", "Ажилчдын сэтгэгдэл" болон түгээмэл асуултуудын дэд хэсгүүд багтсан. Наран Мандал орон нутагт 700 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Иргэдийн санаачилгын талаар тус компани орон нутгийн эрүүл мэндийн хөтөлбөр, хүүхдийн баярыг тэмдэглэж, хүүхдүүдэд бэлэг өгөх, хичээлийн хэрэгслээр хангах, 54 оюутанд тэтгэлэг олгох, ахмадын өдрийн хүлээн авалт, концерт, нутгийн малчин өрхүүдэд 10 өвөлжөө барих, малчдад худаг гаргах, малчдад зориулсан арга хэмжээ зохион байгуулах зэрэг ажил санхүүжүүлснээ онцолж байна. | Мэдээлэл олдоогүй | "Медиа" хэсэгт хэвлэлийн мэдээ нийтэлдэг. Энэхүү судалгааны явцад гүйцэтгэх захирлын баяр наадмын мэндчилгээ, 10 малчин өрхөд өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулж хандив өргөсөн тухай хоёр мэдээ бүртгэгдлээ. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | Баян Аайраг Эксплорэйшн | bayanairag.com | “Аюулгүй ажиллагаа, байгаль хамгаалал, нийгмийн хариуцлагын стандартыг тууштай баримтлан Монгол улсын уул уурхайн салбарт манлайлах” алсын хараатай. | "Тогтвортой хөгжил" цэстэй. Байгаль орчны тухайд БОАЖЯ-наас 2013, 2018 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг баталж, БОМТ, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг жил бүр шинэчлэн боловсруулж, яаманд батлуулахаар хүргүүлдэг.<br>"Орон нутаг ба нийгмийн хариуцлага" дэд хэсэгт тус компани өөрийн бодлого, тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ. Баян айраг нь 13 хүний бүрэлдэхүүнтэй Олон нийттэй харилцах хэлтэстэй бөгөөд баг, сумын хэмжээнд олон удаагийн уулзалт, сургалт зохион байгуулж, нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг аж.<br>Орон нутгийн хөгжлийн төслүүдийн тухайд Баян айраг нь Завхан аймгийн дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьж байна. Тус компани байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, ЖДҮ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, соёлын өвийг хамгаалах, спорт, нийгмийн эрүүл мэнд, хүмүүнлэгийн үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлсэн. Баян айраг эксплорэйшн 2013-2018 оны хооронд Дөрвөлжин, Эрдэнэхайрхан сумын нутгийн захиргааны байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллаж, 1.79 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. | Баян Аайраг Эксплорэйшн компанийн “Тогтвортой хөгжил” тайлан нь 64 нүүр бүхий сэтгүүл хэлбэрээр гарсан бөгөөд орон нутгийн иргэдэд шууд чиглэжээ. Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хөгжил, аюулгүй байдал, байгаль орчны менежмент, хүний нөөц, бизнесийн манлайллын талаарх мэдээллийг 35 гаруй хүнтэй хийсэн ярилцлагад үндэслэн хүргэж байна. Тус тайланд Баян Айраг Эксплорэйшн ажилд авсан нутгийн иргэдийг онцолж байна. Тайлангаас үзэхэд цианид алдагдсан тухай ташаа мэдээлэл байнга тархдаг. Бага оврын осол гарсныг мэргэжлийн хяналтынхантай хамтран шийдвэрлэсэн тухай тус компанид ажилладаг нутгийн иргэд онцолж байна. Мөн тайланд цианид алдагдсан талаарх ташаа мэдээлэлтэй тэмцэх зорилгоор технологи, аюулгүй байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ.<br>Цаашлаад орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, түүний хэрэгжилт, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн шийдвэр гаргагчид, компанийн олон нийттэй харилцах албаны дарга нар хүргэсэн байна. Түүнчлэн тус компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар орон нутгийн эрүүл мэндийн төв, сургууль, нутгийн иргэд, малчдын төлөөлөл байр сууриа илэрхийлжээ. Мөн орон нутгийн бизнес эрхлэгчид тус компанид бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэх туршлагаа хуваалцжээ. Эцэст нь, тус компанийн санхүүжилттэй, иргэдийн саналын дагуу орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийдэг Баян Дөрвөлжингийн Өгөөж зэрэг орон нутгийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл хийж хэрэгжүүлсэн ажил, орон нутаг дахь үр өгөөжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байна. | “Медиа” буланд 2019-2020 онд ТОП 100 аж ахуйн нэгжийн нэг болж, "Хариуцлагатай татвар төлөгч" байснаа онцолжээ. 2019 онд нийтлэгдсэн бусад мэдээ нь тус компанийг Олон улсын санхүүгийн корпорациас "Усны менежментийн шилдэг олон нийтэд хүрч ажиллагч " шагнал авсныг онцолжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | Цайртминерал | www.tsairt.mn | Мэдээлэл олдоогүй | Мэдээлэл олдоогүй | Мэдээлэл олдоогүй | "Мэдээ" булангаараа аюулгүй байдал, байгаль орчны талаар баримтлах бодлогын талаарх мэдээллийг хуваалцжээ. Тус компани 2018-2022 онд нийт таван мэдээ нийтэлсний дотор аймгийн Онцгой байдлын хэлтэст КОВИД-19-ийн эсрэг тусламж болгон хандив өгсөн, уран зураг, эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, шилдэг 100 аж ахуйн нэгжийн нэг болсон нь багтжээ. |
| 18 | Бороо Гоулд | http://www.boroogold.mn/mn | Бороо Гоулд нь аюулгүй, хариуцлагатай уул уурхайг эрхэмлэдэг. | "Байгаль орчин", "Эрүүл мэнд, аюулгүй байдал", "Олон нийт" гэсэн ангилал бүхий "Тогтвортой хөгжил" цэстэй. Байгаль орчны менежментийн систем (БОМС) нь олон улсын ISO 14001 стандартын шаардлагад нийцдэг. Орон нутгийн хөгжлийн тухайд тус компани байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсад 1.2 их наяд төгрөг, үүний дотор орон нутагт 11.4 тэрбум төгрөгийн өгөөж оруулснаа онцолжээ. Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Мандал сумтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу тус компани сумдын дэд бүтцийн хөгжил, нийгмийн халамжийн үйлчилгээ, ЖДҮ-ийг дэмжих зорилгоор жил бүр санхүүжилт олгодог. Тухайлбал, тус компани Мандал суманд хатуу хучилттай зам тавихад хөрөнгө оруулалт хийсэн. | Мэдээлэл олдоогүй | "Мэдээ" булан 2020 оноос хойш шинэчлэгдээгүй бөгөөд хэвлэлийн мэдээ нь зөвхөн англи хэл дээр гарсан. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | Монцемент Билдинг Материалс | http://moncement.mn | "Бүтээгдхүүний чанар, найдвартай үйлчилгээ, нийгмийн хариуцлагаа үлгэр жишээчээр хангадаг Монголын барилгын материалын шилдэг компани болж, илүү сайн ирээдүйг бүтээх" нь компанийн алсын хараа юм. Үүнээс гадна тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалахыг эрхэмлэдэг. | "Тогтвортой хөгжил" гэсэн булантай. Компанийн "Эхлээд аюулгүй байдал" зарчим нь ажилчдын сайн сайхан байдлыг эрхэмлэдэг. Цаашилбал, компани нь "Нэг ертөнц" зарчмынхаа үндсэн дээр байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөцийн ашиглалтыг оновчтой болгох, байгаль орчин, орон нутгийн экосистемийг дээд зэргээр хамгаалах, 3R системийг хэрэгжүүлэх, ногоон худалдан авалт хийх замаар буцаан өгөөжөө өгөхийг эрмэлздэг. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, тусгай хэрэгцээт аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлоготой. | Мэдээлэл олдоогүй | "Медиа" хэсэг нь мэдээ, видео, гэрэл зургаар байнга шинэчлэгдэж байдаг. Тус компани зургаан жилийн хугацаанд дотоодын 150 гаруй ханган нийлүүлэгч байгууллагатай хамтран ажиллаж, төр, хувийн хэвшлийн 200 гаруй томоохон бүтээн байгуулалтад оролцож, 1000 гаруй ажлын байр бий болгосноо онцолсон зурагт хуудасны хамт шилдэг бизнес эрхлэгчээр шалгарснаа онцолж байна. Дорноговь аймгийн Өргөн суманд тус компани цөлжилтийн эсрэг 300 мод тарьжээ. Мөн тус компани худалдаж авсан цементийн нэг уутнаас 60 төгрөгийг хүүхдийн цэцэрлэг барих ажилд зарцуулах аян зарласан. Тус компанид ажилладаг орон нутгийн иргэнтэй хийсэн ярилцлагыг нийтэлж, ажилчдаа орон сууцаар хангаж байгаа талаар туршлагаасаа хуваалцжээ. Компанийн ажилчдыг харуулсан видео бичлэгүүд нь тус компани орон нутгийн иргэдийг ажилд авч, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг болохыг харуулж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20 | Оюутолгой | www.ot.mn | “Хувь нийлүүлэгчид болон оролцогч талууддаа үнэ цэнэ бий болгож, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацаанд хувь нэмэр оруулах” алсын хараатай. | "Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин", "БОННҮ менежмент", "Орон нутаг", "Хандив" ангилал бүхий "Тогтвортой хөгжил" гэсэн цэстэй.<br>2012 онд БОННҮ-г цогцоор нь хийсэн. БОННҮ, Менежментийн төлөвлөгөө, аудитыг татаж авах боломжтой. Нийгмийн хариуцлагын тухайд тус компани орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр орон нутгийн санаачилга, олон нийтийн оролцоотой төсөл, хөтөлбөр, түншлэлд тусалдаг. Компанийн нийгмийн хариуцлагын бодлого нь ISO26000: Нийгмийн хариуцлагын удирдамжид суурилдаг.<br>“Монгол инженер-2018” арга хэмжээг зохион байгуулах, “Нарны хүүхдүүд” цэцэрлэгт хандив өргөх, зорилтот 10 сургуульд хүчирхийллийн эсрэг төсөл хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 25 дугаар тусгай сургуульд тохижилт хийх, ЕБС-ийн хүүхдүүдэд зориулсан TEDx Youth ESM арга хэмжээг ивээн тэтгэх зэрэг боловсролын төслүүдийг Оюу Толгой компани дэмжсэн. Мөн эх нялхсын эрдэм шинжилгээний төв, 116-р тусгай сургууль, улсын эмнэлгүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж, сайн чанарын IQ агаар цэвэршүүлэгч хандивлажээ. 186 дугаар цэцэрлэгт аутизмтай хүүхдүүдэд зориулсан анги танхим тохижуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн Хөдөлмөр зусланд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж хандивлаж, "Яарад яахав дээ", "Дураараа биш дүрмээрээ" замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах аяныг ивээн тэтгэх зэрэг ажлууд багтаж байна. | 2021 оны жилийн тайлан нь "Түншлэгч талуудын хамтын ажиллагаа" бүлгээрээ дамжуулан орон нутгийн иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаагаа хүргэжээ. Тус компани Өмнөговь аймгийн төрийн албан хаагчид, малчид болон нийгмийн бусад гишүүд зэрэг 1172 оролцогч талтай 800 гаруй уулзалт, зөвлөгөөн хийснээ онцолсон байв. Мөн Оюу Толгой компани жил бүр Ханбогд, Даланзадгад, Манлай, Баян-Овоо сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг.<br>Тус компани орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2021 онд Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Санд 5.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.<br>Оюу Толгой компани хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг үргэлжлүүлэн дэмжиж, "Малчин" гар утасны аппликейшн нэвтрүүлж, бизнесийг чадавхжуулах 5 удаагийн сургалт 29 оролцогчдод, мөн 99 зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, малчин өрхүүдийг ингэний сүүгээр дотоодын бренд бий болгон зах зээлд нийлүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлсэн зэргээс гадна бусад хандив, тусламжийн мэдээллийг хүргэжээ.<br>2021 оны арванхоёрдугаар сарын байдлаар Оюу Толгойн үндэсний худалдан авалтын 25 хувийг орон нутгийн ханган нийлүүлэлт эзэлж байгаа бөгөөд нийт ажиллах хүчний 24.7 хувийг орон нутгийн иргэд бүрдүүлж байна. Түүнчлэн 2021 онд Оюу Толгойд дотоодын 94 ханган нийлүүлэгч 216 сая ам.долларын бараа, үйлчилгээ нийлүүлжээ. Цагдаагийн ерөнхий газартай урт хугацааны түншлэл эхлүүлсний дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр улсын хэмжээнд аян өрнүүлж, Сайншанд-Замын-Үүд чиглэлийн замд хурд хянах камер суурилуулсан.<br>Тус тайланд мөн COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ | "Хэвлэлийн мэдээ", "Онцлох мэдээ", "Нийтлэл, бүтээл", "Зураг, видео" зэргийг агуулсан "Хэвлэл мэдээлэл" гэсэн цэстэй бөгөөд эдгээр нь байнга шинэчлэгддэг. Онцлох мэдээ нь “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдсэн зэрэг мэдээлэл гаргадаг бол “Хэвлэлийн мэдээ” булан улирал тутмын тайлан зэрэг үйл ажиллагааны талаар цаг тухайд нь мэдээлдэг. Компанийн ажилчдын тухай ярилцлага, өгүүллэг "Оюутолгойчууд" буланд гардаг бол “Зураг, видео” нь компанийн түүх, хэрхэн ажилладаг талаар хүмүүст ерөнхий мэдээлэл өгөх зорилготой контент агуулж байна.<br>Мөн тус компаниас улирал тутам “Уурхайчин” сэтгүүл гаргаж, тус сэтгүүлд компанийн үйл ажиллагаа, орон нутгийн бүтээн байгуулалтыг онцолдог. Жишээлбэл, 2022 оны 4-р улирлын сэтгүүл 24 хуудастай байсан. Энэ нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих аяныг дэмжсэн Оюутолгойн гүний уурхайн төслийн захирал Жак Ван Тондертэй хийсэн ярилцлага, Рио Тинтогийн Кеннекотт руу шилжсэн компанийн ажилтны ярилцлага, "Уул уурхайн долоо хоног-2022" арга хэмжээ, олон нийтийн нээлттэй хаалганы өдөрлөг, асуулт хариултыг нийтэлжээ. Мөн ажилчдын дунд зохион байгуулсан үйл ажиллагаа, тэтгэлэгт хамрагдах, ажил мэргэжлийн боломж олгох талаар зөвлөгөө болон бусад мэдээлэл багтжээ.<br>Энэхүү цахим хуудас аюулгүй байдал, байгаль орчны гүйцэтгэл, худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хувь нэмрийн ахиц дэвшлийг харуулсан улирал тутмын инфографик, виртуал аялал, тэтгэлэгт хамрагдах зарын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авахад зориулсан хандив тусламж, өсвөр насныхны сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд чиглэсэн боловсролын төсөл, хөтөлбөрүүдийг дурджээ. | зурагт хуудас болон бусад мэдээлэл түгээх материалуудтай. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 21 | Адуунчулуун | http://aduunchuluun.mn/ | Мэдээлэл олдоогүй | "Нийгмийн хариуцлага" булантай. Нийгмийн хариуцлагын тухайд тус компани ажилчдынхаа нийгэм, эдийн засгийн дэмжлэгийг онцолж байна. Тодруулбал, "Уурхайчин" орон сууцны хороолол 2008-2013 онд баригдсан бөгөөд нийт ажилчдын 68 хувь нь орон сууцанд амьдардаг. Ахмад ажил олгогчдыг урамшуулахын тулд компани нөхөн олговор олгосон. Тус компани ахмадууддаа жилдээ 8 тонн нүүрс, замын зардал, нөхөн олговор олгодог. Цаашлаад орон нутгийн ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийг нүүрс, түлшээр дэмжих, хүүхэд багачуудыг дэмжих, урлаг соёлын арга хэмжээ, наадам ивээн тэтгэж, нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажилладаг. Тус компани "Хариуцлагатай татвар төлөгч"-өөр шалгарсан тухай мэдээлэлдээ төлсөн татварынхаа хэмжээг хүргэж байна. Байгаль орчны нөхөн сэргээлтийн тухайд Адуунчулуун 1955 онд уурхайн үйл ажиллагаа явуулж, 2002 онд Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг шинээр эхлүүлсэн. | Тус компанийн 2022 оны хагас жилийн тайланд үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг багтаасан болно. Гэсэн хэдий ч нийгмийн хариуцлага, олон нийтийн хөгжил/оролцооны талаар мэдээлэл илрээгүй. | Тус сайт нь "Мэдээ" гэсэн хэсэгтэй. Нийтэлсэн мэдээллийн дийлэнх нь нээлттэй  орон тоо, хувьцаа эзэмшигчдэд зориулсан зар, тухайлбал хурал, ногдол ашиг олгох тухай мэдээлэл байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд Засаг даргын захирамжийн дагуу Хэрлэн голын орчмын цэвэрлэгээг хийж, Хэрлэн сумын Онцгой байдлын албанд Covid-19-ийн эсрэг тэмцэх ажилд таван сая төгрөг хандивласан талаар мэдээлжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 22 | Бүрдэл Майнинг | https://burdelmining.mn/ | Мэдээлэл олдоогүй | Цахим хуудсанд "Нийгмийн хариуцлага" гэсэн цэс бий. Иргэдийн хувьд 2021 оны есдүгээр сард Заамар суманд 240 хүүхдийн хүчин чадалтай “Өгөөмөр” цэцэрлэгийг ашиглалтад оруулсан. Боловсролын тухайд Бүрдэл майнинг ХХК нь 2017 оноос хойш Заамар сумын 40 оюутны сургалтын төлбөрийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд мөн Булганы Бүрэгхангай дахь сургуулийн дотуур байрны өргөтгөлд зориулж 100 сая төгрөг хандивлажээ. Байгаль орчны нөхөн сэргээлтийн тухайд жил бүр БОМТ-ийг шинэчилж, төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийдэг. Мөн орон нутгийн иргэдийг биологийн нөхөн сэргээлтэд оролцоход нь дэмжлэг үзүүлж хашаа барих, мод тарих зэрэг ажилд хамруулдаг. | Мэдээлэл олдоогүй | Мэдээлэл олдоогүй |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 23 | МАК (Монголын Алт) | www.mak.mn | Мэдээлэл олдоогүй | “Нийгмийн хариуцлага” булантай бөгөөд тус компани нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүдэд 28.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн тухай онцолсон байна. Сэлэнгэ аймгийн Ерөө сумынд 2022 онд 11.5 тэрбум төгрөгөөр олон улсын жишигт нийцсэн 960 хүүхдийн эко сургууль барьсан. Мөн МАК-аас Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгийн 11 оюутанд тэтгэлэг олгосон. Даланжаргалан сумынд тус компани 8 айлын орон сууц барихад зориулж барилгын материал хандивлажээ. Хариуцлагатай уул уурхайн чиглэлээр ашиглалтад орсон бүх талбайд техник, биологийн нөхөн сэргээлт хийж, орон нутгийн удирдлагад хүлээлгэн өгсөн. Мөн тус компани "Тэрбум мод" үндэсний санаачлагын хүрээнд уурхайн ойролцоо 150 мянга гаруй мод тарьж, ургуулсан байна. МАК-ийн уурхайн нөхөн сэргээлтийн хамгийн сайн жишээ бол Даланжаргалан дахь Элдэвийн нүүрсний уурхай юм. Дэд бүтцэд хөрөнгө оруулах нь МАК-ын нийгмийн хариуцлагын үндсэн зорилт юм. Тус компани Монголын сүүлийн зургаан сумын тавыг эрчим хүчний эх үүсвэрт холбосон. Түүнчлэн Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлд 55 км хатуу хучилттай авто зам, Оюутолгой-Цагаансуварга чиглэлд 220 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станцыг барьжээ. | Мэдээлэл олдоогүй | Мэдээ, видео, зурагт хуудас зэргээр байнга шинэчлэгддэг "Мэдээ" булантай. Тус компани нь "Нийгмийн хариуцлага" дэд хэсэгт шагналтнуудын тухай мэдээ, видеогоор тэтгэлэг олгох, "Тэрбум мод" үндэсний санаачилгад нэгдэж, 11,000 мод тарих, ан амьтдыг хамгаалах, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд, 960 хүүхдийн эко сургууль барих зэрэг ажлуудыг онцолж байна. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 24 | Монгол Майнинг энд Эксплорэйшн | http://mme.mn/index.html | Тус компани нүүр хуудсандаа “Хариуцлагатай уул уурхай” уриатай. | Мэдээлэл олдоогүй | Мэдээлэл олдоогүй | Цахим хуудсанд "хариуцлагатай уул уурхай", "мэдээ" гэсэн тусгайлсан хэсэг байхгүй. Харин нүүр хуудсанд уул уурхайн ашиглалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн тухай хоёр видео оруулсан бөгөөд үүнд компанийн ажилчид нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг танилцуулжээ. 2017 оноос хойш тус компанийн байгаль орчны менежмент, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг орон нутгийн болон төвийн удирдлагууд 91-98 хувьтай үнэлжээ. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | Монполимет | monpolymet.mn | “Байгальд ээлтэй эко шийдэл бүхий шинэ ноу-хау, инноваци, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, ногоон хөгжлийг дэмжих” нь компанийн эрхэм зорилго юм. "Нийгмийн хариуцлага" бол компанийн уриа юм. | "Нийгмийн хариуцлага" гэсэн булантай бөгөөд "Эдийн засаг", "Мөнх Тогтвортой Хөгжил Сан", "Байгаль орчин" гэсэн хэсэгт хуваагддаг. “Эдийн засаг” дэд хэсэгт орон нутгийн иргэдийг сургах, ажлын байр бий болгох, ажилчдынхаа нийгэм, эдийн засгийн сайн сайхны төлөө санаа тавих, тухайлбал орон сууцжуулах зэрэг мэдээллийг багтаасан болно. Нийгмийн халамжийн тухайд Булган аймгийн Бүрэгхангай суманд Засгийн газрын нэгжийн барилга, Дашинчилэн сумын бага сургууль, сургуулийн дотуур байрны засвар, Заамар суманд худаг гаргах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг жагсаажээ. Сум орон нутагтай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр сум хөгжүүлэх сан болон орон нутгийн иргэд, байгууллагад жил бүр тодорхой хэмжээний хандив тусламж үзүүлсээр ирсэн. Тус компанийн байгаль орчны бодлого, менежмент, байгаль орчны хяналт, экологийн нөхөн сэргээлт, байгаль орчны боловсрол, хяналт зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. "Мөнх тогтвортой хөгжил сан" дэд хэсэг нь тусдаа цахим хуудастай, энэ судалгааны явцад нэвтрэх боломжгүй байв. | Мэдээлэл олд”оогүй | "Мэдээлэл" булан нь компанийн үйл ажиллагааны талаар цаг тухайд нь мэдээлдэг. Тухайлбал, 21 дэх удаагаа “Тэргүүний нөхөн сэргээгч”-ээр шалгарснаа онцолжээ. Түүнчлэн тус компанийн нөхөн сэргээлтийн бүсэд ажиллаж буй албаны хүмүүсийн мэдээг нийтэлсэн. Мөн энэ буланд байгаль орчныг таниулах, соён гэгээрүүлэх зорилготой гэрэл зураг, зурагт хуудас байнга нийтлэгдэж байв. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 26 | Өсөх Зоос | http://usukhzoos.mn/ | Мэдээлэл олдоогүй | “Нийгмийн хариуцлага” гэсэн цэстэй бөгөөд “Нутгийн иргэд, байгууллагуудтай хамтран ирээдүйгээ аюулгүй цогцлоох нь” компанийн нийгмийн хариуцлагын бодлого гэдгийг онцолсон байна. Тус компанийн хөрөнгө оруулалтаар Гурвантэс сумын эмнэлгийг тохижуулж, сумын төвийн уулзварт гэрлэн дохио тавьж, спорт цогцолборыг тохижуулжээ. Мөн орон нутгийн иргэдийг сургаж, ажлын байраар хангах, оюутнуудад тэтгэлэг олгох, 11000 гаруй мод тарьж, орон нутгийн айл өрхүүдэд зориулж жилдээ 1-2 удаа хүнсний тусламж үзүүлдэг. | Мэдээлэл олдоогүй | Мэдээлэл олдоогүй |
| 27 | Улз Гол | http://ulzgroup.mn/ | Хувьцаа эзэмшигчид, ажилчид, бизнес болон нийгмийн түншүүдэд үнэ цэнийг нэмэгдүүлэх эрсдэлгүй, байгаль орчинд ээлтэй ажлын байрыг бий болгох нь компанийн эрхэм зорилго юм. | "Нийгмийн хариуцлага" хэсэгт биологийн болон техникийн нөхөн сэргээлт, эрүүл ахуй, аюулгүй байдлын бодлого, олон нийтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгчээ. Энд компанийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны үр дүнг өмнөх/дараах зургаар дүрсэлсэн. Иргэдийг дэмжих хөтөлбөрүүдийн тухайд Улз Групп нь үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, жижиг дунд бизнесийг дэмжих, оюутнуудын боловсрол, сургалтад дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажилладаг. Жагсаалтад орсон бүх үйл ажиллагаа нь 2014-2017 он хүртэл байсан бөгөөд үүнээс хойш мэдээлэл шинэчлэгдээгүй байна. | Мэдээлэл олдоогүй | "Мэдээ" булан 2018 оноос хойш шинэчлэгдээгүй. |

| № | Компанийн нэр | Цахим хуудас | Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс | Нүүр хуудасны цэс | Компанийн жилийн тайлан/КНХ-ын тайлан | Мэдээлэл түгээх материалууд |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | Хан Алтай | https://khanaltai.mn/ | “Тогтвортой, нийгмийн хариуцлагатай дэлхийд өрсөлдөх алтны уурхайг бүтээн байгуулж, Монгол улсын баруун бүсийн хөгжлийг хамтран бүтээх” нь компанийн эрхэм зорилго юм. | Цахим хуудасны "Тогтвортой хөгжил" хэсэгт Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Байгаль орчныг онцолсон байдаг. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2021 онд хийж, 2022 онд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг үнэлгээний хүрээнд орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөлөлтэй хамтран сөрөг нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Үүнээс гадна компани нь дараахь дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.<br>-Соёлын өвийг хамгаалах<br>-Нутгийн иргэдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих<br>-Орон нутгийн дэд бүтцийн хөгжил<br>-Орон нутгийн бизнес, эдийн засгийг дэмжих<br>-Хамтын оролцоотой байгаль орчны хяналт | Мэдээлэл олдоогүй | Энэхүү цахим хуудас нь нүүр хуудсандаа "Мэдээ" гэсэн хэсэгтэй бөгөөд дэд хөтөлбөрүүдийн талаарх үндсэн мэдээллийг өгдөг. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | Энержи Ресурс | www.energyresources.mn | Компани нь ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн хариуцлагыг эрхэмлэдэг. | "Тогтвортой хөгжил" хэсэгт компанийн нийгмийн хариуцлагын бодлого, нийгэм эдийн засагт оруулсан хувь нэмэр, орон нутгийн хөгжлийн төсөл, хүний нөөц, байгаль орчин, аюулгүй байдлын талаарх мэдээллийг багтаасан.<br>Тус компани ISO 26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн болон КНХ-ын бодлогоо боловсруулсан. Нэг удаагийн хандив, тусламж, богино хугацааны төсөл хөтөлбөр бус харин хариуцлагатай уул уурхайн зарчмыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах, тогтвортой хөгжлийн бат бөх суурь бий болгох бодлоготой.<br>Нийгэм, эдийн засагт оруулсан хувь нэмрийн тухайд тус компани татвар төлөлтөөрөө улсдаа ТОП 5-д тогтмол жагссаар ирсэн гэдгээ онцолж байна.<br>Ухаа худаг төслийн хүрээнд 4000 орчим хүн шууд ажилтай, орлоготой байгаагийн 40 орчим хувь нь Өмнөговь аймгийн иргэд байна. Мөн дотоодын 2000 гаруй аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчээр хамтран ажилласан.<br>Жил бүр эрүүл мэнд, боловсрол, ЖДҮ-ийг дэмжих, соёлын өвийг хамгаалах чиглэлээр орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт нэг тэрбум гаруй төгрөг зарцуулдаг. | Энержи Ресурс компанийн 2021 оны нийгмийн хариуцлагын тайлан 21 хуудас баримт бичигт компанийн нийгмийн хариуцлагын бодлого, нийгэм эдийн засагт оруулсан хувь нэмэр, орон нутгийн хөгжлийн төсөл, байгаль орчин, аюулгүй байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан. Компанийн төсөл, арга хэмжээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж сонирхогч талууд болон олон нийтэд дараах төлөвлөгөөний дагуу танилцуулж байна.<br>• Төслийн сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө<br>• Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөө<br>• Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө<br>• Гомдол барагдуулах журам<br>• Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө<br>• Нийгмийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөө<br>• Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө гэх мэт.<br>Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн дэд бүтцийг тогтворжуулах, дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлээр төсөл/хөтөлбөр хэрэгжиж байна. Орон нутгийн хөгжлийн тухайд уг тайланд 10,000 хүнд шууд чиглэсэн орон нутаг, төсөл, хөтөлбөрүүдийг нүүрс, УС-аар хангах асуудлыг онцолж байна. Тус компани ЖДҮ-ийг дэмжих төсөл боловсруулах чиглэлээр орон нутгийн иргэдийг сургаж, хөнгөлөлттэй зээл олгодог. Тус хөтөлбөрт хамрагдсан ЖДҮ эрхлэгчид өөрсдийн амжилтын түүхээ тайландаа хуваалцжээ. Нутгийн иргэдтэй хамтран мод, ногоо тарих "Ойн шугам", "Сайн хөрш", "Бэлчээрийн усан хангамж" зэрэг хөтөлбөрүүд, компанийн хандив тусламжийн талаар онцолжээ. | Тус цахим хуудасны "Мэдээ" буланг ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарсан, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдсэн зэрэг видео бичлэг, инфографик, компанийн үйл ажиллагааны мэдээ мэдээллээр байнга шинэчилж байдаг.<br>Тухайлбал, 2022 оны 10-р сард Цогт-Овоо, Хан-Хонгор, Цогтцэций сумдад "Хариуцлагатай уул уурхайд иргэдийн оролцоо" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн 700 гаруй иргэнийг хамруулсан талаар мэдээ гаргажээ. Оролцогчдод байгаль орчны менежмент, орон нутагт нийгмийн хөрөнгө оруулалт хийх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөхөөс гадна судалгаа явуулж, нээлттэй ажлын байранд сонгон шалгаруулалт хийж, санал гомдлын маягтуудыг цуглуулсан байна. Оролцогчдын санал бодол, санал хүсэлтийг мэдээнд мөн тусгажээ. |

## Хавсралт 6 Судалгааны дүн шинжилгээний загвар

| Гол сэдэв | Судалгааны асуултууд | Дүн шинжилгээний гол агуулга | Мэдээлэл цуглуулах аргачлал | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| Олон нийтийн оролцоог хангах, мэдээлэл түгээх, орон нутагтай хамтран ажиллах хүчин чармайлтуудын үр дүн | Олборлох үйлдвэрлэлийн салбарт олон нийтийн оролцоог хангах ямар арга замуудыг хэрэгжүүлж байна вэ? Аль арга замууд нь үр дүнтэй байв? Яагаад? Үр дүнгүй байсан бол ямар сургамж үлдсэн бэ (Монголд болон олон улсад)? | Иргэдийн оролцооны түвшин<br>Мэдээлэл харилцааны хэлбэрүүд<br>Тараах материалуудын зорилго<br>Иргэдийн оролцооны сайн туршлага, сургамж, нөлөөлөх хүчин зүйлс, үйл явц<br>Мэдээллийн хүртээмж<br>Санаатайгаар тараасан ташаа мэдээлэл (түүний нөлөө)<br>Орон нутгийн нөхцөл байдал<br>Хэвлэл мэдээлэл, ТББ, мэргэжлийн холбоод, төрийн үүрэг оролцоо<br>Олон нийтийн оролцоог хангаагүйгээс үүсэх эрсдэл | Баримт бичгийн шинжилгээ<br>Ярилцлага<br>Иргэдийн хэлэлцүүлэг<br>Ажиглалт | Мэдээллийн сан:<br>Web of science (2018-2022)<br>Scopus (2018-2022)<br><br>Байгууллагуудын хийсэн ажил ба судалгааны тайлан, гарын авлагууд: ЗГ-ын тайлан, олон улсын байгууллагаас гаргасан материал (WB, IFC, UNDP, ADB, MERIT, Adam Smith Int'l, г.м.) (2018-2022)<br><br>Уул уурхай дахь иргэдийн оролцоотой холбоотой монгол хэл дээрх материалууд (цахим хуудас, товхимол, тараах материал, бичлэг, г.м.) (2018-2022) |
| Уул уурхайн талаарх иргэдийн ойлголт хандлага | Олон нийт уул уурхайн талаар ямар ойлголт хандлагатай байна вэ? Олон нийтийн ойлголт хандлага сүүлийн 5 жилд хэрхэн өөрчлөгдөж ирсэн бэ? | Иргэдийн санаа бодолд нөлөөлөх хүчин зүйлс, үйл явц<br>ТББ, төр, хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо | Баримт бичгийн шинжилгээ<br>Ярилцлага<br>Иргэдийн хэлэлцүүлэг | |
| Олон нийтийн оролцооны талаарх ойлголт | Оролцогч талууд олон нийтийн оролцоог хэрхэн ойлгож хүлээн авдаг? Орон нутагт ямар хүлээлттэй байдаг? | Иргэдийн оролцоо<br>Компани, иргэдийн харилцаа | Ярилцлага | Судалгаанд оролцогчид |
| Эрсдэл ба боломж | Уул уурхайн салбарт олон нийтийн оролцоог хангахад ямар саад бэрхшээл, эрсдэл тулгардаг? Сайжруулах ямар болом байна вэ? | Оролцогчдын тодорхойлсон саад, эрсдэл, боломж | Ярилцлага<br>Иргэдийн хэлэлцүүлэг | Судалгаанд оролцогчид |
| Үр дүнтэй мэдээлэл харилцааны арга замууд | Мэдээлэл түгээх, авах /хоёр талт мэдээллийн урсгал/ хамгийн үр дүнтэй ямар арга хэрэгслүүд байна вэ? | Өмнө нь хэрэгжсэн болон одоо хэрэгжиж буй тараах материал, гарын авлагуудын зорилго, үр дүн | Ярилцлага<br>Иргэдийн хэлэлцүүлэг<br>Ажиглалт | Судалгаанд оролцогчид |

# Ашигласан материалуудын жагсаалт


1. Altanchimeg Zanabazar, B. B. (2019). The Indonesian Journal of the Social Sciences. *The Indonesian Journal of the Social Science*, *10*(3).

   https://journal.scadindependent.org/index.php/jipeuradeun/article/view/409

2. Asia Forum (2019). Fact Finding Mission Report on the impacts of mining on defenders and environment in Khentii and Dornod provinces of Mongolia.

   https://www.forum-asia.org/uploads/wp/2019/10/FFM-Mongolia-2019-Report.pdf

3. Asia Foundation (2016). Frugal Rehabilitation Methodology, Field Handbook,

   https://asiafoundation.org/wp-content/uploads/2016/04/Frugal-rehabilitation-methodology-FRM-eng.pdf

4. Asia Foundation (2016). Frugal rehabilitation demonstration in Mongolia

   https://asmhub.mn/uploads/files/cases-studies-encompressed.pdf

5. Batdelger, T., Tuvshintugs, D., Usny-Ekh, E., Bayartsogt, K.-E., Zagdbazar, M., Davaakhuu, O., Tserendorj, O., & Davaa, U. (2022). *Impact of Mining on Local Livelihood and Social Licensing in Mongolia*. Springer Nature Singapore.

   https://doi.org/10.1007/978-981-19-5515-0_6

6. Chawa, A. F, & Grace, M. (2019). Demystifying Power in Community Development Practice. *International Journal of Asia Pacific Studies*, 15(1), 153-181. https://ijaps.usm.my/?page_id=4449

7. Canada's Minerals and Metals Sector (2016). Good community engagement practices. https://natural-resources.canada.ca/sites/nrcan/files/mineralsmetals/files/pdf/rmd-rrm/GoodPractices2ed_En.pdf

8. Chimedlkham, E. (2019). Community Perception of Cooperation Agreement. In *University of Alberta*.

   https://era.library.ualberta.ca/items/f105ed2f-2837-4c48-8bad-986f5fb13a35

9. Dagvadorj, L., Byamba, B., & Ishikawa, M. (2018). Effect of local community's environmental perception on trust in a mining company: A case study in Mongolia. *Sustainability (Switzerland)*, *10*(3), 1–12. https://doi.org/10.3390/su10030614

10. Dalaibuyan, B. (2022). Negotiating the coexistence of mining and pastoralism in Mongolia. *Journal of Contemporary East Asia Studies*, *11*(1), 46–63. https://doi.org/10.1080/24761028.2021.2021356

11. Daley et al (2018).Gender, Land and Mining in Mongolia. http://mokoro.co.uk/wp-content/uploads/Gender_Land_and_Mining_in_Mongolia_WOLTS_Research_Report_No.1_January_2018-1.pdf

12. Davis, R., & Franks, D. M. D. (2011). The costs of conflict with local communities in the extractive industry. *First International Seminar on Social Responsibility in Mining*, 19–21. https://www.csrm.uq.edu.au/Portals/0/11srm_cap06_p88.pdf

13. Environmental Performance Index, 2022

    https://epi.yale.edu/epi-results/2022/component/epi

14. Fraser, J., & Kunz, N. C. (2018). *Water Stewardship : Attributes of Collaborative Partnerships between Mining Companies and Communities*.

    https://doi.org/10.3390/w10081081

15. Hosoi, Y., Batdelger, T., & Chuluundorj, K. (2022). Economic Dependence of Mongolia on Minerals.

    https://link.springer.com/book/10.1007/978-981-19-5515-0

16. IFC (2021). Endline public perception survey. Mining, Communities & water management project.

17. International Republican Institute (IRI) and IRIM (2022).Public opinion poll: Residents of Mongolia.

https://www.iri.org/wp-content/uploads/2022/08/Eng-Public-Opinion-Poll-Final-PUBLIC.pdf

18. Independent Reporting Mechanism (IRM): Mongolia Transitional Results (2019-2021)

https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2022/02/Mongolia_Transitional-Results-Report_2019-2021_EN.pdf

19. IGF Case study: The importance of Consultation and Engagement in Environmental and Social Impact Assessments, 2023

https://www.iisd.org/system/files/2023-01/igf-case-study-environmental-social-impact-assessments.pdf

20. IGF: Mongolia Mining Policy Framework Assessment Report 2017

https://www.iisd.org/system/files/publications/mongolia-mining-policy-framework-assessment-en.pdf

21. Impact of Coronavirus disease (COVID-19) on Mongolian Mining Sector, presentation of survey findings, 2022

http://www.eri.mn/download/2022/en/01.%20ERI%20COVID%20impact_EN.pdf

22. Kilajian, A. & Chareonsudjai, P. (2021). Conflict resolution and community engagement in post-audit EIA environmental management: Lessons learned from a mining community in Thailand. *Environmental Challenges.* 8, 100253. https://www.sciencedirect.com/science/article/pii/S2667010021002328

23. Kot-Niewiadomska, A., Simić, V., Tost, M., & Wårell, L. (2022). Public participation as an element of a mineral deposit safeguarding system – international experiences. *Gospodarka Surowcami Mineralnymi / Mineral Resources Management*, *38*(4), 5–28. https://doi.org/10.24425/gsm.2022.143626

24. KPMG. (2021). Risks and opportunities for mining. In *Kpmg*.

https://kpmg.com/xx/en/home/insights/2021/02/risks-and-opportunities-for-mining.html

25. Malone, A., Smith, N.M., & Zeballos, E.Z. (2021). Coexistence and Conflict between artisanal mining, fishing adn farming in a Peruvian boomtoon. *Geoforum.* 120, 142-154. https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0016718521000208

26. Matikainen, L. S. (2022). Addressing Sustainability in the Mining Industry Through Stakeholder Engagement. *South Asian Journal of Business and Management Cases*, *11*(1), 35–48. https://doi.org/10.1177/22779779221078673

27. Mercer-Mapstone, L.D., Rifkin, W., Moffat, K. & Louis, W. (2018). What Makes Stakeholder Engagement in Social Licence “meaningful”? Practitioners’ conceptualisations of dialogue. *Rural Society.* 27(1), 1-17

https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/10371656.2018.1446301?journalCode=rrso20

28. Mijiddorj Purevsuren (2019). The mining melodrama, case of Gurvantes. *The Impact of Mining Lifecycles in Mongolia and Kyrgyzstan*.

29. Mutti, D., Yakovleva, N., Vazquez-Brust, D., & Di Marco, M. H. (2012). Corporate social responsibility in the mining industry: Perspectives from stakeholder groups in Argentina. *Resources Policy*, *37*(2), 212–222. https://doi.org/10.1016/j.resourpol.2011.05.001

30. Myadar, O., & Jackson, S. (2019). Contradictions of Populism and Resource Extraction: Examining the Intersection of Resource Nationalism and Accumulation by Dispossession in Mongolia. *Annals of the American Association of Geographers*, *109*(2), 361–370. https://doi.org/10.1080/24694452.2018.1500233

31. Natural Resources Governance Institute (2021). Resource Governance Index Mongolia.

https://resourcegovernance.org/analysis-tools/publications/2021-resource-governance-index-

mongolia-mining

32. Pareja, C., Honey-Roses, J., Kunz, N. C., Fraser, J., & Xavier, A. (2018). What Participation? Distinguishing Water Monitoring Programs in Mining Regions based on Community Participation. *Water Stewardship in Mining Regions.* 10(10), 1010-1325.

https://www.mdpi.com/2073-4441/10/10/1325

33. Poscente, M., Choijinzav, T., & Chultemgombo, B. (2022). Mine closure plan for the Salkhit silver mine in Mongolia. *Proceedings of the International Conference on Mine Closure*, *1*, 209–224. https://doi.org/10.36487/ACG_repo/2215_12

34. Provincial Competitiveness Report, 2022. http://aimagindex.mn/

35. Prno, J., Pickard, M., & Kaiyogana, J. (2021). Community Engagement during the Environmental Assessment of a Mining Project in the Canadian Arctic. *Environ Manage.* 67(5), 1000-1015. https://pubmed.ncbi.nlm.nih.gov/33528623/

36. Responsible Mining Index report, 2020. https://2020.responsibleminingindex.org/en

37. Seloa, P., & Ngole-Jeme, V. (2022). Community Perceptions on Environmental and Social Impacts of Mining in Limpopo South Africa and the Implications of Corporate Social Responsibility. *Journal of Integrative Environmental Sciences,*19(1), 189-207.

https://www.tandfonline.com/doi/full/10.1080/1943815X.2022.2131827

38. Serfontein-Jordaan, M., & Dlungwane, S. (2022). Achieving Sustainable Corporate Social Responsibility Outcomes: a Multiple Case Study in the South African Mining Industry. *Communitas*, *27*, 1–20. https://doi.org/10.18820/24150525/Comm.v27.1

39. Sternberg, Toktomushev, Ichinkhorloo, B. (n.d.). *The Impact of Mining Lifecycles in Mongolia and Kyrgyzstan*.

https://www.routledge.com/The-Impact-of-Mining-Lifecycles-in-Mongolia-and-Kyrgyzstan-Political-Social/Sternberg-Toktomushev-Ichinkhorloo/p/book/9780367563394

40. Sternberg, T., Mayaud, J. R., & Ahearn, A. (2022). Herd It in the Gobi: Deserting Pastoralism? *Land*, *11*(6). https://doi.org/10.3390/land11060799

41. Sustainability outlook of Mongolia, 2018.

https://www.unescap.org/resources/sustainability-outlook-mongolia

42. Sustainable Minerals Institute, Brisbane. Responsible mining in Mongolia: Enhancing Positive Engagement, 2015. https://www.csrm.uq.edu.au/media/docs/1171/j003551-csrm-report-conceptweb-mr.pdf

43. van der Watt, P., & Marais, L. (2021). Implementing social and labour plans in South Africa: Reflections on collaborative planning in the mining industry. *Resources Policy*, *71*(January), 101984. https://doi.org/10.1016/j.resourpol.2021.101984

44. UNDP (2021). Human Rights Due Diligence Training Facilitation guide.

https://www.undp.org/mongolia/publications/hrdd-training-facilitation-guide

45. UNDP (2021). Participatory Environmental Monitoring guide. Step without border (SWB)

46. UNDP (2019). Training Manual on Responsible Mining.

https://www.undp.org/mongolia/publications/training-manual-responsible-mining

47. WWF(2016). Assessment report on the knowledge, attitudes and practices of stakeholders involved in mining decision-making.
https://dcgfgwahwg1cz.cloudfront.net/downloads/kap_report_mon_4.pdf

**Adam Smith International Mongolia LLC**
2A Temple View Residence, Suhbaatar District – 1
Ulaanbaatar 15160, Mongolia
/AMEP2
info@amep.mn
www.amep.mn
976-7000 8595